1.Их Британи, Нидерланд, Герман, Эстони, Казахстан зэрэг улсуудад бизнесийн цар хүрээ, салбарын онцлогоос хамаарч, эрсдэлийн түвшин багатай үйл ажиллагааг мэдэгдлээр эрхэлдэг олон улсын жишигт нийцүүлэн нийт 30 гаруй төрлийн үйл ажиллагааг буюу хүнсний зах, дэлгүүр, ресторан, цайны газар, кофе шоп, үсчин, гоо засал, хими цэвэрлэгээ, бялдаржуулах төв, спиннинг, цанын баазын үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэн дээр бус, төрийн байгууллагын шийдвэр хүлээлгүйгээр зөвхөн төрийн байгууллагад мэдэгдэл хүргүүлээд эрхэлдэг байхаар тусгалаа. Мөн аймаг, нийслэл, дүүрэгт Зөвшөөрлийн хуульд заагаагүй ч зөвшөөрөл шиг бичиг баримт шаарддаг байсан хувцас захиалга, засвар, гутал засвар, нүдний шил захиалга, засвар, цаг засвар, гэрэл зургийн үйлчилгээ, биллиард, машин угаалга зэрэг үйлчилгээнүүдийг шууд эрхлэх нөхцөлийг хуулиар бүрдүүллээ.

2.Зөвшөөрөл олгоход 20-оос 30 төрлийн шаардлагатайг тогтоож, зөвшөөрөл олгох процессыг хүндрүүлж байгаа нөхцөлийг өөрчилж, зөвшөөрөл олголтын болон зөвшөөрөл авчихсаны дараах зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл шаардлагыг ялгамжтай тогтоож, олон төрлийн баримт бичиг шаардагддаг байдлыг багасгаж, зөвшөөрөл олголт, явцын хяналтын тэнцвэртэй тогтолцоог бүрдүүлэхээр тусгалаа.

3.Зарим салбарт нэг төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл авахад 3-аас 4 жил зарцуулдаг байдлыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн тухайлбал барилгын салбарт 16 давхар барилгын ажил эрхлэх нэг төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд 3 төрлийн тусгай зөвшөөрөл авч, 3-аас 4 жил зарцуулдаг байдлыг бүрэн халж, нэг төрлийн зөвшөөрөл авч, Зөвшөөрлийн хуульд заасан 22 өдөрт олгохоор тусгалаа.

4.Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг 20 хоногт магадлан шалгах ажиллагааг хийж, сунгадаг нөхцөлийг хялбаршуулж, зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчөөгүй болох нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд ажлын 2 өдөрт шууд сунгах талаар зохицуулж, зөвшөөрлийн тогтолцоо, хяналтын тогтолцоог уялдуулан аж ахуйн нэгжид учруулах дарамтыг багасган хуульд тусгалаа.

5.Энгийн 120 зөвшөөрөл олгох, 30 мэдэгдэл бүртгэх эрхийг салбарын мэргэжлийн нэгдсэн холбоогоор дамжуулан гүйцэтгүүлж, төрийн чиг үүргийг шилжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхээр тусгалаа.

6.Тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгож байгааг 10 жилээр, энгийн зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгож байсныг 5 жил болгон нэмэгдүүлж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн тогтвортой байдлыг хангаж, зөвшөөрлийг сунгахтай холбоотой дарамтыг багасгаж өглөө.

7.Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх нийт 32 төрлийн үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлд шилжүүлэхээр тусгаж, эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд энгийн зөвшөөрөл хүссэн өргөдлийн хариуг хэрвээ өгөөгүй бол 30 хоногийн дараа зөвшөөрөл олгосонд шууд тооцох боломжтой болголоо.

8.Мөн 20 гаруй тусгай болон энгийн зөвшөөрлийг хүчингүй болгохоор тусгаж, тухайн аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж, зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой дарамт багасаж, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих нөхцөлийг бүрдүүлээ.

9.Зөвшөөрлийн талаар шийдвэр гаргах тогтолцоог ЗГХЭГ-ын дэргэдээс улсын эдийн засаг, бизнесийн орчны асуудал эрхэлсэн мэргэжлийн яам болох Эдийн засгийн хөгжлийн яаманд тусгахаар шилжүүлэхээр тусгалаа.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын дарга, хуулийн төслийн санаачлагч Учрал, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Ганхуяг, Монгол Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Хууль санаачлагч 3 гишүүн ирсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү, Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД, Тэнгис Улсын Их Хурлын даргын засаглал хариуцсан зөвлөх, Золбоо Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга, Дөлгөөн СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, Мөнх-Оргил СЗХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газар, Төв банкны эрх зүйн газрын захирал, Хандсүрэн Монголбанкны Зөвшөөрлийн албаны дарга, Батзориг Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Номинбилиг Эрчим хүчний зохицуулах хорооны Тусгай зөвшөөрлийн газрын дарга, Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Санчигдорж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Туяа Зам, тээврийн яамны Иргэний нисэхийн бодлогын зохицуулалтын газрын дарга, Мяндасмаа Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Батзориг Хот, байгуулалт барилга, орон сууцжуулалтын яамны Барилгын материал, үйлдвэрлэл хэлтсийн дарга, Сүхбат Хот, байгуулалт орон сууцжуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга, Оргил Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Лувсан-Очир Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Нямдулам Харилцаа, холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга, Батцоож Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, Золзаяа Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын

Зөвшөөрлийн нэгдсэн сангийн хөгжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Мөнхнаран Харилцаа, холбооны зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Баярмаа Боловсролын яамны Тусгай зөвшөөрлийн газрын Хуулийн хэлтсийн ахлах шинжээч, Базаррагчаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Гадаад эмчилгээг зохицуулах албаны мэргэжилтэн, Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч, Баярзаяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тусламж, үйлчилгээний Чанар, магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн, Жаргал Нийслэлийн эрүүл мэндийн газрын Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, Бямбаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье? Соронзонболд, Ганхуяг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг.

Х.Ганхуяг: Энэ үндсэндээ яагаад энэ хуулийг гишүүд болон дарга өргөн барих болсон үндсэн шалтгаан юу вэ гэхээр 2022 онд Зөвшөөрлийн хууль батлагдсан байдаг. Анх 2002 онд энэ чинь Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хууль гэж байсан юм. Тэгээд 24 жил, 20 жилийн дараагаар энэ хууль нь шинэчилсэн найруулга ороод, 1600 гаруй зөвшөөрөл, тэгээд тэр нь зөвшөөрөл, бүртгэл ингээд л аягүй олон нэртэй байсан. Тэгээд 1600 гаруй зөвшөөрлийг 362 зөвшөөрөл болгож бууруулаад, тэгээд 22 оноос хойш үндсэндээ Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг 3 удаа шалгалт хийж, хууль, хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор шалгалт хийсэн юм.

Тэгээд асуудлууд нь ямар асуудлууд гарсан бэ гэхээр сүүлдээ нөгөө зөвшөөрөл гэдэг нэрээс татгалзаад, бүртгэл, дүгнэлт, баталгаажуулалт, гэрчилгээ, магадлан итгэмжлэл, сертификат гэдэг нэртэй байдлаар зөвшөөрлүүд олгогдож эхэлсэн. Тэгээд 362 зөвшөөрөл маань явсаар байгаад 800 гаруй болчихсон байгаа өнөөдрийн байдлаар. Жишээлбэл журмаар 265 бүртгэл олгогдоод явж байгаа журмаар. Дүгнэлтээр 232 дүгнэлт гарч байна өнөөдрийн байдлаар. Баталгаажуулалт гээд 72 төрлийн баталгаажуулалт хийгдээд явж байгаа. Гэрчилгээ гээд 132 төрлийн гэрчилгээ олгогдоод явж байна. Магадлан итгэмжлэл гээд 30 магадлан итгэмжлэл явж байгаа юм. Сертификат гээд 9 төрлийн сертификат явж байгаа юм. Тэгэхээр эд нарыгаа бүгдийг нь цэгцэлье, цаашдаа ер нь бүртгэл гэдгийг юу гэж ойлгох вэ, мэдэгдэл гэдгийг юу гэж ойлгох вэ гэдэг байдлаар энэ хуулийн шинэ нэмэлт өөрчлөлт нь тэрийг нэлээн цэгцлэх үүднээс орж ирсэн байгаа юм.

Мэдэгдэл гэдэг маань үндсэндээ ямар нэгэн зөвшөөрөл авахгүйгээр, ажлын байрны дүгнэлт авахгүйгээр эрх бүхий байгууллагадаа энэ үйл ажиллагааг эрхэллээ шүү гээд л мэдэгдээд л болно. Тэгээд үйл ажиллагаагаа эрхлээд эхэлнэ. Гагцхүү ямар шаардлага тавигдах вэ гэхээр эхэлснээс хойш тэр шаардагддаг шалгуур үзүүлэлтүүдээ бүгдийг нь хангаж ажиллах ёстой гэж байгаа юм. Нөгөө стандартын шаардлагуудаа хангаад явна шүү гэдэг нөхцөлтэй гээд. Эрх бүхий байгууллага нь мэдээж хэрэг очих шалгах эрх нь байна. Тэр нөгөө шалгууруудаа хангаагүй байвал үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх эрх нь байна. Тэгэхээр нөгөө аль, аль талдаа хариуцлагатай болох ёстой болчихож байгаа юм. Нөгөө иргэн, аж ахуйн нэгжийн тэр шалгуур, шаардлагуудаа хангаад явах ёстой болно. Нөгөө талдаа шууд бизнесээ эхлүүлээд явах боломжтой болно. Яах вэ энүүгээр үндсэндээ жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарт нэлээн нурууг нь тэнийлгэсэн ийм хууль болно гэсэн үг. Баярлалаа. Тэгээд асуулт гарвал нэмээд хариулъя.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Өглөөний мэнд бүгдэд нь хүргэе. Энэ Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг ерөнхий энэ утга агуулгынхаа хувьд дэмжиж байна. Энэ дээр нэг ийм асуулт байна. Жишээлбэл яг тухайн газар зүйн байршил, сум нэгж дээрээ жишээлбэл тухайн зах зээл дээр ийм монопол болчихсон ингээд байгууллагууд байгаад байдаг. Тэгэхээр тийм байгууллагуудад нэмэлт зөвшөөрөл өгөөд байх уу? Өөрөөр хэлбэл өрсөлдөөнийг зохицуулах талаасаа энэ хуулийн төсөл дээр бодож, тусгасан зүйлс байгаа юу гэж нэг ийм асуулт байгаад байна.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Ер нь тусгай зөвшөөрөл гэдэг маань өөрөө яг ямар үйл ажиллагаа дээр тусгай зөвшөөрөл олгох уу гэдэг жишээлбэл зөвшөөрөлтэй байх уу гэдэг бол энэ Зөвшөөрлийн хуульд орсон байгаа юм. Тэр нь төрийн нийтийн өмчийг ашиглах байдаг юм уу, жишээлбэл үндэсний аюулгүй байдалтай холбоотой байдаг юм уу, эрүүл мэндтэй холбоотой юм уу, орчны бохирдолтой холбоотой байдаг юм уу, хүнсний эрүүл мэндтэй холбоотой байдаг юм уу яг энэ харилцаан дээр л зөвшөөрлийн харилцаа байна шүү гэдгийг энэ Зөвшөөрлийн хуулиар зохицуулж өгсөн юм. Тэрнээс биш бусад зүйл дээр зөвшөөрөл хэрэггүй. Зөвхөн стандартынхаа шаардлага хангаад л үйл ажиллагаа явуул, бизнесээ чөлөөтэй эрхэл гэдэг ийм хууль юм.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор энэ саяын яригдаж байгаа тэр салбарууд дээр монопол бизнесийн үйл ажиллагаа бий болчихсон байсан. Тухайлбал харилцаа холбоо дээр ч гэдэг юм уу, нөгөө санхүүгийн чиглэл ч гэдэг юм уу, тэгээд энэ асуудлуудыг тэр зөвшөөрлийн, энэ яагаад Зөвшөөрлийн хууль гэж гарч ирэх болсон бэ гэхээр шалтгаан нь би түрүүн бас танд дурдсанчлан 1 дүгээрт ийм төрлийн зөвшөөрөл байна гээд жагсаалтыг нь оруулчхаж байгаа юм. Хэн олохыг нь оруулчхаж байгаа юм. Тэгээд дээрээс нь зөвшөөрлөө ямар нэгэн байдлаар хүнд суртал бий болгохгүйн тулд процессжуулсан юм. Нэг ёсондоо бүгдээрээ яг л нэг процессоор явна. Тэгээд зөвшөөрөл олгох хугацааг нь хатуу оноогоод өгчхөж байгаа юм. Яг 22 ажлын өдөр дотор тусгай зөвшөөрлийг олгоно гээд. Энэ дээр хэн нэгэнд хууль өөрөөр үйлчлэх боломжгүй байдлаар олоод өгчхөж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ бол өөрөө эргээд монополыг задлах ийм хууль гэсэн үг. Харилцаа холбоо ч байдаг юм уу эд нараас бол ингээд зөвшөөрлийг шалгуур үзүүлэлтүүдийг нь нэлээн өндөр болгох ийм хүсэлтүүд байнга тавигддаг. Тэрийг нь одоо аль болох хамгийн бага байдлаар шалгууруудыг нь энэ салбар хуулиуд дээр нь оруулж өгч тавих ёстой байдаг. Яагаад гэхээр Зөвшөөрлийн хууль гэдэг маань бүх зөвшөөрлийн харилцааг зохицуулахгүй. Энэ чинь 160 гаруй хууль зөвшөөрлийн харилцааг зохицуулж байдаг юм салбарын хуулиуд дээр. Тэгэхээр яг тэр салбар хууль дээр нь монопол бий болгохгүй байх тэр эрх зүйн зохицуулалтыг нь салбарын хууль дээр хийж өгөх ёстой байдаг. Бид бол яг тэр салбар хуулиудыг нь аль болох хөндөөд оруулж ирээд, тэр монополын харилцаатай асуудлыг нь бүгдийг нь хөндөөд ороод ирчихсэн байгаа. Тэгэхээр яг энэ дээр ажлын хэсэг маань нүдлэн хамгаалж, энэ Зөвшөөрлийн хуулиа хамгаалж батлуулах дээрээ ажиллах ёстой гэсэн үг.

Р.Сэддорж: Соронзонболд гишүүн тодруулж асууна. Алдаржавхлан гишүүнийг нэмье.

Л.Соронзонболд: Тэгэхээр зохицуулагч байгууллагууд болохоор хууль дээр байгаа зөвшөөрлийг өөр цаад талд нь ингээд задлаад, тэгээд нэмэлт ингээд зөвшөөрлийн журам байдлаар ингээд их зохицуулсан байдал харагдаад байдаг л даа. Тэгэхээр одоо энэ Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноороо тухайн зохицуулагч байгууллагуудын одоо ингээд хүчинтэй ажиллаж байгаа тэр зөвшөөрөл олгоод байгаа журам зааврууд бүгд хүчингүй болно гэж ойлгох уу?

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Энэ дээр яг жишээлбэл 2023 онд ажлын хэсэг ажиллаж байхад 2023 оны 12 сарын, 12 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 20 гаруй байгууллага зөвшөөрлийг үндэслэлгүй нэмсэн байгаа юм. Үндэслэлгүй, ерөөсөө ямар нэгэн, зөвшөөрөл уг нь нэмнэ гэдэг маань нөгөө Зөвшөөрлийн зөвлөлөөр орох ёстой байдаг юм. Зөвшөөрлийн зөвлөл гээд Ерөнхий сайдын дэргэд зөвлөл байдаг. Түүний 2/3 нь хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодоос бүрддэг байхгүй юу. Тэгээд тэр Зөвшөөрлийн зөвлөлөөр орж байж л зөвшөөрлийг эргээгээд Засгийн газраас өргөн бариад, Улсын Их Хурал баталсны үндсэн дээр, хуульд нэмэлт, өөрчлөлт орсны үндсэн дээр зөвшөөрөл нэмэгдүүлэхээр хуульд заасан байгаа. Гэтэл ямар асуудал үүссэн бэ гэхээр 2023 он гэхэд 20 гаруй байгууллага зөвшөөрлийг үндэслэлгүйгээр нэмсэн байдаг. Тэгээд тэрийгээ бүртгэл, баталгаажуулалт, гэрээ байгуулах гэх мэтчилэн нэр оруулсан байдлаар 200 гаруй зөвшөөрлийг зөвшөөрөлтэй болгочихсон байдаг. Шинээр бий болгочихсон байдаг. Тэрийг хязгаарлаж байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Очирбат асуулт асууна.

Г.Очирбат: Өглөөний мэнд. Энэ хуулийн төслийг ерөнхийдөө дэмжиж байгаа. Ялангуяа энэ аж ахуйн нэгжүүд, бизнес эрхэлж байгаа хүмүүст нэлээн тийм дэм болох юм болов уу гэж харж байгаа. Тэгээд энэ хуулиар 381 зөвшөөрлийг олгож байна гэж байгаа. Мөн дээрээс нь нэр дурдсан зөвшөөрлөөс 251 зөвшөөрөл буюу 100 зөвшөөрлийн 122 нь захиргааны хэм хэмжээний акт журмаар зохицуулж байна гээд. Бид энэчээнээс хууль батлаад өгөөд байдаг. Яг очиж хэрэгжихдээ нөгөө Соронзонболд гишүүн түрүүн хэлээд байна журмаар зохицуулж яваад байдаг. Тэгэхээр манай энэ төрийн албаныхан энд ирсэн байна. Яг энэ хууль хэрэгжихэд ер нь бэлэн үү? Ганхуяг гишүүн түрүүн ярьж л байна. Стандартын тухай хууль орж ирж байсан. Яг энэ салбар, салбар дээрээ очоод тэр стандартууд яг өнөөдрийн түвшинд олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлж чадаад, зөвхөн бүртгэл, мэдэгдлээ өгөөд, тэгээд очоод үйл ажиллагаа явуулахад тэр стандартууд бэлэн байгаа юу, хэрэгжихэд бэлэн үү гэдэг эхний асуулт байгаад байна 1-д?

2-т гэвэл мэдээж энэ аж ахуйн нэгжүүдээ дэмжиж байгаа нэг талаасаа төр ингээд хууль боловсруулаад байдаг. Нөгөө талаасаа энэ төрийг хэт данхайлгаад байдаг. Их Хурлын дарга Учрал орж ирээд суусан байна. Тэгээд Ардчилсан намын бүлгээс яригдаж байгаа энэ дэд сайд нарын асуудал, бүхэл бүтэн өчнөөн олон жил зүгээр яваад ирсэн. Тэгээд Монгол Ардын намын их хурлын гишүүд нь ч мэдээгүй байхад ингээд баахан сайд нарыг томилж оруулж ирээд, 2026 оны төсөв дээр хүртэл дэд сайд гэсэн орон тоо байхгүй, төсөв байхгүй байгаа шүү дээ. Тэгэхэд ингэж хүчээр оруулж ирдэг. Тэгээд 1 гараараа ингээд бизнесийг чөлөөлөх гээд байгаа юм шиг, нөгөө гараараа энэ төрийг буцаагаад томруулаад байгаа энэ дээр Их Хурлын

дарга орж ирчихсэн байгаа дээр нэг асуулт асуучихъя. Ингээд 2 асуулт асууя. Тэгээд тодруулга авъя.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга Учрал.

Н.Учрал: Энэ Зөвшөөрлийн хууль тухайн үед ажлын хэсгийг нь Ганхуяг гишүүн ахлаад, 381 зөвшөөрөл болгосон. Үүний дараа бид энэ Зөвшөөрлийн хуулийг шинэчилж гээд би нэг жилийн дараа Ганхуяг гишүүний ажлын хэсэгтэй хамтарч ажилласан. Тухайн үед би Хэрэг эрхлэхийн дарга байлаа. Нэг ёсондоо Зөвшөөрлийн зөвлөлийг ахалж байсан. Ингээд Зөвшөөрлийн зөвлөлийг ахалж байхдаа яагаад хуульд нөгөө журмаар зөвшөөрөл олгож болохгүй, шинэ дүрэм гаргаж болохгүй, шинэ бүртгэл, гэрчилгээ, сертификат, магадлан итгэмжлэл нэртэй янз бүрийн дарамт шахалт хувийн хэвшилд үзүүлж болохгүй гээд заачихсан байхад яагаад журам гаргаж зохицуулсан юм бэ гэдэг шаардлагыг Зөвшөөрлийн зөвлөл дээр тавьсан. Зөвшөөрлийн зөвлөл дээр шинэ зөвшөөрөл олгохдоо дүгнэлт авдаг байсан чинь аваагүйгээр дураараа 20 гаруй зөвшөөрлийг нэмчихсэн тэр цаг үеэс хойш.

Тэгээд ингээд Зөвшөөрлийн зөвлөл дээр бид энийг яриад, энэ хууль давсан журам байж болохгүй гээд 51 журам цуцалсан, манай төрийн байгууллагынхан байна. Одоо энэ хууль гарвал бараг 104 журам дахиад цуцална шүү дээ. Тэгээд Засгийн газрын гишүүн энэ хуулийг барьж орж ирж ерөөсөө болохгүй юм байна лээ. Энэ салбаруудын эрх ашиг хөндөгдөөд ерөөсөө их зовлонтой. Тэр хаана нэгэн газар аваачиж гацаадаг, эрх мэдэлд хайртай хүмүүс олон. Тийм учраас би Их Хурлын даргаар томилогдоод, Их Хурлын гишүүнийхээ хувиар энэ хуулийг барьж байгаа. Ингээд хүнд суртлаас чөлөөлж гээд явж байна. Тэгэхгүй бол ингээд нэг салбарын эрх ашиг яригдаад байдаг байхгүй юу энэний ард.

Тийм учраас сая AI дээр шинжилгээ хийлээ. 228 эдийн засгийн эрх чөлөөг зөрчиж байгаа хуулиуд байна шүү. Бүүр 120 гаруй хүний эрх, эрх чөлөөнд халтай бүүр хууль гээд ингээд олон хуулийн зөрчил байна. Энийг шийдэхгүйгээр зах зээл дэх төрийн оролцоо буурахгүй. Дээрээс нь иргэд өөрөө бизнес эрхлээд амьдрал ахуйгаа аваад явах бололцоо үүсэхгүй. Өнөөдөр энэ гомдол саналууд энэ зөвшөөрөлтэй холбоотой саналууд бүүр хэрээс хэтэрч байгаа шүү дээ. Тэгэхээр үүн дээр анхааръя гэдэг зорилгоор энэ хуулийг ингээд оруулж ирсэн юм гэдгийг та бүхэнд хэлжэе.

Тэгээд ер нь яах вэ тэгээд хүнд суртлаас чөлөөлж, эдийн засгийн эрх чөлөөний төлөө зах зээл дэх төрийн оролцоог бууруулъя, ер нь Монгол хүн нэг их том тус бид хүргэж чаддаггүй юм гэхэд гай тотгор бага учруулъя. Олон юм ярихаа л больё. Ер нь ард түмнийг амар амгалан, сайн сайхан амьдруулахын тулд зарим зүйлээс татгалзаж суръя. Бүх юм мэддэгээ больё л гээд байгаа юм. Тийм. Гүйцэтгэх засаглалыг шахна, шаардана, ажлаа хий, тэгээд хэдэн хүнтэй, яаж ажиллахыг нь тэр дотоодын асуудал. 2,2 их наяд хэмнэсэн, 9 хувь хэмнэсэн нь үнэн. Тэгээд одоо ажлаа хийх хэрэгтэй, тэгээд л ингээд шахаад шаардаад ажиллана. 1 минут авчихъя.

Р.Сэддорж: Учрал дарга 1 минут.

Н.Учрал: Шахаад шаардаад ажиллана. Түүхэнд анх удаа 9 хувийн хэмнэлт бүх түвшинд хийсэн Засгийн газар мөн л дөө. Тэгээд тэр нэг ингээд байгаа юм зөвшөөрлийг мэдэгдэл, гэрчилгээ, сертификат, магадлан итгэмжлэл гээд янз бүрээр нэрлэчихсэн. Тэрнээс биш зөвшөөрлийн тоо 20-хон нэмэгдсэн гээд худлаа л даа,

найм, есөн зуу хүрчхээд байна л даа. Түүн шиг нөгөө ингээд дэд сайдыг магадгүй ингээд бүтээмжийн менежер ч гэдэг юм уу нэрлэхивэл болчих юм шиг ийм нэг арга заль ингээд бид ингээд хэрэглээд ирчихсэн. Тэгэхээр би бол зүгээр Засгийн газарт парламент хяналт тавих ёстой гэж үзэж байгаа. Хяналт тавина, төсвийн сахилга батаа барь гэдгийг шаардана. Төсөв санхүүгийн тооцооллуудаа тайлбарлаад, ингээд тэр бүтээмж хяналтын менежер багасгаснаараа ийм хэмнэлт хийсэн, 2,2 их наядын 9 хувийн хэмнэлт хийсэн, дэд сайд дээр 14, 15, 16 билүү дэд сайд томилсон гээд ингээд л тайлбарлаж байгаа.

Р.Сэддорж: 3 номер, 2 номер Улсын Их Хурлын даргын засаглал хариуцсан зөвлөх Тэнгис.

С.Тэнгис: Улсын Их Хурлын даргын засаглал хариуцсан зөвлөх Тэнгис байна. Гишүүний асуултад хариулъя. Төрийн чиг үүргүүдийг шилжүүлж, цомхон чадварлаг төрийг бүтээх зорилгоор Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийг өнгөрсөн жил батлан гаргасан байдаг юм. Гэхдээ хэрэгжилтийн явцад тодорхой хэмжээний хүндрэл үүсээд, бүртгэх эрх бүхий субъект нь маргаан үүсгэсэн учраас энэ хуулийн өөрчлөлтөөр Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийн нэмэлт, өөрчлөлт дагаж орж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл Мэргэжлийн нэгдсэн холбоо маань тухайн салбарын яг салбараа мэддэг мэргэжилтнүүд, холбоодоос бүрдсэн ийм субъект бий болно, салбар бүрд бий болно. Энэ субъектүүд маань өөрөө энэ хуульд зааснаар энгийн зөвшөөрөл буюу 100 гаруй зөвшөөрлийг мэргэжлийн нэгдсэн холбоонд шууд шилжүүлж болохоор зохицуулалт орсон байж байгаа. Үүгээрээ бид тэр төрийн захиргааны байгууллагуудын тэр асуудал үүсгээд байгаа зөвшөөрлүүдийг нь холбоодод нь, мэргэжлийн экспертүүдэд нь шилжүүлж, энэ зах зээлийг оновчтой, чөлөөтэй, нээлттэй, тэгээд өөрийнх нь жамаар хөгждөг тэр зарчмыг бүрдүүлэхээр тусгаж оруулж ирсэн байгаа.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Эдийн засгийн эрх чөлөөг хангах, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих, бизнесийг тэлэх боломжийг олгох олон эерэг үр дагавар энэ хуулийн өөрчлөлтөөс гарна гэж хүлээж байгаа. Үр дүн гарна гэж хүлээж байгаа. Нөгөө талдаа төрийн байгууллагуудын энэ олон зөвшөөрөл олгодог процессын үйл ажиллагаатай ажлын ачаалал цаг хугацааны хувьд алддаг энэ процессын алдагдлуудыг бууруулах байх гэж ингэж найдаж байгаа юм.

2 асуулт байгаа юм. 1 дүгээрт Зөвшөөрлийн хууль болон бусад хууль тогтоомжоос гадуур төрийн захиргааны төв байгууллагуудын дарга нарын баталсан олон журмаар зөвшөөрөл хэлбэртэй бичиг баримтуудыг олгож байсан гэж байгаа юм. Тэгээд энэ бичиг баримтуудыг дахиж гарахгүй байх хаалтыг яг энэ зохицуулалтаар 1 дүгээрт оруулж өгч байгаа юу нэг?

Дахиад бид энэ хуулийг хэрэгжүүлээд явдаг, ард нь бас нэг баахан хууль давсан дүрэм журам гаргачихвал ер нь хариуцлагын тогтолцоо ямар байх ёстой юм бэ?

2 дугаарт энэ яамнууд маань уг нь бодлогын төрийн захиргааны төв байгууллага бодлого барьж байх ёстой. Гэтэл яамнууд тусгай зөвшөөрөл олгоод яваад байдаг. Тусгай зөвшөөрөл олгосон этгээд тусгай зөвшөөрлийнхөө хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих ёстой. Тэгэхээр хяналтын чиг үүрэг нь бас яамдад ирээд яваад байдаг. Тэгээд 1 процесс дээр нэг бизнес хийх гэж нэг үйлдвэрлэл хийх гэж

нэг чиглэлийн процесс дээр нь л гэхэд хэд хэдэн тусгай зөвшөөрөл авдаг. Тухайлбал юу гэдэг юм нэг арьс шир боловсруулах үйлдвэр барих гэж байгаа хүн газраа авсны дараа өндрийн шугамаас эрчим хүчээ буулгаж авахын тулд 1 дүгээрт трансформатор диффе буулгах нэг зөвшөөрөл, диффенээсээ өөрийнхөө объект хүртэл шугам татахын тулд дахиад шугамын зөвшөөрөл яамнаас, дараа нь 380 ашиглахын тулд дахиад орон нутгийн станцаасаа 380-ын зөвшөөрөл гэх мэтчилэн ингээд нэг үйл ажиллагааны зөвхөн нэг хэсэг дээр нь гэхэд л хэд хэдэн зөвшөөрөл авдаг, энэ нь яамнаас олгогддог ийм асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр төрийн захиргааны төв байгууллага өөрөө зөвшөөрөл олгож, гүйцэтгэл хянах нь хэр зохистой юм бэ? Энэ тал дээр ер нь ямар бодлого барьж оруулсан бэ гэдгийг тодруулъя.

Сая хариулт дотор манай мэргэжлийн байгууллагуудаас хариулж байна. Энэ мэргэжлийн экспертүүд төрийн бус байгууллагуудад зөвшөөрөл олгох асуудлыг шилжүүлнэ гэж. Энэ чинь эргээд бизнесийн хэлбэр лүү шилжчих юм биш биз дээ? Өнөөдөр хувь хүнтэй холбоотой асуудал дээр жишээлбэл хувь мэргэжилтэн, хувь хүнийг ажилд оруулахын тулд янз бүрийн сургалтын агуулгад багтаагүй ийм шалгалт юмыг авдаг, тэрийг нь сургалтын нэг төрийн бус байгууллага хийдэг, тэрийг мөнгөөр авдаг, нэг сертификат гэрчилгээ олгодог. Тэрний дагуу ажилд авах ийм шалгуур тавьдаг хүртэл жишиг тогтчихлоо шүү дээ. Манай ТӨК-уд дээр ч энэ жишиг явж байгаа. Өнөөдөр үйлчлэгчээр орохын тулд үйлчлэгчийн цэвэрлэгээний стандарттай тэр стандартыг мөрдсөн, тэр стандартыг заалгасан сургалтад суусан байх ёстой гэдэг шаардлага хүртэл явж байна шүү дээ хувь хүн дээр. Тэгэхээр ийм асуудлууд дээр хязгаарлалтуудыг нь хэрхэн, яаж зохицуулахаар орсон, зөвхөн ААН-тэй холбоотой асуудлууд орсон уу? Энийг цааш нь мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэхэд анхаарахад.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга Учрал хариулна.

Н.Учрал: Тийм, одоо ч гэсэн Зөвшөөрлийн хуульд энэ хориглочихсон л байгаа. Зөвшөөрлийг өөр ямар нэгэн хэлбэрээр гэрчилгээ гэж нэрлэнэ үү, магадлан итгэмжлэл гэж нэрлэнэ үү, сертификат гэж нэрлэнэ үү, ямар нэгэн зөвшөөрлийн хэлбэрийн эрхийг олгохыг хориглоно. Зөвшөөрлийн тэр 381 дотор багтаагүй л бол бусдыг нь чөлөөтэй эрхэл гэж заачхаад байхад жишээ нь нийслэл, аймаг, орон нутаг дээр бүртгэнэ гээд биччихэж байгаа байхгүй юу. Тэгээд оёдлын цех байгуулна бүртгэнэ гээд, бүртгэхгүй бол эхлэхгүй л гэсэн үг. Үгүй ээ тэр чинь гэрчилгээнээс ямар ялгаа байх юм. Тэгээд хүмүүсийг ингээд ажилд хийхэд нь төвөг учруулаад байдаг.

Өнөөдөр байгаль орчны чиглэлээр 9 баримт бичгийг олгохдоо 42 шат дамжлагатай байгаа байгаль орчны салбарынхан. Соёл, боловсролын чиглэлээр 20 баримт бичгийг олгохдоо 80 шат дамжлагатай байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 19 баримт бичгийг олгохын тулд 138 шат дамжлага дамжуулж байгаа шүү дээ 138. Нэг дээс томдог үлгэр шиг юм болж байгаа. Нэг, ерөөсөө цонхноос цонхны хооронд. Эрүүл мэндийн чиглэлээр 33 баримт бичиг олгохдоо 126 шат дамжлагатай. Тэгээд юу гэдэг вэ гэхээр нэг журам байгаа юм, нэг сайдын тушаал байгаа юм, яалт ч болдоггүй юм гээд ингээд. Тэгэнгүүт энэ хуулиар тэр журмаар зохицуулах харилцаануудыг хууль руу татаж авч байгаа, хууль руу татаж авч байгаа. Тэгэхээр зуугаад журмыг цуцална. Энийг Засгийн газар зоригтой хийх ёстой. Тэгээд энэ чинь Хэрэг эрхлэхийн дарга байхад, Эдийн засгийн сайд байхад, энэ чинь Хэрэг эрхлэхийн дарга байхад Зөвшөөрлийн зөвлөлийг би ахалсан, Эдийн засгийн сайд байхад Зөвшөөрлийн санг хариуцсан байхгүй юу.

Тэгээд явж байгаад Их Хурлын даргаар томилогдоод, Ганхуяг гишүүнтэй энэ ажил дээр хамтарч байсан учраас энэ ажлаа явуулсан. Ганхуяг гишүүн Шадар сайд болоод удаагүй байгаа учраас эрх мэдлээсээ салъя гэдэг итгэл үнэмшил нь хэвээр байх шиг байна. Жилийн дараа ямар болохыг хэлж мэдэхгүй байдаг учраас Засгийн газрын гишүүд энийг ярихаар энэ болдоггүй юм байна лээ. Ерөөсөө болдоггүй юм байна лээ. Та яагаад салбараа ингэж байгаа юм бэ, та болохгүй шүү дээ сайдаа гээд ингээд байдаг байхгүй юу. Мэргэжлийн холбоо бэлэн биш шүү дээ. Хуульчдын холбоо өөрөө гэрчилгээгээ өгөөд, сургалтаа хийгээд болоод байна шүү дээ. Яагаад та нар бэлэн, эд нар бэлэн биш байдаг юм. Тэгээд тусгай зөвшөөрөл өгөхийн төлөө тэр 10, 20 нэгж юу хийгээд суугаад байгаа юм бэ? Тэгэхээр нь авлигаас салъя гэвэл, ашиг сонирхлоос ангид байя гэвэл төрийн албан тушаалтнууд ажилдаа эзэн болоод, хэн нэгэн хамааралгүйгээр ажлаа хийе гэвэл зайлшгүй л энийг ингэж явуулах ёстой. Тэгээд нэр ус сольдог ийм асуудлуудаас холдох ийм боломж энэ хуулиар нээгдэнэ.

2 дугаар асуулт дээр чиг үүргийн шинжилгээг яамнууд дээр хийсэн юм. Чиг үүргийн шинжилгээнүүдийг хийсэн чинь яам өөрөө төрийн захиргааны төв байгууллага төрийн захиргааны байгууллага.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Учрал дарга.

Н.Учрал: Чиг үүргийн шинжилгээ хийхэд яам өөрөө зөвшөөрөл олгож байгаа мөртөө өөрөө хянаад байгаа одоогийн байдлаар. Тэр чинь юу вэ гэхээр нөгөө салбарын хяналтууд яамнууд дээр оччихсон чинь ёстой өөрөө зөвшөөрөл олгочоод, олгосон хувийнхаа байгууллагуудыг сайдын доор байгаа газрын дарга улсын байцаагч гэдэг нэртэй нөхөр очиж шалгаад, энэ чинь ер нь эмх замбараагаа л алдаж байна шүү дээ энэ чинь, тэгээд ойлгомжтой биз дээ. Өөрөө зөвшөөрөл олгочоод, өөрөө тэндээс очиж хянаад, өөрөө өөрийгөө сайн, муу гэж дүгнээд нэг ийм л байдалтай. Тэгэхээр цаашаа энэ хууль гарснаараа тэр 100 журам хүчингүй болох ёстой. 2-т тэр нэр ус сольж арга заль хэрэглэдэг ов мэхийг байхгүй болгохгүй бол Шадар сайд хэн бэ гэвэл Ганхуяг гэнэ, Хассуурийн Ганхуяг гишүүн гэнгүүт Ганхуяг гэнэ, Баянголоос сонгогдсон хүн гэнгүүт Ганхуяг гэдэгтэй адилхан нэрийг нь солиод л хүн нь адилхан байгаад байгаатай яг адилхан юм хийгээд.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн нэмж хариулна.

Х.Ганхуяг: Энэ нэмэлт, өөрчлөлтийг хийхэд ер нь мэдэгдэл гэдэг маань яг ямар агуулгаар орж байгаа вэ гэхээр бага зэргийн эрсдэлтэй үйл ажиллагаа, эсвэл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бага зэргийн эрсдэлтэй нэмэлт үйл ажиллагаа гэдгийг ингээд томьёолоод оруулсан байгаа. Тэгээд энийг Учрал дарга Хэрэг эрхлэхийн дарга байхад бид бас нэг чухал баримт батлуулж чадсан нь юу вэ гэхээр Засгийн газар батлуулж чадсан юм нь юу вэ гэхээр нөгөө Эрсдэлийн үнэлгээний журмыг батлуулсан юм. Нэг ёсондоо эрсдэлийн үнэлгээг ингэж хийнэ шүү, нөгөө ... нь энэ байна шүү гээд манай Учрал дарга Хэрэг эрхлэхийн дарга байхдаа батлуулчихсан байгаа гэсэн үг.

Тэгэхээр цаашид нөгөө 3 жил тутам Зөвшөөрлийн зөвлөл өөрөө эргээгээд эрсдэлийн үнэлгээгээ хийнэ. Тэндээс ингээд нөгөө бага эрсдэлтэй үйл ажиллагаануудаа яваандаа ингээд мэдэгдэл рүү аль болох шилжүүлээд явчихвал эргээгээд нөгөө бизнест ирж байгаа нөгөө дарамт, нөгөө яриад байгаа хүндрэл юм чинь улам багасаад л яваад байх ийм нигууртай юм байгаа юм.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууна.

Д.Үүрийнтуяа: Яг ийм учраас л би хариуцлагын тогтолцоог яаж хуульчилж, түүний гүйцэтгэлд нь хэн хяналт тавих, хэрэгжилтийг хангах механизмыг нь л асуугаад байгаа юм л даа. Өөрөөр хэлбэл бодлогын, процессын бидэнд алдаа байгаад байгаа юм. Яам өөрөө зөвшөөрөл олгодог, зарим үйл ажиллагааг нь гүйцэтгэдэг өөрийнх нь дэргэд ТӨК-уд байдаг. Өөрөөр хэлбэл яам өөрөө гүйцэтгэгч болчихдог нэг талаас. Тэгэнгүүтээ нөгөөдхөдөө дахиад өөрөө хяналт тавьдаг. Тэгээд төлөвлөөд зөвшөөрлийг нь олгоод, гүйцэтгээд хянадаг нэг гараараа бүгдийг хийдэг ийм механизм өнөөдөр л яваад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр хяналтын тогтолцоо бол яг үнэндээ хуучин байсан мэргэжлийн хяналтын тогтолцоо ядаж хяналт нь хөндлөн байсан бол өнөөдөр дотооддоо оччихсон. Тэгэхээр энэ асуудал яг энэ хуулийн төсөл дээр тэр бүрэн суусан уу л гэдгийг тодруулаад байгаа юм.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Үүрийнтуяа гишүүн маш зөв асуудал ярьж байна. Ер нь өмнө нь би 2022 онд батлуулахдаа бид Зөвшөөрлийн хуулийг, гол Стандартын хуулийг, тэгээд дагуулаад Төрийн хяналт шалгалтын хуулийг ингээд гурвууланг нь батлуулсных нь дараа ингээд залгуулаад батлуулаад явсан юм. Энэ 3 хууль угаасаа нэг бүтний 3 хэсэг юм байгаа юм. Тэгээд бид хүссэн, хүсээгүй Төрийн хяналт шалгалтын хуулийг энэ хуультай уялдуулж хийх ёстой. Хөндлөн байх нь зөв байх болчихоод байна. Тухайн салбар нь өөрөө сайд нь өөрөө нэг гараараа зөвшөөрөл олгоод, нэг гараараа шалгана гэхихээр эргээгээд ашиг сонирхлын зөрчил гардаг асуудал үүсэж л байна. Энэ яалт ч үгүй үнэн. Мөн Стандартын хуулийг бид ялгаа байхгүй Зөвшөөрлийн хуультайгаа уялдуулж батлуулах ёстой. Одоо стандартыг бол өргөн барьчихсан байгаа, шинэчилсэн найруулга болохоор магадгүй Сэддорж даргаа энэ зөвшөөрлийн ажлын хэсэг байгуулбал, Зөвшөөрлийн хууль дээр угаасаа ажлын хэсэг байгуулж таарах байх. Тэгээд нөгөө Стандартынхаа ажлын хэсэгтэй ажлаа уялдуулаад, хуулиа хамтдаа явуулчихвал их сайн байгаа. Төрийн хяналт шалгалтын хууль бол одоо яг ингээд Засгийн газар дээр яригдаад явж байгаа. Тэгээд тэр нь ингээд төд удалгүй өргөн баригдах байх.

Р.Сэддорж: Заяабал гишүүн нэмж хариулах уу? Бямбацогт дарга. Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Ганхуяг сайдаас асууя. Энэ нэг ойлгомжгүй зөвшөөрлийн нэг байгууллага байдаг юм Монголд. Манай иргэд бүгдээрээ мэднэ. Танай байшинд ус, цахилгааны асуудал үүсээд, бохирын асуудал үүсвэл нэг орон сууцны контор гэж нөхдүүд хариуцдаг шүү дээ. Тэгээд орон сууцны конторын тусгай зөвшөөрлийг нь тэр Усны зохицуулах хороо гэв үү нэг газар өгдөг гэж байгаа юм. Тэгээд нийслэл, дүүргээс асуудал үүсээд контор муу ажиллаж байна гээд иргэдийнхээ өмнөөс нөгөө контортой холбогдохлоор та нар надад хамаагүй, миний тусгай зөвшөөрлийг надад энэ Усны зохицуулах хороо өгдөг гээд ийм маргаан үүсдэг. Тэгээд энэ орон сууцны конторын үйл ажиллагаа эрхлэхэд өгч байгаа Усны зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийг энэ хуульд оруулж шийдэхгүй бол ямар ч үүрэг хариуцлага байдаггүй, зүгээр л зөвшөөрөл өгдөг л газар байгаа байхгүй юу тэр Усны зөвшөөрөл зохицуулах хороо гэж. Тэгээд асуудал үүсэхлээр нийслэл, дүүргийн ЗДТГ хариуцдаг тэр нөгөө ус алдах, цахилгаан техникийн асуудал үүсэхлээр.

Тийм учраас тусгай зөвшөөрөл өгдөг хэр нь эргээд араас нь хяналт тавьдаггүй ийм байгууллагуудын асуудлыг энэ хуулиараа авч үзэхгүй юм уу? Тэр усны, Эрчим хүчний зохицуулах хороо гэж байна. Зөвхөн үнэ нэмэхээр гарч ирдэг, тэгээд алга болчихдог. Яг энэ тусгай зөвшөөрлийнхөө араас явж байгаа юм уу, хяналт тавьж байгаа юм уу бүү мэд. Хамгийн бодит жишээ бол тэр нийслэлд орон сууцны конторын тусгай зөвшөөрлийг өгдөг энэ хоттой огт хамаарал байхгүй ийм сонин байгууллага байна. Зөвхөн тусгай зөвшөөрлийг өгдөг, зовлон болохоор алга болчихдог. Энэ ийм сонин, сонин байгууллагуудын асуудлыг энэ хуулиараа нэг тийш нь болговол яасан юм бэ? Ийм асуулт байна.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулаад ер нь Их Хурлын тогтоол гарч таарах байх. Тэгээд тэрэн дээрээ ер нь жишээлбэл ийм байгаа Нийслэлийн аялал, жуулчлалын газар жишээлбэл хуульд байхгүй зөвшөөрөл шинээр бий болгочихсон өгөөд явчихдаг. Жишээлбэл дэн буудлын зөвшөөрөл, аялал жуулчлалын камп зөвшөөрөл гээд, тэр зөвшөөрөл нь энэ хуульд байхгүй, яам олгодоггүй. Тэгэнгүүт шууд тийм зөвшөөрөл гээд юун дээрээ сайт дээрээ тавиад л, тэгээд л тийм зөвшөөрөл олгоод эхэлчхэж байгаа юм. Тийм асуудлууд байдаг. Цөмөөрөө энэ хуулиар угаасаа тэрийг бол хязгаарлаж байгаа. Энэ хуулийг дагуулаад Их Хурлын тогтоол гарч таарна. Их Хурлын тогтоол дээрээ саяын ярьсан асуудлуудыг бүгдийг нь дурдаад, хүчингүй болохоор Их Хурлаас Засгийн газарт чиглэл өгөх хэрэгтэй гэсэн үг. Засгийн газар болон магадгүй орон нутгийн удирдлагад. Тэгж байж цэгцлэгдэх юм байна лээ.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн тодруулж асууна.

Ж.Алдаржавхлан: Ганхуяг сайд энэ хууль дээрээ миний сая ярьсан тэр байгууллагын асуудлыг нэг тийш нь болгохгүй бол Монголд чинь төрийн монопол бий болчхож. Орон сууцны конторын үйл ажиллагаа явуулахад төрийн орон сууцны конторын компаниуд үйл ажиллагаа явуулаад эрхэлж байна. Тэр чинь хувийн хэвшил хийчих бүрэн бололцоотой. Тийм учраас тэр Усны зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хорооны тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг энэ хуульд энэ хуулийн хүрээнд авч үзмээр байна, энийг оруулж өгөөч энэ хуульдаа би тийм саналтай байна.

2 дугаарт тэр нөгөө Түц энд хамаарахгүй биз дээ. Өмнөх нөгөө хотын дарга маань ковидын үед дуртай үйл ажиллагаагаа явуулаарай гэсэн чинь хотоор дүүрэн Туул голын эргээр дүүрэн юунууд үүссэн. Бид сүүлдээ дийлэхээ больсон. Одоо хотын дарга чинь тэмцээд явж байгаа, явган хүний зам дээр аваачаад тавьчихдаг, тэгээд авдаггүй энэ арай хамаарахгүй байлгүй дээ.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Усны болон орон сууцны юутай холбогдуулаад энэ 3.15 дээр орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ гээд тусгай зөвшөөрөл орсон байгаа. Тэгэхээр энэ бол наад зохицуулалт нь орно гэсэн үг. Юуны асуудал бол Түц-ийн асуудал бол нийтийн эзэмшлийн газар талбайн зөвшөөрлийг Нийслэлийн Засаг дарга олгоно гээд энэ дээр орчихсон байгаа. Тэгэхээр одоо бол НЗД-ын захирамжаар тухайн зөвшөөрлийг нь олгоно гэсэн үг. Түц байна уу, эсвэл тухайн талбай дээр хоол, хүнсний үйлчилгээ үзүүлнэ үү. Яагаад вэ гэхээр энэ өөрөө иргэдийн эрүүл ахуй, эрүүл мэндтэй холбоотой сэдэв байхгүй юу.

Тэгээд тийм болохоор заавал ч үгүй нийтийн эзэмшлийн талбай дээр зөвшөөрөлтэй байдаг. Ер нь дэлхийн аль ч том хотод нийтийн эзэмшлийн талбай дээр худалдаа, үйлчилгээ эрхлэх маань өөрөө зөвшөөрөлтэй л байдаг юм байна лээ. Зүгээр зөвшөөрөл олгох процесс нь өөр байдаг. Тухайлбал борлуулалт ихтэй нийтийн эзэмшлийн талбай дээр бүүр дуудлага худалдааны зарчмаар явдаг. Дуудлага худалдааны зарчмаар. Наадам дээр тийм зарчим хэрэглэсэн гэж би ойлгоод байгаа өнгөрсөн энэ 2025 оны наадам дээр. Тийм зарчмаар л явдаг юм байна лээ.

Р.Сэддорж: Нэмж 1 минут өгье Ганхуяг гишүүнд.

Х.Ганхуяг: Болчихсон уу? Нэмээд асуучих тэгвэл.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна, Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Ганхуяг гишүүнээ хэдүүлээ ажлын хэсэг гарвал би асуугаад байна шүү дээ. Энэ түрүүний тэр ийм зөвхөн тусгай зөвшөөрөл өгдөг, эргээд араас нь хяналтад нь ч оролцдоггүй, иргэдийн гомдлыг ч хүлээж авдаггүй, саяын тэр 2, 3 байгууллагын асуудал энэ хуулийн хүрээнд авч үзэж болох уу? Болно гэвэл ажлын хэсэгт нь ороод, энэ асуудлыг энэ олон жил болж байгаа асуудал байгаа. Зөвхөн зөвшөөрөл өгдөг, тэгээд эргээд ямар ч юунд оролцдоггүй, бүх бусад үед бүгд хаалттай хаалга нь.

Р.Сэддорж: Хариулт Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Ийм байгаа шүү. Энэ Зөвшөөрлийн хууль дээр яг ингээд олгох процесс нь бүгдээрээ байж байгаа. Нөгөө түдгэлзүүлэх байдаг юм уу, яах байдаг юм энэ процесс нь орсон байгаа. Дагаад явж байгаа дагах хуулиуд дээр тухайн салбарын асуудлууд нь нарийвчилж орсон байдаг. Тэгэхээр та яг ажлын хэсэгт нь орж байгаад, яг таны санаа зовниж байгаа асуудлууд дээрээ тэр салбарын хуульд ер нь хэрхэн, яаж хөндөж байгаа тал дээр ажиллаад явчихад болно гэсэн үг. Ер нь таны ярьж байгаа асуудал бүгдээрээ туйлын зөв, энэ дагасан хуулиуд руу орчихсон байгаа гэсэн үг шүү. Та тэгэхээр ажлын хэсэгт ороод ажиллах нь зөв байна гэсэн үг.

Р.Сэддорж: Энэ нөгөө жижиг аж ахуйн нэгжүүдийг ахуйн шинжтэй ийм аж ахуйн нэгжүүдийн зөвшөөрлийг хүнд сурталгүй болгоё гээд байгаа шүү дээ. Тэгэнгүүтээ дахиад л нөгөө нийслэлээс, НЗДТГ-аас зөвшөөрөл авна газрын талбайн зөвшөөрөл авна гээд. Энэ чинь тэгээд дэвшил гарч байгаа юм уу, сая тэгчхэв үү? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Нөгөө нийтийн эзэмшлийн талбай гэдэг маань хэн нэгэн давуу байдал эдэлж, дуртай үйл ажиллагаагаа явуулж болно гэсэн үг биш байхгүй. Энэ угаасаа Зөвшөөрлийн хуульд байсан, хуучин Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хууль дээр байсан. Энийг яагаад энэ Зөвшөөрлийн хуультай процессыг нь оруулж өгч байгаа вэ гэхээр тэр зөвшөөрлийг хэрхэн, яаж авах вэ гэдэг л процессыг нь оруулж байгаа гэсэн үг. Жишээлбэл Сүхбаатарын талбай дээр ирээд дуртай үйл ажиллагаа хийгээд ингээд явж болохгүй байхгүй юу. Тэгээд тэр нь угаасаа заавал ч үгүй хуульчлах ёстой байдаг юм байна лээ. Жишээлбэл сая Туул голын эрэг дээр ярьж байна. Яг нөгөө сезоноосоо хамаараад энд тэнд очоод ингээд үйл ажиллагаа эрхлээд явчихдаг. Тэгэхээр тэрнийг чинь тэр үйл ажиллагаа явуулахын тулд ариун цэврийн нийтийн нөгөө бие засах газар байдаг юм уу, ариун цэврийн асуудал байдаг юм уу энэ юм нь зохицуулалт нь заавал ч үгүй дагаж явдаг юм. Тэгэхээр тэр зөвшөөрлийг олгохоор болчихвол эргээгээд тэр нөгөө хот нь байдаг юм уу, эсвэл

дүүрэг нь байдаг юм уу тэрэнтэй холбоотой иргэдэд үйлчлэх нийтийн бие засах газар, бусад асуудлуудаа заавал давхар жишээлбэл явуулж байх ёстой байдаг байхгүй юу. Тийм учраас тэр заавал ч үгүй зөвшөөрөлтэй байдаг юм байна лээ шүү.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Очирбатаар нэр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат.

Г.Очирбат: Хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Тийм ер нь цаашдаа бид энэ бизнес эрхлэгч нарыгаа дэмжих, аж ахуйн нэгжээ дэмжих бодлогыг энэ үе шаттай, хурдтайгаар авч явахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Ялангуяа энэ зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг салбар яамнууд болон тусгай зөвшөөрөл олгодог тэр бүх байгууллагууд энийг анхааралдаа авах хэрэгтэй шүү. Улсын Их Хурлын гишүүд, парламент энэ дээр ингээд онцгой анхаараад байдаг. Тэгээд яг шат нь нөгөө гүйцэтгэх түвшин дээр очоод гацаад байдаг. Тэгээд энэ байдлыг байхгүй болгох ёстой, хүнд суртлаа багасгах ёстой, зөвшөөрөл гэдэг нэг дөрвөлжин цаасаар аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулах эрхэд нь халдаж болохгүй. Тэгэхээр энэ Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Анар үг хэлнэ.

Ч.Анар: Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Асуудал байгаа. Мэргэжлийн холбоодын нэгдсэн эвлэл гэж байгуулагдсан. Тусгай чиг үүргийн зарим нэгэн асуудал зөвшөөрлүүдийг мэргэжлийн холбоодод өгөх, чиг үүргээр нь шилжүүлж байгаа. Гэхдээ энэ мэргэжлийн холбоодын шинэ хуулийн дагуу бол энэ нь угаасаа өөрөө төрөөс илүү хүнд сурталтай, ашиг сонирхлын зөрчил бүхий газрууд үүсээд байгаа. Борооны дараах мөөг шиг маш олон мэргэжлийн холбоод үүсчихсэн. Түүн дээрээ үндэстний бүх салбар дагасан нэг салбарт олон охин компани, хамаарал бүхий компаниуд өөрснөө үндсэндээ бараг мэргэжлийн холбоодыг байгуулаад, бусад жижиг шинэ өөр зах зээл дэх компаниудыг шахах үйл ажиллагаа энүүгээрээ дамжуулж хийх эрсдэлтэй байгаа. Тэгэхээр энэ болзошгүй үр дагаврыг нь энэ хуулийн ажлын хэсэг сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Ганхуяг гишүүн сууж байгаарай. Энэ чинь үг хэлж дуусаагүй байгаа байх шүү. 91 санал хураалт байгаа. 91 санал хураалт байгаа. Энэ ажлын хэсгийг Учрал Их Хурлын дарга ажлын хэсэг гаргана. Би тэгээд сая үгээ дахиад л хэлье. Тэгээд энэ хуулиараа ингээд ингэж их ач холбогдол өгч байж, зарим зүйлүүдийг сайн шийдэж, иргэддээ ээлтэй төр гэдгээ харуулах ийм боломж энүүгээр л гарах гээд байна шүү дээ. Тэгээд Ганхуяг гишүүн, Заяабал гишүүн, Учрал дарга, Бямбацогт дарга оролцсон. Ингээд энэний хуралд нь би сууж байсан.

Тэгээд сая тэр бие засах газрын асуудал дээр тэгээд иргэд чинь дэд бүтэц байхгүйгээс тэгээд л амиа юугаа яаж хөл дээрээ босгох вэ гэж байгаа ард түмэн бол тэн дээр очоод л гацна шүү дээ. Тэгээд сая Түц-үүдийн асуудлыг байгаа. Тэр Түц-үүдийн ард хэдэн айлын амьдрал байсан бол тийм ээ? Одоо ингээд дэлхийн том, том сүлжээнүүд ороод ирсэн CU, GS25 гээд. Энэ бие засах газрын асуудлыг тэгээд энэ чинь яг төр л яах ёстой шүү дээ, хийх ёстой. Нийслэлийн Тамгын газар, Нийслэл Улаанбаатар хот чинь энэ нийтийн бие засах газар эд нараа шийдэх ёстой биз дээ. Тэгэхээр энэ дээр заавал тэр хувийн хэвшил рүү энэ асуудлуудыг хандуулах нь тийм

зөв зүйл биш байх. Зүгээр миний хувьд шүү. Тэгэхээр хуушуурын зөвшөөрөл авах гээд л бүтдэггүй гэж байгаа шүү дээ. Тэгээд наадмын зөвшөөрөл эд нар дээр чинь асуудал үүсдэг гэж байгаа юм. Тэгээд энд байгаа энэ ажлын хэсгийн энэ гишүүд энэ дээр бүгд л дотроо бодож байгаа байх.

Тэгээд энэ хуулиа энэ ажлын хэсгээ сайн ажиллуулж, иргэндээ ээлтэй, аж ахуйн нэгжүүддээ ээлтэй, жижиг, дунд үйлдвэрүүдийг жинхэнэ дэмжсэн ийм төр энэ хуулийн өөрчлөлтөөр бий болох гэж байна л гэж иргэд маань хүлээж байгаа байх. Ажлын хэсэг хэлэлцэх эсэх, одоо санал хураалт явагдана. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт.

Саналын томьёолол. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70,6 хувиар санал дэмжигдлээ. Хамт өргөн мэдүүлсэн хуулиудын санал хураалт явагдана.

Хамт өргөн мэдүүлсэн Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70,6 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсгийн гишүүдийг хурлын танхимаас гарч болно.

3.Авто тээврийн, хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70,6 хувиар санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт, санал хураалт. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

9.Хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүдийн ирцэд анхааръя.

11.Хамт өргөн мэдүүлсэн Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувиар санал дэмжигдлээ.

12.Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Хамт өргөн мэдүүлсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батнайрамдал гишүүн, Уянга гишүүн горимын санал гаргая, гаргана.

Б.Уянга: Уучлаарай. Санал хураалтад оролцож амжсангүй. Техникийн алдаа.

Р.Сэддорж: Хүчингүй болгож өгнө үү гэсэн тийм ээ санал хураалтыг?

Б.Уянга: Хүчингүй болгоё.

Р.Сэддорж: Уянга гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,2 хувийн, 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүй болсон тул дахин санал хураалт явуулъя. Хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Хамт өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Хамт өргөн мэдүүлсэн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Алдаржавхлан гишүүн горимын санал гаргана.

Ж.Алдаржавхлан: Техникийн асуудлаас болж санал хураалтад оролцож чадсангүй. Санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

Р.Сэддорж: Төхөөрөмж ажиллаагүй учраас Алдаржавхлан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Батнайрамдал гишүүн, Лодойсамбуу гишүүн горимын санал гаргая. Ирцэд орсон гишүүдийг танхимд урьж байна. Алдаржавхлан гишүүний гаргасан горимын саналаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжээгүй. Тэгэхээр Байнгын хорооноос дэмжээгүй гэдгээр чуулганд орохоор болж байна.

Дараагийн санал хураалт явуулъя. 17.Хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцоорой. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Хамт өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Хамт өргөн мэдүүлсэн биш ээ, 19.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Хамт өргөн мэдүүлсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Хамт өргөн мэдүүлсэн Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Хамт өргөн мэдүүлсэн Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Хамт өргөн мэдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Хамт өргөн мэдүүлсэн Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Хамт өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Хамт өргөн мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Хамт өргөн мэдүүлсэн Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Хамт өргөн мэдүүлсэн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Хамт өргөн мэдүүлсэн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувиар санал дэмжигдлээ.

34.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Хамт өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Хамт өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энхцэцэг гишүүн горимын санал гаргаж байна.

М.Энхцэцэг: Сая энэ төхөөрөмж ажилласангүй, тэгэхээр саяын саналыг хүчингүй болгоод, дахиж санал хурааж өгөөч гэсэн горимын санал гаргаж байна.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар сүүлийн санал хураалтыг 40 дэх санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдэж, 40 дэх санал хураалт хүчингүй болж байна. Дахин санал хураалтыг явуулъя. Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Хамт өргөн мэдүүлсэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Мэргэжлийн нэгдсэн холбоо хураасан уу.

44.Хамт өргөн мэдүүлсэн Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Хамт өргөн мэдүүлсэн Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Хамт өргөн мэдүүлсэн Оюуны өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Хамт өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Хамт өргөн мэдүүлсэн Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

49.Хамт өргөн мэдүүлсэн Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

50.Хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

51.Хамт өргөн мэдүүлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 67,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

52.Хамт өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53.Хамт өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

54.Хамт өргөн мэдүүлсэн Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

55.Хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56.Хамт өргөн мэдүүлсэн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

57.Хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

58.Тусгай хамгаалалттай, хамт өргөн мэдүүлсэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

59.Хамт өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

60.Хамт өргөн мэдүүлсэн Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61.Хамт өргөн мэдүүлсэн Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

62.Хамт өргөн мэдүүлсэн Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

63.Хамт өргөн мэдүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

64.Хамт өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

65.Хамт өргөн мэдүүлсэн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

66.Хамт өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

67.Хамт өргөн мэдүүлсэн Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. 69.

68.Хамт өргөн мэдүүлсэн Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

69.Хамт өргөн мэдүүлсэн Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

70.Хамт өргөн мэдүүлсэн Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа. Одоо 20 санал хураалт эхний асуудлын.

71.Хамт өргөн мэдүүлсэн Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд, зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

72.Хамт өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

73.Хамт өргөн мэдүүлсэн Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

74.Хамт өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

75.Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

76.Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

77.Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцье дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 78,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

78.Хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

79.Хамт өргөн мэдүүлсэн Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

80.Хамт өргөн мэдүүлсэн Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

81.Хамт өргөн мэдүүлсэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүддээ баярлалаа. Одоо 8 санал хураалт болно.

82.Хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Бүгдээрээ идэвхтэй оролцохыг хүсье гишүүддээ. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

83.Хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

84.Хамт өргөн мэдүүлсэн Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

85.Хамт өргөн мэдүүлсэн Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

86.Хамт өргөн мэдүүлсэн Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

87.Хамт өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

88.Хамт өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

89.Хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эхний асуудлын сүүлийн санал хураалт. 90.Эрчим хүчний тухай хуульд, хамт өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Очирбат гишүүн танилцуулах уу? Очирбат гишүүн танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

12.32 цаг

Хоёр. “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа орѐе, гишүүддээ баярлалаа. Хэлэлцэх асуудал 2. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлѐе. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт танилцуулна. Наранцогт Ерөнхийлөгчийн микрофоныг нээе. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт танилцуулна, 4 номерын микрофоныг нээе.

С.Наранцогт: Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтын дагуу Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 26 оны төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьж байна. Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 25 оны төсвийн гүйцэтгэлийг мөн танилцуулж байна.

Үүнд 1.2025 оны эрдэнэсийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр 2 тэрбум төгрөгийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, байгалийн төрц алт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад зарцуулахаар төлөвлөсөн байна. Эрдэнэсийн санд 2025 онд иргэдээс эд зүйл худалдан авах тухай өргөдөл ирснээс Жанрайсэг бурхныг 100 сая төгрөгөөр худалдах худалдан авах гэрээ байгуулан эд зүйлийг хүлээн авч, Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэсэн байна.

2.Монголбанкны дурсгалын зоосны дээж болон франчайз зоосыг гүйцэтгэлээр орлогод авахаар төлөвлөсөн бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 162 ширхэг дээд зоосыг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэсэн байна.

3.1945 оны зоосон мөнгөн тэмдэгт 2000 ширхэг, Монголбанкны хүндэт банкир тэмдгийг Үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор мөн бүртгэсэн байна.

4.Монголбанкны санаачилгаар болон франчайзаар үйлдвэрлэсэн дурсгалын зоос, үрлэн мөнгө, гулдмай 5701 ширхгийг эрдэнэсийн сангийн гүйлгээ санд мөн орлогоор бүртгэн авсан.

5.Гүйлгээ сангаас 24500 ширхэг дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар тусгагдсанаас зочин төлөөлөгчийн зардлаар 184 ширхэг дурсгалын зоос зарцуулж, 4561 ширхэг дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг 11,9 тэрбум төгрөгөөр худалдсан байна.

6.Чингис хаан баримлын үзэсгэлэнгийн нээлт болон эрдэнэсийн сангийн сан хөмрөг дэх эд зүйлийн сэлбэн тордолт, бусад ажлын зардалд 2025 онд нийт 200 сая төгрөгийг төсөвлөснөөс 46,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Эрдэнэсийн сан хөмрөгт нийт 1,1 их наяд төгрөгийн үнэ бүхий 2706275 ширхэг эд зүйлс хадгалагдаж байгаа бөгөөд төрц алт 32 ширхэг, Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зүйлийн ангилалд хамаарах 30 дэсийн 130 ширхэг эд зүйлс байна.

Одоо та бүхэнд 2026 оны Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг танилцуулъя. Монголбанкнаас эрдэнэсийн сангийн сан хөмрөгийн 2026 онд дараах байдлаар нэмэгдүүлж үндсэн санд орлогоор бүртгэгдэхээр төсвийн төлөвлөгөөг төлөвлөсөн байна.

Үүнд, 1.Эрдэнэсийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, сэргээн засварлалт, байгалийн төрц алт худалдан авах, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад 2 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.

2.Монголбанкны зөвшөөрлөөр цуглуулсан франчайз болон дурсгалын зоосны дээжийг орлогоор бүртгэх, мөн 2026 онд үйлдвэрлэгдэх дурсгалын зоос болон бусад эд зүйлсийг гүйлгээ санд орлогоор бүртгэхээр төлөвлөсөн. Гүйлгээ сангийн 24500 ширхэг дурсгалын зоос болон гулдмай, үрлэн мөнгө зарлагадах, үүнээс худалдах зориулалтаар 24300 ширхгийг, зочид төлөөлөгчдийн зардлаар 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар төлөвлөсөн байна.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны хурлаар Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл болон 2026 оны төсвийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Санжаагийн Наранцогт Монголбанкны Ерөнхийлөгч, Атарбаатарын Энхжин Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Пүрэвдоржийн Эрдэнэтуяа Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн захирал, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Түмэнжаргалын Тэлмэн Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Эрдэнэсийн сангийн ахлах эдийн засагч.

Тайлантай холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье. Алга байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийг баримтлан боловсруулсан Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэлийг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2026 оны төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай. Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Эрдэнэсийн сангийн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Уянга гишүүн танилцуулах уу? Улсын Их Хурлын гишүүн Уянга уншиж танилцуулна.

12.41 цаг

Гурав. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3.Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-аас 2028 онд биржээр болон олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийг оруулъя. Асуулт асууж, үг хэлсний дараа санал хураалттай тул гишүүдийг хуралдааны танхимд ирэхийг урьж байна.

Тогтоолын төслийн талаарх төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Сайдын микрофоныг нээе, 3 номер.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсад өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээс хойш 35 жилийн хугацаа өнгөрсөн байна. 1991 оноос хойш нийтдээ 2019 аж ахуйн нэгж үл хөдлөх хөрөнгө, хувьцааг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг хувьчилж, улсын төсөвт 278 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, хувийн хэвшлийг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмрээ оруулсан. 2025 оны байдлаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам тээвэр, банк, санхүү, мэдээлэл харилцаа зэрэг салбаруудад нийт толгой компани 84, тэдгээрийн охин хараат компани 17, нийт 101 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тэдгээр компани, үйлдвэрийн газруудаас 100 хувь төрийн өмчийн 73, төрийн өмчийн оролцоотой 22, олон нийтийн нээлттэй хувьцаат компани 6 байна. Төрийн өмчит компани /ТӨК/, үйлдвэрийн газрууд нь 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн нэгдсэн дүнгээр нийт хөрөнгө 59,4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 74,3 хувь, нийт орлого 26 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 32,5 хувь, нийт өр төлбөр 22,9 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 28,6 хувь тус тус эзэлж байна.

Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт ТӨК-ийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үе шаттай хувьчлалыг хэрэгжүүлэх зорилт тусгагдсан бөгөөд Шинэ итгэл-эрс шинэтгэл Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд ТӨК-ийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулах, цахим шилжилт хийх зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Иймд төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн болон стратегийн хөрөнгө оруулалт, санал болгох хувьцааны хэмжээг үндсэн чиглэл дээр тодорхойлсны дагуу нээлттэй хувьцаат компани болгох, төрийн мэдэлд байх өмчийн хүрээг дахин тодорхойлох, ТӨК, үйлдвэрийн газруудыг тодорхой шалгуурын хүрээнд ангилж авч үзэж, ангилал тус бүрийн онцлогт тулгуурлан төрийн зүгээс тухайн компанид оролцох өмчлөлийн бодлогыг ялгамжтай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн давхардсан чиг үүрэгтэй, үр ашиггүй хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, цэгцлэх үүднээс чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц, орон тоог оновчлох замаар ТӨК, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд татан буулгах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төсөлд тусгасан. Төсөлд эхний ээлжид олон нийтэд нээлттэй болгох, хувьцааг биржээр арилжаалах, төрийн мэдлийн хувьцааг худалдах болон өөрчлөн байгуулахаар дараах компаниудыг тусгалаа. Төрийн өмчит дараах 18 хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гарган, биржээр олон нийтэд нээлттэй худалдана.

Үүнд, 1.Монголын цахилгаан холбоо хувьцаат компани, 2.Хөдөө аж ахуйн бирж хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3.Үндэсний давхар даатгал хувьцаат компани, 4.Монголын хөрөнгийн бирж хувьцаат компани, 5.Хөдөө аж ахуйн корпорац хязгаарлагдмал хариуцлагатай компани, 6.Шивээ-Овоо хувьцаат компани, 7.Багануур хувьцаат компани, 8.МИАТ төрийн өмчит хувьцаат компани, 9.Төрийн банк хувьцаат компани, 10.Эрдэнэс Тавантолгой хувьцаат компани, 11.Эрдэнэс үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газар, 12.Эрдэнэс критикал минералс төрийн өмчит үйлдвэрийн газар, 13.Дулааны 3 дугаар цахилгаан станц хувьцаат компани, 14.Дулааны 4 дүгээр цахилгаан станц хувьцаат компани, 15.Эрдэнэтийн дулааны цахилгаан станц хувьцаат компани, 16.Дорнод бүсийн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компани, 17.Дарханы дулааны цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компани, 18.Амгалан дулааны станц төрийн өмчит хувьцаат компани.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах 8 компанийн төрийн эзэмшлийн хувьцааг худалдана. 1.Дулааны Шарын гол төрийн өмчит хувьцаат компани, 2.Цемент шохой хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3.Монгол шуудан хувьцаат компани, 4.Багануурын дулааны станц төрийн өмчит хувьцаат компани, 5.Налайхын дулааны станц төрийн өмчит хувьцаат компани, 6.Хөвсгөл дулааны станц төрийн өмчит хувьцаат компани, 7.Ховд дулааны станц төрийн өмчит хувьцаат компани, 9.Улаангомын дулааны 2 дугаар станц.

Дараах 7 төрлийн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх арга хэмжээ авна. Үүнд, 1.Эрдэнэс Монгол хязгаарлагдмал хариуцлагатай компани, 2.Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компани, 3.Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани, 4.Мэдээллийн технологийн үндэсний парк төрийн өмчит үйлдвэрийн газар, 5.Авто импекс хувьцаат компани, 6.Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэр технологийн цогцолбор хязгаарлагдмал хариуцлагатай компани, 7.Авто зам засвар арчлалтын нэгтгэл Төрийн өмчит компани. Дээрх компаниудын хувьд нээлттэй хувьцаат компани болгохын тулд компанийн засаглалыг шинэчлэх, санхүүгийн тайланд нь хөндлөнгийн аудит хийлгэх, ил тод мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ өмнөх жилүүдийн хувьчлалын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, зайлшгүй төрийн мэдэлд байх төрийн өмчийн хүрээг дахин тодорхойлсны үндсэн дээр давхардсан чиг үүрэгтэй, үр ашиггүй хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, цэгцлэх асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Тодруулбал Монгол Улсын Их Хурлаас 2001-ээс 2022 оны хооронд Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг 5 удаа баталсан боловч хэрэгжилт хангалтгүй, хангалтгүй 33 хувьтай. Давхардсан тоогоор нийт 115 хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулахаар заасан ч дийлэнх хувь нь хэрэгжээгүй байх тул дээрх үндсэн чиглэлүүдийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авах арга хэмжээний саналыг мөн тогтоолын төсөлд тусгасан болно.

Төрийн өмчийг хувьчлах бодлогыг хөрөнгийн зах зээлийн чиг хандлага, эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдын сонирхол, хуулийн этгээдийн бодит үнэ цэн, үнэлгээнд тулгуурлан тогтоож, үе шаттай, ил тод, хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа болно.

Тогтоолын төсөлд төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, эхний ээлжид авах арга хэмжээний саналыг тусгасан болохыг энэ ташрамд дурдъя. Анхаарал хандуулсанд баярлалаа. Хэлэлцэн, шийдвэрлэж өгнө үү.

Р.Сэддорж: Бямбацогт сайдад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дамдинпүрэвийн Батзориг Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Эрчим хүчний яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батсуурийн Даваадалай Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Ганибалын Амартүвшин Эрчист монгол компанийн гүйцэтгэх захирал, Жаргалсайханы Мөнхсайхан Эрчист монгол компанийн Стратеги, бизнес хөгжлийн газрын захирал, Аюушийн Ариунболд Эрчист Монгол компанийн Хууль, эрх зүй, хянан нийлүүлэлтийн газрын захирал, Раднаарагчаагийн Очбадрах Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн албаны дарга, Даваацэрэнгийн Мөнхбат Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тунсагийн Тэлмэн МИАТ компанийн төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Нарангэрэлийн Цэгц МИАТ төрийн өмчит компанийн Санхүү, удирдлагын газрын захирал, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн газрын Санхүүгийн бодлогын газрын Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Пүрэвсүрэнгийн Тамир Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Доржийн Эрдэнэбат Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Цагаанчулууны Анх-Од Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга, Эрдэнэ-Очирын Уянга Эрдэнэс Тавантолгой хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга, Дэлэгпунцагийн Ядамжав Эрдэнэс Монгол компанийн Чанар, бүтээмжийн менежер, Самдандоржийн Ашидмөнх Эрдэнэс Монгол компанийн Түлш, эрчим хүчний группийн зохицуулагч, Насанбаярын Ганхуяг Цемент шохой төрийн өмчит хувьцаат компанийн Стратеги, төлөвлөлт, бизнес хөгжлийн газрын дарга, Батмөнхийн Жавхлант Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гомбодоржийн Батсуурь Шивээ-Овоо хувьцаат компанийн захирал, Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Вандангийн Дарханбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга, Дамбын Нямдэлгэр ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын ахлах референт.

Гишүүд санал хураалт явуулах учраас гишүүдийн ирцийг бүрдүүлж, 30 минут Байнгын хорооны хурлыг завсарлуулж байна, цаг. Асуултаа тэгээд нэмээд явчихъя гэж үү? Асуултын нэрээ авчих гэж үү? Тэгье. Тогтоолын төслийн талаар төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасалъя. 1 цаг 30 минутаас хуралдаан үргэлжилнэ, 1 цаг 30 минут.

Хуралдаан 12 цаг 58 минутаас 13 цаг 40 минутад завсарлав.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны завсарлага дууссан. Хуралдаанаа үргэлжлүүлье. Гишүүд асуулт асуухаар нэрсээ өгсөн. Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан гишүүн асуулт асууя.

Л.Энх-Амгалан: Надад бараг асуух юм байхгүй дээ. Тэгээд энэ төрийн болон орон нутгийн ТӨК-удын энэ өөрчлөлт зохион байгуулалтын асуудал бараг үндсэндээ сүүлийн 30 жил л ярьж байгаа, огт хийгдэж чаддаггүй, хийж чаддаггүй нэг ийм сэдэв. Тэгээд та бид нэг хэдхэн тоон дээр л их анхаарлаа хандуулах ёстой гэж би ойлгоод байгаа юм. Өнөөдөр танилцуулагдаж байгаа энэ компаниудын юу бол энэ төрд байгаа 67 компани, энэ дээр 59 мянган хүн ажиллаж байна. Бүгдээрээ нийлээд 25,9 тэрбумын их наядын борлуулалт хийж байна. Ингээд өр төлбөр нь тэрнээсээ илүү 22,8 их наяд болчихсон, хамгийн их өр төлбөр үйлдвэрлэдэг. Тэгээд нийт хөрөнгө нь бараг 60 их наяд гарчихсан мөртөө энэ хөрөнгийн өгөөж нь 9,6. Энэ дээр энэнээс яг Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой 2-ыг хасчихвал бараг хасахтай, хөрөнгийн өгөөж хасах.

Энэ дээр ингэж байгаа юм. Өнөөдөр яг энэ ТӨК-удын нийт орлого дотоодын нийт бүтэгдэхүүний 32,5 хувь тийм ээ. Ингээд бараг үндсэндээ өр төлбөр нь Дотоодын нийт бүтээгдэхүүний 28,6 хувь гээд, ингээд эндээс Эрдэнэт Тавантолгой 2-ыг хасчихаар илүү энэ үзүүлэлтүүд нь ингээд буучхаж байгаа юм. Эндээс бид юу харж байна вэ гэхээр үнэхээр манай зах зээлийн эдийн засаг бол Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжээгүй, яг хуучнаараа төрийн өмчид суурилсан эдийн засагтай улс орон гэдгийг бид харж дүгнэлт хийж чадна. Тэгээд их гашуун сургамжууд бидэнд их байгаа.

Өнөөдөр ингээд энэ компаниудаа бизнесийн болон өрсөлдөөнд суурилсан ТӨК, стратегид суурилсан ТӨК, нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц, тусгайлсан чиг үүрэг бүхий ТӨК гээд 3 ангилаад оруулж ирж байх шиг байна. Бид харилцаа холбоо компани гэж Монголын цахилгаан холбоо компани гэж хамгийн үнэ цэнтэй компани Монгол Улсад байсан, хамгийн үнэ цэнтэй компани байсан. Энийг хувьчлахгүй стратегийн компани гэж ингэж авч үлдээд өнөөдөр энэ компани яг ямар үнэ цэнтэй болчхов? Өнөөдөр энэ компани Мобиком, Юнител, Скайтелтай харьцуулахад ямар үнэ цэнтэй болчхов? Дахиад дээрээс нь төр холбооны үйлчилгээ монопол байх ёстой гээд манай Анар гишүүн сайн мэдэж байгаа байх, Тагнуулын ерөнхий газар хүртэл бие даагаад сүлжээний компани байгуулж байсан, харилцаа холбооны компани байгуулж байсан. Ийм гашуун сургамж бидэнд маш их байна. Тийм учраас ингээд бид энэ өмч хувьчлалын асуудлуудыг нэг нэгнээ хардахгүй сэрдэхгүй шиг нь хийх ёстой.

Сая Бямбацогт гишүүн Сингапурын Temasek дээр очоод ирсэн байна лээ. Би зүгээр нэг онигоотой зүйлийг хэлье гэж бодож байна. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэтэй очиход тэр Temasek сан дээр Монгол Улсаас 108 дахь удаагийн зочид төлөөлөгч ирж байна гэж байж байсан 108 дахь удаагийн. Тэгээд та нар төрийн өмчийнхөө өөрчлөн байгуулалтуудыг одоо хүртэл хийгээгүй юм уу гэж. Ер нь дэлхийн хэмжээнд манай Монголчуудын хамгийн их очсон компани Temasek, Норвегийн баялгийн сан гэж энэ 2 компани байдаг. Маш их судалсан, маш их мөнгө зарсан. Эргээд ямар ч үр дүн байхгүй.

Р.Сэддорж: 1 минут Энх-Амгалан гишүүн.

Л.Энх-Амгалан: Тэгээд одоо нөхдүүд минь нэг жаахан зориг гаргаж, энэ хардлага сэрдлэгээ жоохон хойш нь тавьж, үнэхээр энэ өмч хувьчлалын бодлогоо явуулбал явуулсан шиг явуулах хэрэгтэй, маш их ярилаа. Бие биеийгээ маш их хардаж сэрдлээ. Та бүхэн санаж байгаа бол Валяхүү гуай гээд Төрийн өмчийн хороонд насаараа ажилласан энэ хүн бол энэ бүх зөвлөх үйлчилгээ гээд хэдэн боть ном болсон. Төрийн өмчийн хороонд одоо байгаа байх тийм үү Цэнгэл даргаа? Бараг жаахан дэгсдүүлээд хэлчихвэл аймгийн номын сангаас илүү та нарт гаднын зөвлөгөөнүүдийг өгсөн, зөвлөх компаниудын өгсөн зөвлөх үйлчилгээ байгаа. Одоо бид энэ дээрээ шийдвэр гаргаж, энэ зохистой арга хэмжээгээ авч хийхгүй юм бол манай Төрийн өмчийн хорооны дарга Цэнгэл дарга маань бас л Валяхүү гуайн араас л орно. Тэгээд хэдэн боть номоо тэврээд л тэтгэвэртээ гарна. Энэ цаг ч их удахгүй байна.

Тийм учраас өнөөдөр энэ төрийн өмчийн талаар явуулж байгаа энэ бодлогын асуудлууд дээр нэг шинэ парламент гарлаа, тийм ээ энэ хүрээнд хамгийн том шийдвэр гарах ёстой шийдвэрүүд бол энэ шийдвэр байх болов уу л гэсэн ийм бодолтой байна гэдгийг би хэлье.

Р.Сэддорж: Бямбацогт сайд 3 номер.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүн маш чухал асуудал хөндөж байна. Тэгээд яах аргагүй өнгөрсөн 35 жилийн хугацаанд өмч хувьчлалын явуулсан бодлогын маань үр дүн нэг иймэрхүү байдалтай байгаа. Бид 35 жилийн хугацаанд өмч хувьчлах ТӨК-ийг нээлттэй хувьцаат компани болгох энэ бодлогыг хэрэгжүүлсэн. Энэ бодлогын үр дүнд 2 мянга орчим аж ахуйн нэгж, хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг худалдсан, хувьчилсан, хувьд шилжүүлсэн. Үүнээс 287 тэрбум төгрөгийн орлого орсон ийм л дүн тооцоо гардаг юм байна лээ. Яг өнөөдрийн байдлаар төрийн өмчит үйл ажиллагаа явуулж байгаа 101 компани байгаа. Энэ компаниудын олж байгаа орлого ноогдол ашгаараа 1 их наяд төгрөг, улсын төсөвт жил болгон төлж байгаа татвар, төлбөр, хураамж нь 6, 7 орчим их наяд төгрөг болсон.

Тэгээд үүнтэй харьцуулаад үзвэл өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд өмч хувьчлалын бодлого маань хэр зэрэг амжилттай хэрэгжсэн бэ гэдэг дээр тэгээд үр өгөөжтэй байж чадсан уу, үгүй юу гэдэг дээр нэг эргэж харж, дүгнэлт хийх ёстой байх. Үүн дээрээ тулгуурлаад цаашдаа бид энэ 26-аас 30 онд Монгол Улсыг хөгжүүлэх Шинэ итгэл-эрс шинэтгэл хөгжлийн, бодлогын бичиг баримт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, мөн Улсын Их Хурлаас өнгөрсөн жил Засгийн газарт энэ ТӨК-удыг нээлттэй ил тод хувьцаат компани болгох, энэ өмчийг хувьчлах, шаардлагагүй хөрөнгүүдээ хувьд шилжүүлэх энэ талаар бодлогоо оруулж ир гэж Засгийн газарт үүрэг өгсөн. Үүний дагуу оруулж ирж байгаа. Энэ хүрээнд таны ярьж байгаа энэ асуудлууд харьцангуй хөндөгдөж байгаа. Тэгээд Их Хурал дээр

хэлэлцээд, Их Хурал нээлттэй хэлэлцээд чөлөөтэй шийдэх учраас аль болох бид нэлээн чөлөөтэй байдлаар либерал байдлаар оруулж ирье гэж шийдсэн.

Тэр Цахилгаан холбоо компанийн тухайд яг тийм. Хамгийн нүдний цөцгий мэт хайрлаж байсан өнөөдөр зах зээлд өрсөлдөөнд олон үүрэн телефоны операторууд бий болсон. Өнөөдөр хамгийн үр ашигтай, хамгийн хямд, хамгийн хурдан, чанартай үйлчилгээг хувийн хэвшлийнхэн үзүүлж чаддаг болсон. Хамгийн хөшүүн хойрго, хамгийн удаан, хамгийн өндөр зардалтай компани Монголын цахилгаан холбоо компани болж хувирсан. Тэгээд төрд өмч байгаад, тэр өмчөө зөв захиран зарцуулж, зөв менежмент явуулж чадахгүй бол ингээд бидний хайрладаг хөрөнгө нэг мэдэхэд ингээд үнэ цэнгүй, үхмэл хөрөнгө болчихдог юм байна.

Тийм болохоор цаашдаа тодорхой хөрөнгүүдээ бид ингэж үнэ цэнтэй байгаа дээр нь зөв менежмент, зөв бодлого явуулж, илүү ард иргэддээ Монгол Улсынхаа эдийн засагт ээлтэй байлгах тал дээр нэг томоохон бодлого гаргах цаг нь болсон гэж хэлж байгаа тантай санал нэг байна.

Р.Сэддорж: Асуулт дээр Сайнзориг гишүүн, Номинчимэг гишүүн, Лодойсамбуу гишүүн нарыг нэмье. Энх-Амгалан гишүүн тодруулж асууя.

Л.Энх-Амгалан: Би энэ Цэнгэл даргаас нэг тоог та Монголын ард түмэнд нэг хэлж өгөөч гэж хэлэх гэж байгаа юм. Сүүлийн 30 жилд яг энэ төрийн өмч хувьчлалын талаар, төрийн компаниудын бүтэц, зохион байгуулалтын талаар хэдэн донорын зөвлөх үйлчилгээг авсан бэ, хэдэн удаа авсан бэ, ямар мөнгө зарсан бэ? Яг миний түрүүний хэлдэг нөгөө Temasek, Норвегийн сангийн энийг ... хүргэж ирдэг, танилцах уулзалтыг хэдэн удаа хийсэн бэ? Ер нь энийг нэгтгэсэн ингээд нэг ийм санхүүгийн тооцооллууд байна уу? Хэдэн удаагийн бодлогын зөвлөмжүүд байна вэ? Миний санахаар Европын сэргээн босголтын банкнаас авхуулаад Азийн хөгжлийн банк, Дэлхийн Банк, хамгийн сүүлд Эрдэнэс Монгол компани Ганхүүг захиралд байхад би санаж байна 5 сая долларын Азийн хөгжлийн банкны энэ өөрчлөлтийн зөвлөх үйлчилгээнүүдийг авч байсан, 5 сая доллар шүү. Энэ бага мөнгө биш тийм ээ. Тэгэхээр энийг нэгтгэсэн энэ тоог та нэг хэлж өгөөч?

Р.Сэддорж: 2 номер.

Б.Цэнгэл: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банкны экспертүүдтэй хамтарч 3 жилийн хугацаанд хамтарч ажиллаж байна. Ингээд зөвлөх үйлчилгээнүүдийг бол авч байгаа, хамгийн сүүлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтраад 200 мянган долларын төсөл хэрэгжүүлэх ийм хувилбар дээр ярьж байгаа. Техникийн буцалтгүй тусламжуудыг бас үзүүлэх ийм нааштай үр дүнгүүд гарч ирж байгаа.

Нөгөө нэг асуудал бол бид БНХАУ-ын SASAC буюу төрийн өмчийн хяналтын хороо буюу яг манайхтай адил төстэй байгууллагатай нь Ерөнхий сайд Хятадад айлчлах үеэр нь хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Энэ санамж бичгийн хүрээн дээр жил болгон 2 талдаа ТӨК-удын сургалт форумыг амжилттай зохион байгуулаад явж байгаа. Мөн.../минут дуусав/

Р.Сэддорж: 2 номер 1 минут.

Б.Цэнгэл: Мөн Солонгосын Temasek, Сингапурын Temasek, Хятадын SASAC, Казахстаны болон Скандинавын орнуудын туршлагыг нэлээд судалж ажиллаж байгаа. Яг тодорхой хэчнээн төсөл дээр, ямар хөрөнгийн асуудал яригдаж байгаа талаар танд тусад нь мэдээлэл бэлдээд тан руу явуулъя.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

Л.Соронзонболд: Энэ төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг ирэх 3 жилийн хугацаанд олон нийтэд нээлттэй худалдана гээд энэ ерөнхий чиглэлийг дэмжиж байна. Энэ дээр компани болгон дээр зарим компанийг яг нэмэлт хувьцаа гаргана гэсэн байгаа юм. Зарим компани болохоор одоо байгаа төрийн өмчийн хувьцааг борлуулна гэсэн байгаа. Тэгэхээр энэ хувьчлалын жагсаалтад орсон байгаа компаниуд дээр бүгд дээр нь яг тийм бизнес төлөвлөгөө гарчихсан байгаа гэсэн үг үү одоо? Өөрөөр хэлбэл шинээр нэмэлт хувьцаа гаргахаар тэр нэмэлт гаргаад хувьцаа гаргаад босгосон мөнгөө эргүүлээд буцаагаад тухайн компанидаа зарцуулах гэж байна гэж ойлгож байна. Одоо байгаа төрийн өмчийн хувийг зарахаар бол төсөв өөрөө мөнгөтэй болох гэж байна гэж ойлгоод байгаа. Тэгэхээр яг энэ бүх компани дээр энэ тусдаа бизнес төлөвлөгөө нь тодорхой хэмжээнд гараад, тэгээд ойролцоогоор хэдэн төгрөг босгоё энэ тэр гэсэн ийм тооцоолол байгаа юм уу гэдэг нэг ийм асуулт байна 1 дүгээр асуулт?

2 дугаарт нь энэ Дорнод бүсийн эрчим хүчний систем төрийн өмчийн компанийн тодорхой үйл ажиллагааг нь шилжүүлнэ гээд. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ гээд төрийн өмчийн компанид шилжүүлсний дараагаар болохоороо байгаа хувиа худалдах талаар орсон байна л даа. Тэгэхээр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ гэдэг компани маань одоо үйл ажиллагаа явуулж байгаа компани уу, эсвэл шинээр компани байгуулах гэж байна уу гэдэг нэг ийм асуулт байгаад байна?

Дархан, Эрдэнэт хотын дулааны цахилгаан станцууд, дээрээс нь түгээх сүлжээ нь хувийн секторт байдаг гэж би ойлгосон. Тэгэхээр яг Дархан, Эрдэнэттэй адилхнаар Дорнодын Дорнод бүсийн эрчим хүчний систем компанийн цахилгаан үйлдвэрлэлийг нь тусад нь компани, түгээлтийг нь тусад нь хувийн компанид шилжүүлэх гэж байгаа ийм төлөвлөгөөтэй ажиллах гэж байна уу гэсэн ийм 2 асуулт байна.

Р.Сэддорж: 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тийм, хэн Соронзонболд гишүүн ерөнхийдөө зөв ойлгосон байна. Энэ хувьчлах, худалдах хамгийн гол нь энэ дээр нээлттэй, ил тод хөрөнгийн биржээр дамжуулаад олон нийтийн хяналт, олон нийтийн оролцоотойгоор гэдэг үндсэн зарчим барьж байгаа. Монгол Улсын Их Хурлаас бидний оруулж байгаа Их Хуралд оруулж байгаа тогтоол дээр ч гэсэн зорилго нь ийм зорилготой. Энэ ТӨК-ийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, олон нийтийн хяналтад оруулах, илүү стратегийн хөрөнгө оруулагчийг оруулж энэ компанийн үр өгөөжийг сайжруулах гэсэн зорилготой. Энэ компаниудыг хувьчлахдаа, худалдахдаа яг ийм үндсэн зарчмууд барина гээд зарчмыг нь тусгаад өгчихсөн байгаа. Иймэрхүү зохион байгуулж, иймэрхүү арга хэлбэрээр хэрэгжүүлнэ гээд оруулаад өгчихсөн байгаа. Энэ дагуу л үндсэндээ бүх зүйл бол Улсын Их Хурлын хяналт дор, олон нийт, иргэдийн хяналт дор явна.

Энэ компаниудын хувьцааг ихэнхийг нь бид нээлттэй нэмэлт хувьцаа гаргаад, түүнийгээ олон нийтийн оролцоотойгоор нээлттэй, ил тод дуудлага худалдаагаар явуулснаараа олсон орлогыг буцаагаад тэр компанийн үйл ажиллагааг сайжруулахад зарцуулна. Цөөхөн Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс критикал минералс гээд энэ компаниуд бол нөгөө Ашигт малтмалын тухай хуульд 10 хүртэл хувийг нь олон нийтэд нээлттэй арилжаална гэсэн хуультай учраас энэ хуулийн дагуу оруулж ирж байгаа. Үүнээс олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх. МИАТ компанийн тодорхой хувьцааг борлуулаад, үүнээс олсон орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлэх ийм л 33-аас 4 компани дээр төсөв рүү тодорхой хэмжээний хөрөнгө татагдах байх. Хэрвээ хувьчлал, хувьцаа худалдах арга хэмжээ амжилттай зохион байгуулагдвал.

Мөн дээрээс нь төрийн эзэмшлийн хувьцааг биржээр худалдана, арилжина гээд бас тодорхой компаниуд байж байгаа. Энэ компаниудыг үндсэндээ Дулааны шарын гол, Багануурын дулааны станц, Налайх, Хөвсгөл, Ховд дулаан, Улаангомын гэсэн эдгээрийг үндсэндээ дуудлага худалдаагаар худалдаад, энэний орлогыг төсөвт үлдэнэ. Бусад нь үндсэндээ төсөв рүү, юу компанидаа шингэж, компанийнхаа үйл ажиллагааг сайжруулах хөрөнгө оруулалт болж үлдэнэ. Цахилгаан түгээх болон цахилгаан үйлдвэрлэх компаниудыг олон нийтийн оролцоотой болгоё, олон нийтийн хяналттай болгоё, илүү үр өгөөжтэй болгоё, өртөг зардлыг нь бууруулах үүднээс тодорхой хувийг нь худалдъя гэж байгаа. Хувийн компанитай, хувийн оролцоотой болгоё гэж байгаа. Ингэхгүй бол үндсэндээ төрд 100 хувь байдаг, үүнийгээ дагаад үүний цаад талд нь яах уу хардлага сэрдлэг, нөгөө хулгай зэлгий, үүнээсээ болоод эрчим хүчний үнэ тариф өсөх, өртөг нэмэгдэх ийм асуудлууд гараад байгаа учраас хувийн оролцоотой болсноороо илүү үр ашигтай болно гэж үзэж энэ цахилгаан түгээх болон.../минут дуусав/

Р.Сэддорж: Жаргалан гишүүнийг асуулт дээр нэмье. Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Лодойсамбуу гишүүнийг хасъя. Соронзонболд гишүүн тодруулж асууна.

Л.Соронзонболд: Төрийн өмчийн компаниудын балансыг харахаар ер нь өр төлбөр нь авлагаасаа хэд дахин их тийм байдалтай байгаад байгаа. Тэгэхээр одоо зүгээр яах вэ төрийн өмчийн компаниудыг нээлттэй нэмэлт хувьцаа гаргаад, тэгээд орж ирсэн мөнгөөр нь буцаагаад өр төлбөрийг нь төлөх ч гэдэг юм уу иймэрхүү байдлаар явбал яг энэ нээлттэй гаргаж байгаа тэр хувьцааг чинь сонирхох хүмүүс байх уу, үгүй юү гээд нэлээн гарах байх. Тийм учраас энэ нэлээн баланс, тэр санхүүгийн байдлыг нь нэлээн эрүүл болгож байгаад, тэгээд араас нь тэр хувьчлал эд нараа хийвэл илүү зөв байх болов уу л гэж санагдаж байна. Тийм учраас төрийн өмчийн компаниудын юун дээр нэлээн сайн ажиллах ёстой байх л гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Үг хэлж байна уу? Санал хэллээ. Бямбацогт сайд хариулах юм уу үгүй юү? Улсын Их Хурлын гишүүн Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Төрийн өмчийн хуулийн этгээдийн хувьцааг нь нээлттэй худалдаад, хувьчлаад өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг өнөөдөр бүгдээрээ хэлэлцэж байна. Засгийн газарт Улсын Их Хурлаас энэ тогтоолын төслийг гаргаж өгөхдөө 26 оны хаврын чуулганаар энэ бичигдсэн байгаа зүйл, заалтад байгаа ажлуудыг хийгээд ир гээд орж ирж байна. Тэгэхээр 26 оны хаврын чуулган гэхээр чинь он гараад л байх нь байна шүү дээ тийм ээ. Тэгэхээр амжих уу гэдэг эхний асуулт байгаа юм?

Нийтийн өмчийн тухай хууль 2024 он, 25 оны 6 сарын 24-нд өргөн баригдаад, хэлэлцэх эсэх нь шийдэгдчихсэн байгаа. Тэгэхээр Нийтийн өмчийн тухай хууль батлагдаад, тэгээд түүн дээр байгаа утга агуулгаараа энэ тогтоолын төслийн нэгд бичигдсэн байгаа яг үл хөдлөх хөрөнгө, одоо яг хувьчлах зайлшгүй шаардлагатай юу гэдэг асуултад нь хариулах ёстой биш үү. Тэгэхээр эхлээд Нийтийн өмчийн тухай хууль батлагдаж байж, дараа нь Засгийн газар энэ ажлаа хийгээд, тэгээд орж ирнэ гэхээр 2026 оны энэ хаврын чуулганд амжих уу, эхний асуулт нь энэ байгаа?

Дараа нь болохоороо ингээд үзэл баримтлалыг судлаад үзэхээр 2001, 2005, 2010, 15, 22 гээд ойролцоогоор 5-аас 7 жилийн давтамжтай ингээд Улсын Их Хурлаас Засгийн газар луу тогтоол гардаг юм байна л даа. Тэгээд хэрэгжилт нь түрүүн Бямбацогт сайд үгэндээ ч хэлсэн 115 аж ахуйн нэгжийг зүгээр тоогоор нь яривал давхардсан тоогоор 115 юм байна, хувьчлагдсан нь 38 юм байна, тэгээд хэрэгжилт нь 33 хувьтай гэхээр мэдээж хамгийн түрүүнд л яагаад вэ гээд бодно шүү дээ тийм ээ? Тэгээд уншихаар яагаад нь бичигдээгүй байна л даа. Тэгэхээр 2 дахь асуулт болохоор яагаад хэрэгжилт ийм хангалтгүй байгаа юм бэ? Тэгэхээр өнөөдөр 2025 онд энэ чуулган хаахаас өмнө гарах Улсын Их Хурлын тогтоол хэрэгжинэ гэсэн баталгаа байна уу?

Яах вэ тэгээд юу болсон юм бол гээд уншингуут яг энэ үзэл баримтлалын танилцуулга дээр болохоороо Хөтөлийн цемент шохой ТӨХК-ийг хувьчилсан, тэгээд тэр нь бүтэлгүйтсэн тухай бичсэн байгаа юм, 2015 онд хувьчилсан юм байна. Тэгсэн 2022 онд Авлигатай тэмцэх газраас дүгнэлт гараад, хууль бус юм байна гээд Улсын Их Хурал руу шийдвэрийн төсөл явуулжээ 22 онд. Тэгээд энд ингээд биччихсэн байгаа нь одоо хүртэл Улсын Их Хурал дээр шийдвэрлэгдээгүй байна. 2024 оноос хойш шинэ Улсын Их Хурлын гишүүд бүрэлдээд ингээд ажиллаж байна. Энэ талаар мэдээлэл бол орж ирээгүй. Тэгэхээр 2025 онд энэ орж ирж байгаа компаниуд нь хувьчлагдлаа, дараа нь шүүх дээр очоод гацаад л, тэгээд хэзээ ч болохгүй асуудал ярьж байгаа юм шиг л уншигдах юм. Тэгэхээр ер нь энэ 2001 оноос хойш хийгээгүй ажлуудаа хий гээд манай энэ тогтоолын төсөл дээр бас бичсэн байна. Тэгэхээр бас яг найдвар байна уу?

Гуравдугаарх нь болохоороо бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх талаар орж ирээд 5 компанийг бичсэн байна л даа Эрдэнэс Монголоос авхуулаад. Тэгээд бүтэц, зохион байгуулалт гэдгийг би засаглалыг сайжруулах гэж ойлгоод байх юм. Зөв ойлгож байна уу? Нэмэлт минутаа авчхаад, гүйцээгээд асуултаа асуучихъя дарга.

Р.Сэддорж: 1 минут, Уянга гишүүн 1 минут.

Б.Уянга: Энэ засаглал өөрчлөх, засаглалыг сайжруулахтай холбоотой энэ бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх гэж орж ирж байгаа 5 компанийг яагаад ингэж орж ирж байгаа юм бол гэж судлаад үзэхээр та хэд ч бас биччихсэн л байна л даа. Засгийн газрын 24-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр энэ ТӨК-удын засаглал, ил тод байдлыг сайжруулаад, олон улсын менежментийн багаар удирдуул гээд биччихсэн юм байна. Шинэ итгэл-эрс шинэтгэл Монгол Улсыг 26-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүл, үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүл гэсэн юм байна. Тэгэхээр яг энэ 2 том зорилт дунд хугацааны төлөвлөгөөнд оролцсон ажлын хүрээнд энэ 5 компанийг оруулж ирж байна гэж харж байна. Яг нэрээр нь дурдвал Эрдэнэс Монгол байна, Цахилгаан дамжуулах сүлжээ байна, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ, Мэдээлэл технологийн үндэсний парк, тэгээд Авто импекс, Авто импексийг сайн

мэдэхгүй юм. Тэгэхээр яг энэ засаглалыг сайжруулна, бүтэц зохион байгуулалтыг өөрчилнө гэдэг нь яг яах юм бэ, ямар нэгэн тийм төлөвлөгөө эд нар байна уу?

Р.Сэддорж: 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Уянга гишүүн асуусан асуултдаа төгсгөлд нь бараг өөрөө хариулчихлаа. Тэгэхээр яагаад оруулж ирж байгаа юм бэ гэж Улсын Их Хурлаас энэ үндсэн чиглэлийг оруулж ир гэж 2024 оны 12 сарын 12-ны өдөр 52 дугаар тогтоол батлаад, Их Хуралд оруулж ирж танилцуул, энэ ТӨК-удын засаглалыг сайжруулах, хувьчлах, хувьцаат компани болгох, өөрчлөн зохион байгуулах энэ бодлогоо оруулж ир гэж үүрэг өгсөн. Энэ үүргийн дагуу Улсын Их Хуралд Засгийн газар оруулж ирж байгаа 1.

2 дугаарт нь Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг Улсын Их Хурал баталж өгсөн. Энэ дотор төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй ХК болгон үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүл. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүл гээд Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлаад өгчихсөн.

Мөн сая Шинэ итгэл-эрс шинэтгэл 2026-аас 30 оны хөгжлийн үндсэн чиглэлд сая та бас өөрөө хэллээ. ТӨК-ийн засаглалыг олон улсын компанийн засаглалын зарчимд нийцүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээлэл, ил тод байдал, хяналтыг сайжруул гээд ингээд заагаад өгчихсөн. Энэ хүрээнд Улсын Их Хурлаас өгсөн үүрэг чиглэлийг биелүүлж, Засгийн газар энэ асуудлуудыг оруулж ирж байгаа.

26 оны 3 дугаар улиралдаа багтаад энэ хэд чинь амжих юм уу гэсэн асуудал ярьсан. Тэгээд тогтоол дээр бид 26 оны хаврын ээлжит чуулгандаа багтаагаад Их Хурлаас баталж өгсөн тогтоол энэ 33 болох юм уу, 50 болох юм уу, эсхүл 20 болох юм уу ингээд нэг тогтоол гарах байх. Энэ тогтоолыг хэзээ, хэрхэн, яаж, ямар арга хэлбэрээр, ямар зорилгоор, ямар үр дүнд хүрэхийн тулд, ямар ач холбогдол өгч хувьчлах вэ, хувьцаат компани болгох вэ, зарах уу, борлуулах уу гэдгээ жагсаалтаа яг ийм арга хэлбэрээр ингэж оруулж ирнэ гэдгээ Засгийн газарт юу, Их Хуралд оруулж ирнэ. Их Хуралд танилцуулж, Их Хурлаас зөвшөөрөл авсны үндсэн дээр 2026-аас 28 он хүртэл хугацаанд үе шаттайгаар ХК болгох хувьцааг нь зарж борлуулах нээлттэй энэ ажлууд хийгдэнэ. Энэ ажлууд.

Яг таны ярьсан Нийтийн өмчийн тухай хууль, Компанийн засаглал, үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай хууль гээд 2 хуулийг Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа Засгийн газраас. Энэ 2 хуулийг Их Хурал яаралтай батлаад өгчихмөөр байгаа юм. Батлаад өгчихвөл энэ хуульдаа нийцүүлж яг энэ хуульд маш том өөрчлөлт гарна. Энэ хуульдаа нийцүүлж бид бүхэн энэ үндсэн чиглэлийг тийм үү төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд биржээр нээлттэй худалдах, хувьчлах энэ бодлогоо хэрэгжүүлнэ. Ингэж хоорондоо ажил уялдана. Цаг.../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Уянга гишүүн 1 минут.

Б.Уянга: Тийм, 3 өөр асуулт асуусан. Хариулт байхгүй учраас асуусан шүү. Нийтийн өмчийн тухай хууль баталсны дараа энэ тогтоол дээр бичигдсэн 26 оны хаврын чуулганд өргөн барина гэсэн яг хувьчлах эсэхийг нь судлаад оруулж ир гэсэн энэ ажил чинь хийгдэхээр харагдаж байгаа. Яагаад вэ гэвэл хууль нь одоо орж ирэхгүй юм чинь хаврын чуулганаар батлагдаж таарна, тийм. Тэгэхээр яг нэг тийм реалистик байдлаар 2026 оны намрын чуулган ч юм уу тэгж оруулж ирэх бол саналыг гаргахаар юм байна.

Тэгээд сүүлийнх нь асуудал болохоор энэ засаглалыг сайжруулна гээд энэ бүх энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр эд нартай танилцчихсан юм байгаа юм. Тийм учраас өгүүлбэрүүдийг нь зүгээр ингээд дахиж хэлэхгүйгээр яг засаглалыг сайжруулж, бүтэц зохион байгуулалтыг сайжруулахын тулд яг юу хийх гэж байгаа юм бэ? Тэрэндээ хариулт өгөөрэй.

Р.Сэддорж: 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Нийтийн өмчийн тухай хууль анхдагч хууль. Энэ хуулийг Засгийн газраас Их Хуралд өргөн барьсан. Энэ хуулийнхаа үзэл баримтлалтай нийцүүлж энэ Улсын Их Хурлын тогтоол үндсэн чиглэлийг Их Хуралд өргөн барьж байгаа. Тийм болохоор үндсэндээ Нийтийн өмчийн тухай хууль хурдан батлаад өгчихвөл, хэрвээ өөрчлөгдвөл үүнд нийцүүлээд бид хаврын чуулганаар оруулж ирэх тогтоолынхоо төслийг оруулаад ирнэ. Нийтийн өмчийн тухай хууль үндсэндээ энэ батлагдаад, дараад нь жагсаалтаа тийм үү хэрхэн, ямар арга хэлбэр гэдэг асуудлаа ярина шүү дээ. Тийм болохоор Нийтийн өмчийн тухай хуулийн дараа бол хаврын чуулган гэдгийг хойшлуулаад оруулж ирэх бололцоотой уялдуулах.

Засаглалыг сайжруулах гэдэг дээр бид тийм үү олон улсын аудит, аудит хийнэ, хөндлөнгийн үнэлгээ хийнэ, хараат бус болгоно. Дээрээс нь гаднын гадна, дотнын менежмент оруулж ирэх, мөн энэ нийтийн ТӨК-удын ил тод байдлыг илүү хангах ийм олон цогц арга хэмжээнүүд авч хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээний үр дүнд үндсэндээ энэ компанийн засаглал сайжирна гэж.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут 3 номер.

С.Бямбацогт: Тэр Хөтөлийн цемент шохой ХК-ийн алдаа давтагдчих юм биш байгаа гэж болгоомжилж байна зөв. Эхнээсээ л Засгийн газар өргөн бариад, Их Хурал батлахдаа ямар нэгэн тийм үү хууль зөрчөөгүй, хуудуутай биш тогтоол батлаад, тэр нь Засгийн газар хэрэгжүүлэхдээ бас хууль зөрчихгүй, хуудуутай биш хэрэгжүүлээд явчихвал энэ өмч хувьчлал буцаад шүүх дээр очоод 10 жилийн маргаан болохгүй. Тийм болохоор Их Хурал ч хууль батлахдаа маш тодорхой, бүгдэд тэгш боломж олгосон, нээлттэй, ил тод хууль баталж өгөх. Түүнийг хэрэгжүүлж байгаа Засгийн газар ч гэсэн ямар нэгэн хуулийн зөрчил, ашиг сонирхлыг хавчуулахгүйгээр батлаад өгвөл энэ Хөтөлийн цемент шохойн үйлдвэр компанийн хувьчлал алдаа давтагдахгүй. Ийм алдаа олон гарч байгаагүй. Тийм болохоор аль болох хаана хаанаа бүгдэд тэгш боломж олгосон нь нээлттэй, ил тод хууль зөрчихгүй байхаа л барьчихвал асуудал үүсэхгүй.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Очирбат асуулт асууна.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Тэгээд сүүлийн үед манай Монгол Ардын намынхан чинь тийм их сайхан аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн, чөлөөт эдийн засгаа

дэмжсэн гэж ярьдаг. Тэгээд энэ тайланг харахад сүүлийн энэ 30 жил ялангуяа энэ ТӨК-уд дээр ямар ч өөрчлөлт шинэчлэлт хийсэн юм байхгүй байна шүү дээ. Тэгээд энэ чөлөөт зах зээл, эдийн засгаа ярьж байвал энэ ТӨК-уд төрд ер нь компани байх ямар хэрэг байгаад байгаа юм Бямбацогт сайдаа? Үгүй ээ энэ дээрээ та бодлогын бүр тодорхой юм оруулж ир л дээ. Тэгээд нэг ийм тогтоолын төсөл оруулж ирдэг, нэг хийсэн болдог, бид нэг хэлэлцсэн болдог, баталсан болдог. Тэгээд та энэ тайлангаа хар л даа. Урьд нь энэ чинь өчнөөн 4, 5 удаагийн ийм Их Хурлын тогтоол гаргаад, 33 хувийн л биелэлттэй байна шүү дээ. Ийм байж болохгүй гэж зарчмын хувьд харж байгаа 1.

2 гэвэл энэ ТӨК-удын нийт хөрөнгө нь Дотоодын нийт бүтээгдэхүүний 74,3 хувьтай тэнцэж байна гээд байгаа юм. Тэгээд бизнес яаж амьдрах юм бэ? Ямар ч боломжгүй болсон ААН-үүд. Энэ 101 компанийнхаа жагсаалтыг харчих, дандаа өрсөлдөх боломжтой салбар төрийн өмч яваад орчихсон, тэгээд төрийн өмчийн компани болохоор ААН-үүд орж чаддаггүй, эрх мэдлээр дарамталдаг, болохгүй бол ТӨК-уддаа хөнгөлөлттэй зээл өгчихдөг. Би хэлээд байгаа шүү дээ тэр Монголбанкийг хүртэл Засгийн газрын банк болгох гэж та нар ер нь оролдож байгаа шүү сүүлийн үед. Бараг оролдох чинь биелчихсэн дээ, түрүүн тэр бензиний сав авахтай холбоотой, урьдын ковидтой холбоотой гээд олон юман дээр ийм юм гарчихсан байгаа.

Нэг дэх асуулт энэ хувьчлалыг үр дүнтэй зохион байгуулах үүднээс эхний ээлжид дараах 33 компанийг нээлттэй хувьцаа гаргана гээд байгаа юм. Энэ 33 компаниа яаж, ямар шалгуур үзүүлэлтээр, яаж сонгон шалгаруулсан юм бэ нэг дэх асуулт?

2-т гэвэл ингэж байгаа юм. Үндсэн чиглэлийн буюу энэ 18 ТӨК-удын төрийн мэдлийн 10-аас 66 хүртэлх хувийн хувьцааг нийтэд биржээр худалдаж, нээлттэй компани болгох гэж байгаа юм. Аль компанийн 10 хувийг юм, аль компанийн 30 хувийг юм, аль компанийн 66 хувийг юм энэ дээрээс тодорхой хариулт авчихмаар байгаад байна.

Мөн хамгийн сүүлийн асуулт 2024-өөс 28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр энэ дээр юу орсон гэхээр энэ ТӨК-удыг сайжруулах чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компаниудаас аудиттай хамтарч ажиллаж үйлчилгээ авна гэж төсөв дээр мөнгө суулгаж байсан санагдаад байгаа юм. Энэний үр дүн хаанаас, ямар аудит аваад, ямар хэмжээний тайлан гарсан бэ?

Хамгийн сүүлийн асуулт энэ олон улсын менежментийн багаар удирдуулна л гээд байдаг. Тэр нь ямар зөвлөгөө аль компани, аль олон улсын менежментийн компаниар удирдуулаад, нөгөөдүүл нь ямар зөвлөмж өгчихсөн юм бэ? Тэгээд энэ асуултууддаа хариулт авчхаад тодруулъя.

Р.Сэддорж: 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Өнгөрсөн 35 жил үндсэндээ 91 оноос хойш шүү дээ. Өмч хувьчлах гээд нөгөө ягаан, цэнхэр тасалбар, дараа нь ТӨК-удыг нөгөө Баянгол, Их дэлгүүрээс нь авхуулаад хувьчлах барих гээд, цаашлаад ингээд сүүлийн үед жоохон амжилтгүй болоод байгаа энэ бүх алдаа оноо бол бүгдтэй нь л холбоотой байх. Энэ дээр юу гэдэг юм Ардын нам, Ардын нам гээд бие бие рүүгээ нэг их чичлээд байх шаардлагагүй. Тийм болохоор энэ дээр та бас юу яах ёстой байдаг,

Ардын намынхан гэхээрээ л өмч хувьчилж чаддаггүй, бизнес хийж чаддаггүй гэдэг зүйлээр ярих хэрэггүй та.

Сүүлийн үед энэ асуудлууд байсан, алдаануудыг засаад л явж байгаа, алдаануудыг. Зөвхөн Эрдэнэт үйлдвэрээр хэлэхэд Эрдэнэт үйлдвэр дээр 3 хулгай байсан. Гэрээний хулгай гэж зэсийн баяжмалын агуулгыг бага байлгаж байгаад гадаад гэрээ хийгээд, хулгай хийдэг байсан. Энийг биржээр дамжуулж зардаг болсон, гэрээний хулгайг таслан зогсоосон. Дахиад шахааны янз янзын тендерт бараа материал шахдаг байсан, энийг хиймэл оюун ухаан ашиглаж сонгон шалгаруулалт тендер шалгаруулдаг болсон. Энэ шахааны хулгай алга болж байгаа. Овоолгын хулгай гээд нөгөө стратегийн орд болсон овоолго зэсийн баяжмалын овоолгуудыг бүгд компаниуд авчихсан байсан үүнийг цэгцэлж байгаа. Иймэрхүү байдлаар урьд өмнө нь гарсан тэрний энэнийх гэхгүй алдаануудыг засаад, үйл ажиллагаа нь сайжирч байгаа. Урьд нь бол ерөөсөө Эрдэнэт гэхээр л бөөн шахаа, бөөн улс төрч, бөөн дарга нар л тэнд шахаа хийж мөнгө олж байдаг гэсэн ойлголт одоо бол байхгүй болсон. Иймэрхүү байдлаар ингээд аль болох сайжруулчих гээд оролдоод л яваад байгаа.

Эрдэнэс Тавантолгой дээр нүүрсний гэрээнүүд 580 хэдэн гэрээ бүгдийг нь ил болгосон. Хэний үед, ямар үнээр, ямар гэрээ хийж, ямар, яаж нүүрс хулгай хийж байсан тэрийг бүгдийг нь хараад мэдчих бололцоотой болсон. Манай Жаргалан гишүүн санаачилсан. Энийг бид хамтраад бодитой, хурдан хугацаанд ажил хэрэг болгосон. Иймэрхүү байдлаар үндсэндээ асуудлыг ингээд шийдээд явж байгаа.

33 хувийн биелэлт гэдэг дээр бас л нэг худалдах гээд л, хувьчлах гээд л, хувьцааг нь зарах гээд л ингээд оролдоод, тэр оролдлогууд нь амжилтгүй болоод байсан юм байна лээ. Тийм болохоор өнгөрсөн хугацааныхаа алдаа оноон дээрээсээ сургамж, дүгнэлт хийгээд, цаашдаа ингээд явбал зөв болох юм биш үү гэдгийг гаргаж ирж байгаа юм. Компаниудыг бид стратегийн ач холбогдолтой компаниуд дээрээ тодорхой хувь нь төрд байг, тодорхой хувь нь хувьчилъя. Нийгмийн ачаа үүрдэг, хариуцлага хүлээдэг компаниудаа яах аргагүй хувьд шилжүүлэх гээд, худалдах гээд хүн авахгүй юм чинь энийг төр аваад явахаас өөр аргагүй. Бизнесийн өрсөлдөөн тийм үү, хувийн хэвшилтэй өрсөлдөөд байгаа компаниудыг аль болох чөлөөтэй худалдах, хувьд шилжүүлэх ийм л бодлого барьж, ийм 3 ангилж оруулж ирсэн. Энэ 3 ангиллын хүрээнд 33 компаниудыг яг энэ компаниуд нь ийм зарчмаар, тэр компаниуд нь тийм зарчмаар гэдгээ тодорхой танилцуулга дээр бичсэн байгаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах 2 номер, 3 номер 1 минут.

С.Бямбацогт: Тийм олон улсын менежментийг хийх гээд Эрдэнэс Тавантолгой компани дээр олон улсын менежментийн багийн олон улсын тендер зарлаад компани оролцоогүй. МИАТ компани дээр бас олон улсын менежментийн зөвлөх компани ирж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Энэ дээрээс бид ингээд цаашдаа аль болох олон улсын менежмент орвол компанийн үнэ цэн, бидний алдаануудыг олж хараад илүү үр ашигтай, илүү менежмент нь сайжраад явчих бололцоотой. Тэгвэл энэ компанийнх нь өнөөдөр үнэлэгдэж байгаа үнэлгээ хэд дахин нэмэгдэх бололцоотой юм. Ийм байдлаар ялангуяа МИАТ компани дээр энэ олон улсын менежментийн баг авчрах, мөн томоохон стратегийн ач холбогдолтой компаниуд дээрээ зөвлөх үйлчилгээ авах ийм бодлогуудыг барья гэдгээ энэ өөрчлөн зохион байгуулах гэдэг дотор оруулсан байгаа. Ийм байдлаар тодорхой өөрчлөлтүүдийг менежментээр ирвэл, гаднын менежмент оролцвол илүү сайжирч магадгүй гэж.

Олон улсын аудит бол Тавантолгой компани дээр орсон, бас өөр Төрийн аудитын Төрийн банкин дээр орсон байгаа.

Р.Сэддорж: Тодруулах юм уу? Очирбат гишүүн тодруулж асууна.

Г.Очирбат: Ингээд 126 Их Хурлын гишүүнтэй шинэ парламент байгаа. Юм ил тод нээлттэй, шилэн болох ёстой. Тийм болохоор хэлж байгаа юм. Зөвхөн Эрдэнэс Монгол компанийн доор 21 компани ингэж хийсэн. 21 компаниас нь бараг 18, 9 нь ингээд ашиггүй ажилладаг, зөвхөн мөнгө үрдэг. Эрдэнэс Тавантолгой компанийн олж байгаа орлого, ашиг бүгд ингээд зүгээр үнэнээ л хэлье. Төрийн өмчит, Төрийн өмчийн хороогоор дамжуулж Монгол Ардын намын сонгуульд ажилласан буюу ажил, албан тушаал дээр тавих ийм орон тоо л болсон шүү дээ, Бямбацогт сайдаа та мэдэж байгаа шүү дээ. Одоо хэдүүлээ жоохон шударга байя л даа, энэ улс эх орноо бодъё. Тийм болохоор энийгээ нээлттэй энэ 10-аас 66 хувь гэхгүйгээр ер нь энэ Монгол төр өөрөө энэ ТӨК-удыг бодлогоор дэмжье. Ялангуяа тэр дэд бүтцийн асуудлууд, хөгжих боломж бололцоотой хууль, эрх зүйн орчныг нь сайжруулж өгье. Бидэнд энэ төрд энэ ТӨК-уд хэрэггүй юм гэдгээ зарлаад явмаар байгаад байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол бид энэ тамын тойргоосоо гарахгүй шүү дээ. Жил болгон л нэг ийм юм.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер.

С.Бямбацогт: Маш чухал асуудал Очирбат гишүүн хөндөж байна. Бид яг нээлттэй, ил тод, хараа хяналттай болгох тал дээр л ерөөсөө л Засгийн газрын бодлого явж байгаа. Урьд өмнө нь хаалттай байдаг, тэгээд л нөгөө цүнх баригчид томилогддог, хяналтгүй болчихдог ийм байсан бол ерөөсөө аль болох нээлттэй ил тод болгох. Энэ хүрээндээ Засгийн газар өнгөрсөн сард ТӨК-удын хөрөнгийн байдал, санхүүгийн орлого, зарлагын гүйлгээ, худалдан авалт, зардал, санхүүжилт, томилгоо бүх зүйлүүдийг нээлттэй болгох, тийм нээлттэй мэдээллийн нэгдсэн систем бий болгож байгаа. Эндээс иргэд, аж ахуйн нэгж хэн нь ч дараад Эрдэнэс Тавантолгой дээр ямар томилгоо хийгдэж байна, ямар худалдан авалт хийгдэж байна, ямар зардал гарч байна энэ бүгдийг нээлттэй болгох ийм байдлаар үндсэндээ засаглалыг сайжруулах гол том бодлого энд явж байгаа. Аливаа зүйл ил тод, нээлттэй, шилэн байх тусмаа л илүү хараа хяналттай, илүү хууль зөрчихгүй, хулгай хийгдэхгүй болно. Ийм бодлого барьж байгаа гэдгийг танд хэлье. Тэгээд 10.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут 3 номер.

С.Бямбацогт: Тэр 3 компани дээр 10 хувийг нь Эрдэнэт, Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс критикал минералс гэсэн 3 компани дээр бид 10 хувийг нь нээлттэй, ил тод хувьцаа хөрөнгийн биржээр дамжуулж хувьцааг нь заръя гэж байгаа иргэддээ. Бусад компаниуд дээр энэ бол нөгөө Ашигт малтмалын тухай хуульд заачихсан учраас ингэж хууль хэрэгжүүлж байгаа. Бусад компаниуд дээр үндсэндээ Их Хурал дээр шийдэгдээд, Их Хурал жагсаалтыг нь батална энэ 33-ыг 40 болгох уу, эсхүл 20 болгох уу, 30 хувь гэх үү, 34 хувь гэх үү, 66 хувь гэх үү, 100 хувь гэх үү Их Хурлын өөрийн бүрэн эрхийн асуудал. Тийм болохоор Засгийн газар ямар ч байсан төслөө өргөн барьсан, хувьчил 100 хувь гэвэл 100 хувь хувьчлах бололцоотой. Ер нь аль болох өрсөлдөөнд суурилсан аж ахуйн нэгжүүдийг Монголын цахилгаан холбоо компани, бусад өөр юу байдаг тийм үү МИАТ, бусад МИАТ биш ээ, тэгээд Монгол шуудан зэрэг компаниудыг бид аль болох 100 хувь

хувьчлах нь зөв байх гэж бодож байгаа. Гэхдээ 100 хувь гэвэл яах бол гэж бодоод Их Хуралд 100 хувь болгох нь нээлттэй байгаа. Энд бол та бүхний бүрэн эрхийн асуудал.

Р.Сэддорж: Очирбат гишүүн сүүлийн 1 минут.

Г.Очирбат: Ганцхан л жишээ хэлье. Монгол Улсад 12-оос 16 онд дэлхийн зах зээлээс асар их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх сонирхлууд бий болсон. Дээрээс нь хувийн хэвшлүүд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр хувийн хэвшлийнхэн ажиллаад, тэнд гангийн үйлдвэр барих цогцолборын бүхэл бүтэн төсөл хэрэгжээд явж байсан. Төр орж ирээд энийг самарч дуусгасан. Би Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд яг энэ асуудлыг хариуцаад ажлын хэсэг дээр ажиллаж байсан. Одоо татан буугдчих, татан буугдаж байх шиг байна. Тэгээд яг энэ мэтчилэн хувийн хэвшил орж ирээд, гаднын зах зээлээс мөнгө татаж орж ирээд, нэг бол өөрийнхөө хөрөнгө оруулалт хийх гээд ажил хийх гэхээр төр орж самардаг. Тэгээд энэ яаж байна гэхээр ТӨК-уд төр хэтэрхий ТӨК-удыг энэ олон жил бойжуулсан болохоор л үр дүн нь ингэж гарч байгаа. Тэгээд одоо бид хар даа та төсөв тасарчихсан, гадагшаа, дотогшоо томилолтоор явна хөрөнгө оруулалт татах гэхээр ямар ч боломжгүй. Монгол Улс дэлхийд хаалттай болж байгаа шүү.

Р.Сэддорж: 3 номер.

С.Бямбацогт: Санал нэг байна. Тэгээд ер нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцсон газар бол хүн хөрөнгөө үхмэл хөрөнгө болгохыг, эрсдэлд оруулж хохирохыг боддоггүй. Төрийн өмч дээр цаад талд нь юу гэдэг юм хувийн ашиг сонирхол яваад байдаг учраас асуудалтай байдаг. Тантай санал нэг байна. Тийм болохоор бид урьд өмнөх алдаануудыг давтахгүйн тулд одоо жишээ нь Эрдэнэс Тавантолгой дээр тэр нөгөө нүүрс угаах үйлдвэр гээд нэг юм хийгээд хаячихсан, тэр нь ашиггүй болчихсон, шал үр ашиггүй, үхмэл хөрөнгө болчихсон байж байна. Тэгээд ... гээд нэг юм хийчихсэн, тэр нь үхмэл хөрөнгө болчихсон, үр ашиггүй байж байна. Үүнтэй адилхан зэс хайлуулах үйлдвэр, ган боловсруулах үйлдвэрүүд дээр бид төр хувь эзэмшихгүй, ТӨК хувь эзэмшихгүй, төр гадаадын, дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдыг өөрсдөө хөрөнгөө оруулаад, өөрсдөө хувьцаагаа эзэмшээд, өөрсдөө менежментээ явуулаад, өөрсдөө технологио явуулах ийм олон улсын нээлттэй тендер зарлаж, цаашдаа ийм нээлттэй байдлаар хувийн хэвшил, энэ дотор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах ийм бодлого барьж байгаа. Ийм.../минут дуусав/

Р.Сэддорж: Чинбаатарын Анар гишүүн.

Ч.Анар: Бямбацогт сайдаас асууя. Энэ хувьчлахаар оруулж ирсэн ТӨК-удын жагсаалт энэ яг хувьчлагдах уу? Урьд урьд нь миний санахаар 2008 онд хувьчилна гээд Засгийн газрын тогтоол гарч байсан. 13, 14 онд тогтоол гарч байсан. Тэгээд Их Хурлаас гаргасан тогтоолууд хэрэгждэггүй. Энэ зүгээр худлаа хоосон PR биш биз дээ, яг хувьчлагдах уу? Тогтоол болгонд итгэхээ больчихоод байна л даа. Бид тогтоол гаргаад л, хийгээд л, хууль гаргаад л байдаг хэрэгждэггүй. Тэгээд энд юу ч хийж сууж байгаа юм мэдэхгүй.

2 дугаарт та нөгөө гаднын хөрөнгө оруулалт менежментийг оруулж ирнэ гээд сая дурдаж байна. Тэгтэл Төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн тухай хуулийн 56.5, 4.1.29-д зааснаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гээд 5 хувиа

хязгаарлачихсан Төрийн болон аж ахуйн нэгж. Энэ дээр ямар ч гаднынхан орж ирэхгүй шүү дээ. Нөгөө банкин дээр бас хязгаарлачихсан байдагтай адилхан, гаднын банк орж ирэхгүй байна гээд байдаг. Гаднын банк орж ирэх бололцоо нь байгаа, тэр хязгаараас орж ирдэггүй. Тэгэхээрээ 5 хувь дээр ийм хүнд сурталтай, улс төр нь ойлгомжгүй улс дээр гаднын менежмент хөрөнгө оруулагч орж ирэхгүй. Энийгээ тогтоолын төслийгөө дагуулаад, хуулийн төслөө боловсруулаад, нэмэлт, өөрчлөлтөө боловсруулж оруулж ирэхгүй бол болохгүй. Энэ судалгаагаа хийсэн юм уу 2 дахь асуулт?

3 дугаарт нь ТӨК-удыг олон нийтэд нээлттэй Хөрөнгийн биржээр дамжуулна гэж байгаа юм. Гэтэл энэ хамгийн гол суурь болсон Хөрөнгийн биржийг нь хувьчлах талаар, менежментийг нь солих талаар бэлтгэл ажил судалгаа хийгдсэн юм уу? Энэ дээр жишээ нь Хөрөнгийн биржээс асууя. Дэлхий дээр Хятадаас өөр Шанхай, Шиньжиний хөрөнгийн биржээс өөр төр нь эзэмшдэг хөрөнгийн бирж хэд байдаг вэ? Тэгэхээр яагаад одоо энэ 49 хувиа эзэмшээд, яагаад төр яагаад хөрөнгийн бирж ажиллуулах гээд байгаа юм бэ? Тэгээд гаднын хөрөнгө оруулагч нь орж ирэх бололцоогүй, менежмент байхгүй, нэг баахан компани IPO хийсэн, нээлттэй болсон нэртэй. Тэгэхдээ хөрвөх чадвар байдаггүй, гаднын хөрөнгө оруулагч орж ирэх боломжгүй тэгээд ийм хөрөнгийн биржээр энэ компаниудаа нээлттэй болгоод үр дүн гарах уу? Энэ 3 дээр асуулт асуугаад, дараа нь тодруулъя.

Р.Сэддорж: Хариулт Бямбацогт сайд 3 номер, дараа нь Хөрөнгийн бирж.

С.Бямбацогт: Би бас одоо манай гишүүдийн асууж байгаа асуултад сэтгэл их хангалуун байна. Бид яг илүү чөлөөтэй, илүү нээлттэй, илүү либерал байх ёстой. Тэгээд Анар гишүүнтэй, сая Очирбат гишүүнтэй, манай Уянгаа гишүүн гээд бүгдээрээ асууж байгаа юмнууд дээр яг ингэж л хэлэлцээд нэг зөв юм баталчихвал илүү үр дүнтэй болох байх, зөв болох байх, хэрэгждэг болох байх. Урьд нь ингээд 2001 онд Их Хурлын баталсан тогтоол 30 хувийн хэрэгжилттэй, 2005 оных 45 хувийн хэрэгжилттэй, 2010 оных 11 хувийн хэрэгжилттэй, 2015 оных 16 хувийн хэрэгжилттэй, 2022 оны үндсэн чиглэл 29 хувийн хэрэгжилттэй байгаа юм. Тэгэхээр энэ удаа хэдүүлээ нийлж байгаад нэг ядаж 60, 70 хувь, 80 хувийн хэрэгжилттэй тогтоол болгочихвол энэ Их Хурлын нэг амжилттай, үр дүнтэй, олон жил үр дүн өгөхгүй байсан ажлыг урагш нь ахиулсан ажил болох байх. Тийм болохоор манай Их Хурлын гишүүдийн гаргаж байгаа энэ ажил хэрэгч, их илүү задгай ярьж байгаад, задгай яриасай ч гэж бодож, чөлөөтэй оруулж ирсэн. Тийм болохоор 80 хувьтай хэрэгжилттэй болгохын тулд хэдүүлээ хамтраад сайхан ажиллая гэдгийг 1 дүгээрт нь хэлье.

2 дугаарт нь тэр ТӨК-ийн 5-хан хувьтай байхад яаж хүн орж ирэх юм бэ гэж санал нэг байна. Банкнууд дээр ч зөвхөн 20 хувь гэгчихсэн байж байгаа. Ингээд ийм хачин хязгаарлалтууд дээр хэн ч орж ирэхгүй. Тийм болохоор аль болох ахиу хувь, яг стратегийн ач холбогдол бүхий гэсэн үзсэн салбар дээрээ төр тодорхой хувь эзэмшье. Бусад дээр нь аль болох тийм үү 100 хувь хүртэл, таны хэлж байгаа Хөрөнгийн бирж дээр бид бас 100 хувь гээд оруулаад ирвэл та нар хөрөнгийн биржгүй болох гэж байна гээд л поп улсууд нь босоод ирчхэж магадгүй. Тийм болохоор дундуур нь оруулчихъя. Их Хурал маань 100 хувь болговол тэгээд санал нэгдээд дэмжээд явчихна. Нэг ийм байдлаар л нэг жоохон чөлөөтэй оруулж ирж байгаа шүү. Хэрэв оруулж ирэхгүй байвал оруулж ирсэнгүй гэнэ.

Тийм болохоор оруулаад, хэрвээ 100 хувь гэвэл нийлж байгаад хуйвалдаад хулгай хийх гэж байна гэж хардана. Тийм болохоор бид сайхан тэгээд л та бүхэндээ

оруулаадахъя, оруулж болох бүгдийг оруулчихъя. Тэгээд та бүхэн маань чөлөөтэй ярьж байгаад нэг шийдэл гаргаад өгөөч. Ер нь аль болох төрийн оролцоог багасгая. Төрийн, зайлшгүй төрд байх өмч тийм үү, ТӨК-удынхаа үр ашгийг нэмэгдүүлье гэсэн гол үндсэн зарчим, бодлогоо л барьж байгаа гэдгийг бас хэлье.

Бирж дээр тэр Хөрөнгийн биржийнхэн бас тэгээд шинэ захиралтай болсон. Ер нь Хөрөнгийн биржийг бид чинь Лондоны бирж рүү нэг оролдож үзээд, Сингапурын биржийн менежмент оруулах гэж үзээд л оролдсон. Яг үнэндээ сая сүүлийн үед уул уурхайн бирж энэ дээр үйл ажиллагаа явуулж байж үр ашиг нь нэмэгдсэн. Манайд хөрөнгийн зах зээл, санхүүгийн зах зээл гэдэг үнэхээр уначихсан байгаа. Банкнууд нь л мангас болчихсон, хэдэн банк бусууд, дээрээс нь хөрөнгийн зах зээл дээр хувьцаа биржийн арилжаа бол үнэхээр уначихсан байж байгаа. Одоо бол тэгээд өөрсдөө их сайн ажилласан гэж хэлж магадгүй. Үгүй.

Р.Сэддорж: Анар гишүүн тодруулж асууя.

Ч.Анар: Хөрөнгийн биржээ зоригтой хувьчлахгүй бол ямар ч менежментийн компани ашиг сонирхол нь орж ирэхгүй болохоор сайн ажиллуулахгүй. Лондонтой бол зүгээр л систем авсан шүү дээ. Одоо бол ингээд энэ гаднын хөрөнгө оруулалтыг маш богино хугацаанд татаж оруулж ирэх бололцоо бол Хөрөнгийн биржээ нээлттэй болгоод, Токиогийн хөрөнгийн бирж, Солонгосын хөрөнгийн бирждээ менежментийг нь өгчихмөөр байгаа юм тэр хуулиа өөрчлөөд. Тэгвэл Монголын эдийн засагт банкнаас гадна, одоо гаднын хөрөнгө оруулалт зогсчихсон. Түрүүн Очирбат гишүүн үнэн л хэлж байгаа, бодитой үнэн байдлаараа зогсчихсон шүү дээ. Ийм улс төрийн эрсдэлтэй газар орж ирэхгүй. Тэгэхээр Хөрөнгийн биржээ эхлээд цэгцлэх ёстой. Тэгэхийн тулд Цэнгэл даргатай би санал солилцсон. Протокол дээр асууя. Хөрөнгийн биржийг хувьчлах сонирхол байдаггүй шалтгаан нь газар байшинд нь болоод байдаг юм шүү дээ. Тэгэхээр Төрийн өмчийн хороо тэрийгээ тусад нь хувьчилж, дуудлага.../минут дуусав/

Р.Сэддорж: 2 номер Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Бид 22-оос 23 оны үндсэн чиглэлд Хөрөнгийн биржийг 34 хувийг нь нээлттэй болгох ажлыг хийсэн. Одоо хоёрдогч зах зээл дээр хувьцаа нь гараад явж байгаа. Бид энэ удаад дараагийн алхам болгоод нэмж 15 хувь буюу 49 хувийг нээлттэй болгоё гэдэг байдлаар оруулж байгаа юм. Ер нь таны хэлж байгаа зөв. Ер нь бусад орнуудын Хөрөнгийн бирж бол бүгд хувийн ийм чиглэл рүүгээ явсан, төрд байдаг хөрөнгийн бирж ер нь ховор, байхгүй талдаа. Тэгэхээр энийг бол яах вэ Их Хуралд бүрэн эрх нь байгаа. Одоо бид 49, 51 гэж явж байгааг хувийн хэвшлийнх нь юуг нь давамгайл байдлаар энийг бол оруулж болохгүй юм байхгүй. Ер нь хөрөнгийн бирж 34 хувиа гаргаад туршлагатай болсон. Ямар ч байсан таны хэлсэн саналуудыг тусгаад, ингээд Их Хурал дээр хэлэлцүүлэг дээр ингээд угаасаа энийг ярих учраас энэ бол нээлттэй яригдаж болох байх гэж бодож байгаа.

Р.Сэддорж: Анар гишүүн 1 минут сүүлийн.

Ч.Анар: Цэнгэл дарга нөгөө тодорхой асууж байгаа нь Хөрөнгийн биржээс Төрийн өмчийн хороо өөрийн эзэмшлийн газар, барилгыгаа тусдаа дуудлага худалдаагаар оруулаад, хөрөнгийн биржээ хувьчилж чадах уу, тийм зохицуулалтыг хийх бололцоотой юу гэдгийг 1 дүгээрт асууж байгаа юм?

2 дугаарт тэр Их Хурлын гишүүд та нарт эрх нь нээлттэй гээд байгаа. Гэхдээ хөрөнгийн бирж маань өөрөө энэ чиглэлийнхээ судалгаагаа бидэнд танилцуулах ёстой шүү дээ. Судалгаагаа хийсэн үү гээд хамгийн анхны асуулт дээр асуусан. Энэ 2 асуултынхаа хариултыг авъя.

Р.Сэддорж: 3 номер.

С.Бямбацогт: Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага. Улсын Их Хурал бол төрийн бодлого тодорхойлдог, тэгээд Улсын Их Хурал дээрээс Хөрөнгийн биржийг байрыг авч үлд, тэр түүхэн дурсгалтай, маш үнэ цэнтэй газар дээр байгаа учраас энийг авч үлдээд, харин Хөрөнгийн биржийнхээ тэр үйл ажиллагаа, менежментийг нь тийм үү чөлөөтэй хувьчлаад тэр эрхийг нь хувьчил гээд ингээд шийдвэр гаргачихвал бид яг л тэгж хэрэгжүүлээд явчихна. Ингэж шийдвэр гаргах нь зөв байх. Үнэхээр тэр сайн байршилтай, түүх, түүхэн барилгаа төрдөө аваад үлдье. Тэр хөрөнгө, дотор нь үйл ажиллагаа явуулж байгаа Хөрөнгийн биржээ тэр тусгай зөвшөөрөлтэй бүх эрх, тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн сантай нь хамтад нь хувьчлаад ингээд чөлөөтэй хөрөнгийн зах зээл маань хөгжих бололцоог бий болгоё. Энийг бол та бүхэн үндсэндээ Их Хурал дээр энэ ажлын хэсэг байгуулаад санал гаргаад, ингээд бид Их Хурал ингээд Засгийн газарт ингээд чиглэл өгөх бололцоотой. Ийм байдлаар шийдчихвэл илүү үр дүнтэй, зөв болох байх.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн алга байна. Чуулган дээр санал хураалт болох гэж байгаа учраас яаралтай энд байгаа гишүүд санал хураалтад орчхоод, эргээд ирэх юм байна. Их Хурлын дарга ярьж байна.

Хуралдаан 14 цаг 30 минутаас 15 цаг 05 минутад завсарлав.

Хуралдаанаа үргэлжлүүлье. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Төрийн өмчөөсөө салъя, хувийн хэвшилд орон зай гаргаж өгье, бүтээмжийг чухалчилъя гэж байгаа энэ Засгийн газрын санаачилгыг дэмжиж байна. Бямбацогт сайд энэ хуулийг өргөн барьж байгааг зарчмын хувьд дэмжиж байна. 3 асуулт байна. Эхнийх нь Монголын хөрөнгийн бирж 51 хувь, Хөдөө аж ахуйн бирж 34 хувиас багагүйгээр төрийн эзэмшилд байна гэсэн байна. Энэ дээр төрийн эзэмшилд байх ёстой гэж үзэж байгаа үндэслэл нь юу вэ? Энэ 2 бирж дээр төрийн оролцоо байхгүй байвал зүгээр гэж бодож байна. Тэгж байж манай үнэт цаасны зах зээл хөгжих болов уу? Ялангуяа биржүүд маань олон улсын биржүүдтэй хамтраад ажиллаад Монголд хувьцаагаа нээлттэй гаргахлаар гадаадад бас зэрэгцээд гарч байдаг тийм зохицуулалтыг хийхээр төлөвлөж байгаа юу эхний асуулт?

2 дахь асуулт ТӨК-удыг ингээд олон нийтэд хувьцаа санал болгож байгаа нь зөв, маш зөв. Гэхдээ энэ чинь хөрөнгө оруулалт татах нэг хэлбэр байгаа. Татсан хөрөнгө оруулалтаараа юу хийх вэ гэдэг нь чухал асуудал гэж бодож байна. Тэр төлөвлөгөө нь юу байгаа юм бол? Тараасан энэ материал дээр тодорхой хувиудыг нь л хувьчилна, олон нийтэд гаргана гэсэн зүйлүүд байна. Ялангуяа Эрдэнэс Тавантолгой, тэгээд Эрдэнэт үйлдвэрийн 10 хувь, 10 хүртэлх хувийг гэж байгаа юм байна шүү дээ тийм ээ? Энийг олон нийтэд санал болгохлоор ойролцоогоор 2,2 их наяд төгрөг татан төвлөрүүлэх болов уу гэж бодож байна. Энэ мөнгийг зүгээр төсөв рүү оруулаад 2026 ч юм уу, 2027 онд төсвөө өөрөө тэлээд явбал эсрэгээрээ бид

эдийн засаг дахь төрийн оролцоог улам нэмсэн алхам болчих болов уу гэж бодож байна. Тэгэхлээр энэ 2,2 их наяд төгрөгөөрөө ямар ажил төлөвлөж байгаа вэ гэсэн 2 дугаар асуулт?

3 дахь асуулт нь манай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар онлайнаар сайт дээрээ бас энийг тавьж байгаа. Жил болгон төрийн өмчид байгаа компаниудын жагсаалт болон хөрөнгийн өгөөжүүдийг бүгдийг нь тавьсан байгаа. Манай хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийт маань хараасай гэж үзэж байна. Энэ сүүлийн хэдэн жил тогтмол гарч байгаа. Зарим компаниуд хөрөнгийн өгөөж нь -500, 600 хувьтай байгаа шүү дээ. Эд нарыгаа шууд татан буулгаад явах санал санаачилгуудыг d.parliament.mn байдаг юм уу, petition.mn сайтуудаар гаргаад явбал их зөв зүйтэй гэж бодож байна. Ийм байдлаар хэрвээ иргэдийн зүгээс ашиггүй ажиллаж байгаа энэ ТӨК-удыг болиоч, татан буулгаач, нэгтгээч, өөрчлөн зохион байгуулалт хийгээч гэсэн санал гаргах бол манай Засгийн газар дэмжиж ажиллах боломж бололцоо байдаг юм болов уу?

Р.Сэддорж: 3 номерын Бямбацогт сайд.

С.Бямбацогт: 1 дэх асуултад Цэнгэл дарга хариулна. Би яг өөртэй чинь санал нэг байгаа. Тэр Хөдөө аж ахуйн биржийг, дээрээс нь Хөрөнгийн биржийг ер нь болж өгвөл 100 хувьчлах бодолтой. Манайхан төрийн хяналт байх ёстой, төрийн оролцоо байх ёстой, үе шаттай байх ёстой гээд ингээд байгаа. Тэгээд үүн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар яг эрхэлсэн асуудал учраас илүү дэлгэрэнгүй хариулчих нь зөв байх гэж бодож байна.

2 дахь асуултын тухайд татсан хөрөнгө оруулалтаараа юу хийх вэ гэж. Ялангуяа Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэр. Тэгээд Ашигт малтмалын тухай хуульд нэлээн дээр үед бас орсон заалт. Энэ уул уурхайн стратегийн ордуудын 10 хувийг Хөрөнгийн биржээр дамжуулж олон нийтэд нээлттэй хувьцаа гаргаж худалдаарай гээд ингээд хуульд заачихсан. Яг энэ хуульд заасны дагуу оруулж ирж байгаа юм. Ингээд юу гэдэг юм энэ 2,2 их наядын хөрөнгө Хөрөнгийн биржээр дамжуулж борлуулаад, энд иргэд хувьцааг нь худалдаж аваад явах бол яг юу бол. Тэгээд ирэх хавар бид жагсаалт оруулж ирнэ. Энэ тогтоолыг баталсны дараа бид нарийвчилж тийм үү, хэрхэн яаж, ямар зорилгоор, ямар үр дүнд хүрэхийн тулд, ямар ач холбогдолтой гэж үзэж, ямар арга хэлбэрээр хөрөнгө татах вэ, түүнийгээ юунд зарцуулах вэ гэдгээ ирэх хаврын чуулганаар бид жагсаалтдаа оруулж ирнэ. Энэ үед илүү тодорхой болно. Тэр үед эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал ямархуу байх нь вэ. Хэрвээ шаардлагагүй үнэхээр бид хувьцаа гаргадаг, эргээд нөгөө хувьцааг худалдаж авах санхүүгийн чадавх байхгүй бол тэр эрсдэлтэй нөгөө хөрөнгө чинь бидний бодсон, тооцсон үр өгөөжөө өгч чадахгүй, үнэд хүрч чадахгүй учраас илүү хохиролтой болчихно. Тийм болохоор тэр нөхцөл байдлаа харж байгаад тухайн үед нь уян хатан байдлаар зохицуулах нь зөв гэж үзэж байгаа.

Ер нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль Их Хурал баталсан. Энэ байгалийн баялгийн үр өгөөж нь дийлэнх нь ард түмэнд ноогдоно гээд заачихсан. Гэтэл үүнээс өнөөдөр амьдарч байгаа болон ирээдүйд амьдарч байгаа. Гэтэл ирээдүй хойч үедээ бид Ирээдүйн өв сангаар 65 хувиа хадгалаад, хадгалахдаа гаднын банканд аваачаад 4 хувийн хүүтэй хадгалуулчихдаг жилийн. Тэгсэн мөртөө Засгийн газар, Хөгжлийн банк гаднаас мөнгө босгохдоо 10 хувийн хүүтэй мөнгө зээлж ирээд, Оюу толгой 11 хувийн хүүтэй мөнгө зээлээд ингээд явж байдаг. Ийм байдлаар хөрөнгийн менежмент. Гэтэл ирээдүй дээр 65 хувийг нь хадгалчихаад, одоо амьдарч байгаа иргэдэд юу байна вэ гэхээр юу ч байхгүй. Юу ч байхгүй гэж

яагаад хэлж байгаа юм гэхээр нөгөө төрийн өмчит стратегийн ордуудын 34 хувийг эзэмшиж байгаа ТӨК-удын ноогдол ашиг гээд маш бага хувь нь өнөөдөр амьдарч байгаа 3 сая 500 мянган иргэд ноогдоод байгаа.

Хөгжлийн санд юу үлдэж байна вэ Хөгжлийн санд юу ч байхгүй байгаа юм. Яагаад юу ч байхгүй гэхээр нөгөө төсвийн давсан орлогоос Хөгжлийн сангийн эх үүсвэр бүрдэнэ гээд ингээд заачихсан. Тийм болохоор бид энэ Баялгийн сангийн менежмент дээр энэ томоохон бодлогын өөрчлөлт хийж, энэ Баялгийн сангийнхаа үр өгөөжийг илүү нэмэгдүүлэх, өнөөдөр амьдарч байгаа иргэд болон ирээдүйд амьдрах иргэддээ тэгш хүртээмжтэй болгох, тэгш хүртээмжтэй, одоо бол ирээдүйдээ 65 хадгалагдаад, өнөөдөр амьдарч байгаа бараг байхгүй болчихоод байгаа юм. Энийг зөв, шударга хуваарилах нэг иймэрхүү зохицуулалтыг хийж, энэ хүрээндээ үндсэндээ энэ 2,2 их наядыг зарцуулах нь зөв болох байх. Тэгэхгүй одоо юу гэдэг юм улсын төсөв рүү орчихвол энэ чинь тэгээд л үрэн таран хийгдээд л, цалин, тэтгэвэр болоод л алга болчихно. Ийм юутай байгаа.

Ашиггүй ажиллаж байгаа компаниудыг ашигтай ажиллуулах асуудал оруулж ирвэл яах вэ гэж шаардлага тавивал. Энэ ашиггүй ажиллаж байгаа компаниудыг аваад үзэхээр төрийн оролцоотой, төрийн бодлого зохицуулалтаар яваад байгаа компаниуд. Өөрөөр хэлбэл эрчим хүчний компаниудын дийлэнх нь ашиггүй ажиллаж байна. Яагаад гэвэл эрчим хүчний үнэ тарифыг төр бариад байна. Цахилгаан, дулааныг өсгөчихвөл, чөлөөлчихвөл ард иргэдийн нуруун дээр ачаа ирчих гээд байгаа учраас төр хүчээр барьж байгаа учраас ихэнх нь энд алдагдалтай ажиллаж байна. Дээрээс нь АЗЗА компаниуд нөгөө зам засах ажлаа хийж байгаа учраас.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут 3 номер.

С.Бямбацогт: Саяын хэлдэг төр зайлшгүй ард иргэдийн нуруун дээр ачаалал үүрүүлэхгүйн тулд үнийн тарифын хязгаарлалт зохицуулалт хийж байгаа эрчим хүчний компаниуд, дээрээс нь зам засвар арчлалтын 21 компани байгаа 21-ийн АЗЗА. Энэ компаниудаас бусад ашиггүй ажиллаж байгаа компаниудыг ер нь татан буулгах, ашигтай ажиллаж чадахгүй бол захирлыг нь хариуцлага тооцох, цаашлаад татан буулгаад, үр ашиггүй хөрөнгө гэж үзээд хувьд шилжүүлэх, хувийн хэвшил чөлөөтэй тэр орон зай дээр орж ирэх бололцоо боломжийг бүрдүүлэх энэ бодлогыг зөв гэж үзнэ. Тэгээд таны ийм санал санаачилга гарвал дэмжинэ.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн тодруулж асууна.

Г.Лувсанжамц: Баярлалаа, чиглэлийг тэгвэл дэмжиж байна. Тэгээд ирэх хаврын чуулганаар татан төвлөрүүлсэн орлогоороо юу хийх вэ гэдэг агуулгуудаа гаргаж ирэх юм байна. Төсөв рүү бол оруулахгүй юм байна. Энэ зарчмаа баримтлахыг хүсэж байна. Банктай холбоотой энэ Төрийн банкныг төрийн эзэмшлийн хувьцааг 51 хувиас багагүй байхаар тооцож оруулна гэж байгаа. Манай Банкны тухай хууль хэрэгжихгүй байгаа 1 эзэмшигч дээр 20-оос дээш хувь байх боломжгүй. Энийг хэрэгжүүлээд явах гэхлээр нөгөө талдаа хувийн банкнууд маань бас төртэй барьцдаг болов уу гэж би хардаг юм. Төр нь яагаад их эзэмшилтэй Төрийн банкны үйл ажиллагаа явуулаад байхад хувийн хэвслүүд нь яахлаараа их хувь эзэмшиж болдоггүй юм бэ гэсэн тийм нөхцөлүүд байдаг. Төрийн банк нь өөрөөсөө манлайлаад төрийн эзэмшил 20 хувиас илүү байхгүй гэдэг зүйлээ эхэлж хийгээд, төрийн хувийн арилжааны банкнуудаа бид 20-оос дээш хувийн хувьцаа

эзэмшихгүй байхаар шаардлагаа тавиад явдаг тийм үйл ажиллагаа төлөвлөж байгаа болов уу?

Р.Сэддорж: 2 номер.

Б.Цэнгэл: Гишүүний асуултад хариулъя. Түрүүн тэр Хөдөө аж ахуйн биржийн 34 хувь нь төрд үлдээд, 66 хувийг нь олон нийтийн болгоё гэж байгаа. Энэ бол 2015 оны үндсэн чиглэлд яг нэрээрээ орчихсон юм байгаа юм. Юу гэж орсон гэхлээр төрийн эзэмшил дээр 36 хувь байх хэмжээнд яагаад, түүний технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилт хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагч этгээдэд оруулсан хөрөнгөд нь тохируулан нэмэлт хувьцаа гарган эзэмшүүлэхээр хувьчлах гэж орсон. Тэгэхээр бид өнөөдөр 15 оны үндсэн чиглэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа учраас энийг өнөөдөр баталгаажуулж оруулж ирж байгаа юм, биржээр. Монголын хөрөнгийн биржийг бид үе шаттайгаар ерөнхийдөө хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх ийм үе явж байгаа юм. Өмнө нь 34 гарсан, одоо нэмээд 15 буюу нийт дүнгээрээ 49 болох юм. Гэхдээ энэ дээр тухайлбал Анар гишүүн санал гаргасан шүү дээ. Энийг эсрэгээрээ төрд нь бага байх ёстой гэж ийм хэлсэн. 2 дахийн тухайд бол.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут 2 номер.

Б.Цэнгэл: Төрийн банк ерөнхийдөө энд манлайлал үзүүлж ажиллаж байгаа шүү дээ. Тэгэхээр бид Төрийн банкиг ерөнхийдөө төрд 51 хувь байхаар, үлдсэн 49 хувь нь нээлттэй олон нийтийн компани болгох ийм тал руугаа явж байгаа юм. Өөрөөр хэлбэл анх Төрийн банкиг үүсгэн байгуулахад Хадгаламж даатгалын корпорац 80 тэрбумд, 80 тэрбум төгрөг гаргаж байж байгуулсан ийм түүхтэй. Тэгэхээр энийг бид тодорхой хэмжээгээр энэ IPO гаргахад энэ 80 тэрбум төгрөгийг нь буцааж олсон орлогоос нь өгөөд, үлдэж байгааг нь банкны үйл ажиллагаанд нь зарцуулах ийм хэлбэрээр явж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүний нэр хасъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Чухал асуудал орж ирээд байдаг. Тэгэхдээ өмнөх 5 удаагийн үндсэн чиглэл батлагдаад, хэрэгжилтээрээ гарсан алдаагаа бид хэд олж ярихгүй, дахиад л ийм гоё ганган юм яриад сууж байгаад харамсаж байна. Энэ өмч хувьчлалын асуудал гэдэг чинь цаана хөрөнгө оруулалтыг татах асуудал байхгүй юу. Ер нь энэ хөрөнгө оруулалт хийх гэж байгаа орчны, орчинд энэ яг бидний хийсэн хөрөнгө оруулалт цаашдаа ямар эрсдэлтэй тулж болох вэ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ямар алхмууд хийгдэх вэ гэдгийг өмч хувьчлалын өмнөх болон дараа гээд бүх зүйлүүдийг анхаарч байж хийнэ.

Гэтэл өнөөдөр яг суурь төрийн өмчийн суурь хуулиа батлаагүй, ТӨК-ийн асуудлыг хуулиа батлаагүй. Эргээд жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудал шийдээгүй, Өрсөлдөөний хуулийг шийдээгүй ийм байж өнөөдөр ингээд яг шилний цаанаас мөхөөлдөс долоож байгаа юм шиг нэг их тоог нь ихэсгээд энэ бол нэг их ажил хийж байгаа яах вэ зүгээр сайшаалтай юм. Тэгэхдээ яг ингээд бүтэлгүйтнэ. Тийм учраас би Бямбацогт сайдыг яг Засгийн газар ингээд Улсын Их Хурлын гишүүд рүү түлхээд та хэд нэг эцэслээд шийдээд өгөх биш, яг Засгийн газар та яг энэ асуудлын бодлогыг барьж байгаа сайдын хувьд яг гарын 15 хуруунд багтах төслийг санал болгох ёстой байхгүй юу компанийг. МИАТ, Төрийн банк, Хөдөө аж ахуйн

бирж, бирж. Өөр юм явахгүй, явахгүй. Би энийг бүүр баттай хэлье Бямбацогт сайдаа. Бид хэд та нэг юм оруулж ирээд л, бид хэд нэг баталсан болно.

Тэгэхээр яг та бодлогын хувьд энэ дээрээ дүн шинжилгээ хийгээд, яг гарын хуруунд хөрөнгийн зах зээлээр дамжуулаад юм уу тодорхой хувилбаруудаар олон нийтийн болгож энэ засаглалыг нь сайжруулах, хувийн хэвшлийн тодорхой оролцоог хангах 5 төслөөс яг санал болго. Тэрнээс биш ийм урт жагсаалт оруулж ирснээрээ энэ сайд мундаг байна гэж хэлж болохгүй байхгүй юу. Би энийг л хэлмээр байгаа юм.

Тэгээд тэр 5 хувийн хувьцаа эзэмшлээс хэтрэхгүй гэдэг энэ дээр хэн ч орж ирэхгүй, хэн ч орж ирэхгүй. Ийм хуулиудыг л бид хэд баталж явсан учраас угаасаа энэ төр данхайхаас өөр арга байхгүй ийм байгаад байгаа юм. Тэгэхээр би зүгээр энэ уул уурхай нэг компанийн төслийг сонгооч гэж байгаа юм. Аль компани байх юм. Энэ дээрээ тэр Ашигт малтмалын хуулийн 5,6-аа хэрэгжүүлээд, хамгийн түрүүнд хувьцааг нь сумд өгмөөр байна. Сумын иргэдэд санал болгоё. Сумын иргэд тодорхой үнэ, хөнгөлөлттэй үнээр аваад, тодорхой цаг хугацаанд санал болгоод, дараагийнх нь аймгийн түвшинд санал болгоё, тэгээд нөлөөллийн бүсийн аймаг, тэгээд бусад хэмжээгээр. Ингэж байж өөрөө эргээд энэ уул уурхайн салбар дээр тогтож байгаа эдийн засгаа орон нутгийн дэмжлэгийг авах, иргэд өөрөө энэ баялгаасаа яг орон нутгийн иргэд хүртдэг байх. Казакстанд жишээ нь ийм юм хийсэн байхгүй юу. Ард түмний IPO гээд том хөтөлбөр гаргасан. Ард түмэн баялагтаа эзэн байх гэдэгтэй яг ижилхэн сонсогдож байгаа. Тэгэхээр ийм байдлаар ингээд хэрэгжүүлэх алхам руу явж болох уу гэдэг нэг зүүлт байна. 2 дугаарт ер нь ТӨК-удынхаа.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Гоё ганган юм оруулж ирээгүй. Олон нийтэд нээлттэй, ил тод, Их Хурлын гишүүд тал талаас нь ингээд бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гээд байгаа боломж бид ийм юм бодож байна зөв үү, буруу юу та бүхэн маань шүүн дэнслээд, тунгаагаад, бодлого чиглэлээ гаргаад өгөөч гэж оруулж ирсэн. Хэрэв одоо 5 компани оруулаад ирсэн бол яагаад 5-ыг оруулж ирэв, наадхаа 50 болгохгүй яасан юм бэ гээд л, яахаараа 5 байдаг юм, яасан харамч юм, либерал байх ёстой, олон компанид оруулж ирэх ёстой гээд л шүүмжлэх байх. Тэгээд өөлөхийн тулд өөлөх хэрэггүй байх гэж бодож байна. Тийм.

Тэгээд яагаад хэрэгжихгүй гэж хэлээд байгаа юм бэ тийм. Их Хуралд бид Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах тухай хуулийг 2025 оны 1 сард өргөн барьсан, 1 сард. Их Хурал маань Ажлын хэсгээ байгуулчихсан. Энэ хуулиа жил болох гэж байна хурдан батлаад гаргаад өгчихвөл бидний энэ бодлого хэрэгжих бололцоо боломж бүрдэнэ. Нийтийн өмчийн тухай хуулийг бид 2025 оны 5 сард Их Хуралд өргөн барьсан. Хэлэлцэх эсэх нь шийдэгдээд үндсэндээ хагас жил гаруй хугацаа өнгөрч байна. Тэгээд Их Хурлаас бид энэ хуулиудаа хурдан батлаад өгөөч гэж удаа дараа хүсээд л, гуйгаад л ингээд байж байгаа. Энэ хуулийг хурдан батлаад өгчихвөл энэ үндсэн чиглэл маань батлагдах бололцоотой болчихно. Тэгээд энэ тал дээр та бүхэн анхаарал тавиад өгөөч гэж 1 дүгээрт нь хүсье.

2 дугаарт нь өнгөрсөн жил 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас хэддүгээр тогтоол билээ 62 билүү, 52 дугаар тогтоолоор үндсэн чиглэлийг маш хурдан яаралтай оруулж ир гэж Улсын Их Хуралд үүрэг өгсөн. Улсын Их Хурал

Засгийн газарт үүрэг өгсөн. Энэ өгсөн үүргийн дагуу л бид энэ 2026-аас 2028 онд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцааг олон нийтэд нээлттэй биржээр ил тод арилжаалах энэ 33 компанийн асуудлыг оруулж ирж байгаа юм. Тийм болохоор Улсын Их Хурлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу л асуудлыг оруулж ирж байна. Улсын Их Хурал маань Засгийн газраас өргөн барьсан хуулиудыг хэлэлцээд, хурдан хугацаанд батлаад өгчихвөл бид юу гэдэг юм аль болох үр өгөөжтэй, аль болох ил тод, аль болох Их Хурлын гишүүд энэ 126 гишүүний санал бодлыг тусгаад, ард түмний хүсэн хүлээлтэд нийцүүлээд, төрдөө ашигтай, ард түмний сэтгэл хангалуун, Улсын Их Хурал овоо ш дээ ийм юм хийчихдэг ийм хэмжээнд хүргэж хийхийн төлөө ажиллана. 5 биш, болж өгвөл тэр 33 компанийн бүгдийг нь үр дүнд хүрэх та бүхний баталж өгсөн хэмжээнд түрүүн бид ярьсан шүү дээ, 80 хувьд хүргээд үр дүнтэй болгочих юм сан гээд хичээгээд ажилла хүсэл эрмэлзэл дүүрэн байна л гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулна.

П.Сайнзориг: Би энэ оруулж ирж байгаа асуудлыг нь дэмжээд байгаа юм. Тэгэхдээ энэ өөрөө нөгөө 33 бол зах зээл хүлээж авахгүй даргаа. Төрийн банкаа хар сая амжилттай гэж байгаа боловч 2 дахь зах зээл дээр наад арилжаа чинь явахгүй үнэ нь уначхаад байхад бид хэд ингээд бодит юмаа нэг үзмээр байгаа байхгүй юу. Бид хэд ийм тэнэг хүмүүс биш шүү дээ. Төрийн банкиг чинь сонирхохгүй тэр 5 хувийн арилжаа чинь бүр ингээд навс уначхаад байхад бид хэд ингээд ийм тоглоомтой юм яриад сууж байгаа байхгүй юу.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн захирлаасаа эхлээд дунд шатандаа нэг IPO өмч хувьчлалын асуудлаар зүгээр мэдлэгийн шалгалт хийгээд та нэг хараарай. Энэ бэлэн биш байгаа. Хууль, эрх зүйн орчин чинь бэлэн биш байна. Дээрээс нь бид хэд энэ хууль гаргаж байж mixed ownership-ийн асуудал буюу стратегийн хөрөнгө оруулагч болон олон нийт тэрнээс нь хүртдэг, иргэд маань хүртдэг ийм зүйл рүү явна. Энэний чинь цаана нь явж, явж ганцхан МИАТ бараг хувьчлагдаад энэ тогтоол чинь дуусна. Энэ непотизм явж байна. Непотизм буюу ойр хавийнхаа танил талд тохоод энэ зарим ашигтай өмчүүдийг хувьчлалыг шилжүүлээд, наад 33-аас чинь 1, 2.../минут дуусав/

Р.Сэддорж: 3 номер.

С.Бямбацогт: Бас их битгий мушгиад Сайнзориг гишүүнээ ингээд л. Одоо бид бүгдийг мэддэг хэтэрхий мэргэн жараахай болох гээд хэрэггүй. Бүгдээрээ л төрийн бодлого зөв байгаасай, бүгдээрээ л Монгол Улсын эдийн засаг, нийгэм хөгжөөсэй, төр ил тод үйл ажиллагаа явуулаасай, хувийн хэвшлээ дэмжсэн, ТӨК-удын үр ашгийг нэмэгдүүлэх юм сан гэдэг дээр санал бодол, зорилго нэг байгаа. Тийм болохоор харлуулахын тулд харлуулаад, мушгихын тулд мушгиад, өөрийгөө зөвтгөхийн тулд бусдыг буруутгаад ингэж хандах хэрэггүй. Хаана, аль компани дээр, ямар компани хулгай зэлгий явах гээд таны хэлээд байгаа хардлага үүсэх гээд байгаа юм бол та бол ил тод нээлттэй хэлж байгаад, энэ хэлэлцэх эсэх нь шийдэгдсэний дараа энэ компанийн ард талд ийм хүмүүс нийлж хулгай хийх гээд байна гэдгээ хасах нь нээлттэй шүү. Хоёрын хооронд ингээд бие биеэ хардаж энэ явах гэж байгаа Их Хурлаас өгсөн бодлогыг унагаах гэж хэрэггүй байх. Их Хурал өөрөө бодлого өгсөн, энэ бодлогыг нь хэрэгжүүлэх гээд бид оролдож байна.

Р.Сэддорж: Сайнзориг гишүүн тодруулж 1 минут сүүлийн.

П.Сайнзориг: Уг нь дэмжээд байгаа байхгүй юу. Бэлэн байдлын үнэлгээтэй компаниудыг хувьчлал хийлгэж орж ирнэ гэсэн 33 ч юм уу тоондоо биш юм гэдэг зүйлийг ойлгооч л гэж хэлж байгаа юм.

2 дугаарт жишээ нь МИАТ зэргийн компанийг энэ дотоодын хөрөнгийн биржээр угаасаа хүлээж авч дийлэхгүй. Уг нь энийг чинь олон улсын бирж дээр гаргана гэдэг зорилготой орж ирэх ёстой. Зорилгыг тодорхойлж байж орж ирнэ үү гэхээс энийг баталсны дараа зорилгоо орж ирнэ гэдэг тийм юм байдаггүй. Жишээ нь Францад өмч хувьчлалыг нэг компаниа хувьчлахдаа бид хэд энэ start-up компаниудын санхүүжилтийг олгохын тулд Францын Засгийн газар төрийн өмчит нэг компанийг хувьчилсан байхгүй юу. Тэгэхээр бид хэдийн асуудал Үндсэн хуулиа амилуулъя, 5.6-аа Ашигт малтмалын хуулийн 5.6-аа амилуулъя гээд орон нутгийн иргэдэд нь, аймгийн иргэдэд нь, тэгээд дараагийн түвшинд нь санал болгож болж байна. Эсвэл зарим компаниудын ажилчдад нь энэ компанид ажиллаж байгаагийнхаа хугацаанд энийг өмчлөх байдлаар хяналтыг нь сайжруулах байдлаар өгч болж байна. Энэ хувилбаруудыг энэ хууль батлагдсаны дараа орж ирвэл илүү их бодитой байна. Түүнээс биш ингээд орж ирээд хүлээлт үүсгэхээд байгаа байхгүй юу Бямбацогт сайдаа. Би тэрнээс биш ерөөсөө таныг эсрэгээр зүгээр мэдэх гээд байгаад биш, таны яриад байгаа.../минут дуусав/

Р.Сэддорж: Үг хэллээ. 3 номер.

С.Бямбацогт: Яг одоо харин их маш зөв байна Сайнзориг гишүүнээ, тийм баярлалаа танд, тийм. Яг үнэхээр асуудалтай юмнуудаа хэдүүлээ Их Хурал дээрээ цэгцлээд, сайжруулаад, бидний таны хэлж байгаа асуудлаар бид энэ ажлын хэсэг дээрээ хариуцсан албан тушаалтнууд, ТӨК-ийн захирлууд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчис Монгол гээд энэ компаниуд маань, Эрдэс Монгол гээд бүгдийг нь анхаарч байгаа. Яг таны хэлдэг энэ ямар стратегийн хөрөнгө оруулагчдаа хэдэн хувьцааг нь хувьчлах юм, ажилчдадаа хэдэн хувьцааг нь хувьчлах юм. Жишээ нь Эрдэнэт үйлдвэр гэхэд 1990 онд цэнхэр тасалбараар ингээд Эрдэнэт үйлдвэрийнхээ хувьцаа эзэмшинэ гээд авчихсан, одоо хүлээлт үүсчихсэн маш олон хүмүүс байж байна. Энэ хүмүүсийн асуудлыг яаж шийдэх юм, энэ хүлээлт байж байгаа. МИАТ компани дээр хамгийн сайн яг таны хэлж байгаатай яг тийм байгаа. Эхний ээлжид 10 хувь нь стратегийн хөрөнгө оруулагчид юм уу хувьчлаад, тодорхой хувьцааг нь өгөөд, үүнийгээ илүү үнэ цэнтэй, илүү үр ашигтай, менежмент сайтай болгосны дараа 34 хувийг нь, 40 хувийг нь хувьчилъя.../минут дуусав/

Р.Сэддорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Ер нь энэ төрийн оролцоог, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, хувийн хэвшлийн орон зайг илүү гаргаж өгөх бодлого руугаа явах чиглэлийг сайн хийх нь зүйтэй. Энэ асуудал олон жил яригдаж ирсэн боловч яах вэ Засгийн газраас ингээд оруулж ирж байгаа юм байна. Уг нь зүй нь энэ суурь хууль бодлого нь юу байх юм гэдэг асуудлаа шийдчихээд явбал уг нь зөв байсан. Даанч цаг хугацааны асуудал байх шиг байна. Тэгээд энэ дээр нөгөө төрийн өмчит ер нь улс чинь компанитай байх юм уу гэдэг чинь тухайн улсын геополитикийн онцлогоос хамаарна, ямар нөхцөлд байгаагаас хамаарна, хөгжлийн ямар түвшинд байгаагаас хамаарна. Тэгээд тэрийгээ Улсын Их Хурал дээр бид бодлогоо гаргаж, хуулиа батлаагүй байхад одоо энэ хувьчлалын асуудал ороод ирлээ. Тэгэхээр нэлээн маш сайн энийг Улсын Их Хурлаар ярилцаж хэлэлцэж байж батлах ёстой гэж харж байна.

2 дугаарт яах вэ бид асуудал хаанаа байна, юунд байна, тэгээд шийдлээ зөв гаргачихдаг манай Монголчууд бид. Тэгээд асуудал төрийн оролцоо их байна, тэрийгээ багасгая, энийгээ олон нийтэд нээлттэй байх, үр ашгийг нь сайжруулах тал дээр, хувийн хэвшилд хөрөнгө оруулалтыг бий болгох тал дээр гээд шийдэл нь зөв байна. Харамсалтай нь ер нь асуудлаа зөв тодорхойлсон боловч энэ шийдлээ гүйцэтгэх гүйцэтгэл дээрээ дандаа бид алддаг. Дандаа тэн дээрээ залхуурчихдаг. Тэгээд тэрийгээ гүйцэтгэлийн процессоо болон деталь дээрээ анхаараагүйгээс болоод дандаа хүссэн үр дүндээ гарч чадахгүй, тэгээд энэ буруу, зөв явлаа гэдэг юм гардаг. Тэгэхээр энэ дээр бид яг энэ бэлтгэл ажлын хүрээнд ер нь яг зөв юмнуудаа хийсэн юм уу гэдэг дээр би асуумаар байна.

Надад 3 асуулт байна. 1 дүгээрт бэлтгэл ажлын хүрээнд юу төлөвлөсөн юм бэ? Маш олон компаниуд байна. Нэлээн том ч компаниуд байна. Тэгээд IPO хийнэ, олон нийтэд хувьцаа зарна гэдэг маш удаан хугацааны бэлтгэл ажил шаардагдахад do the... явна, энийгээ бэлдэнэ. Дор хаяж алдагдалтай байгаа компани чинь үнэхээр үйл ажиллагааны хувьд чардайгаад, чардайгаад алдагдалтай байгаад байгаа юм уу, эсвэл хулгай ороод алдагдалтай болчихсон юм уу гэдгээ санхүүгийн дүн шинжилгээгээ хийнэ, хууль, эрх зүйн хувьд ямар байснаа хийнэ, цаашид prospectus нь ямар байхыгаа хийнэ. Энд чинь хамгийн багадаа 6 сар, тэгээд томоохон компаниуд дээр 1, 2, 3 жилийн асуудал байгаа. 28 он хүртэл хийнэ гэж байна. Яг энэ дээр энэ олон компаниудыг листэлсэн байгаа. Та бүхэн яг бэлтгэл ажлын хүрээнд юу хийхээр төлөвлөөд, юу хийчихсэн байгаа юм бэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна?

2 дугаар асуулт энэ олон компаниудыг IPO хийснээр ч байдаг юм уу, хувьчилснаар ч байдаг юм уу, зарснаар хэдэн их наядын хөрөнгө оруулалт ер нь хөрөнгө оруулагчдаас болон орж ирэх ёстой, хэдээр үнэлж гаргана гэж бодож байгаа юм бэ нийлүүлээд шүү? Би яагаад энийг асуугаад байна гэхээр манай нийгэмд үнэндээ олон нийт гэх юм уу, энгийн иргэн энэ хувьцааг авах мөнгө байгаа юу гэдэг дээр үгүй гэж бодож байна. Баялгийн хуваарилалт ямар болчихсон байгаа билээ, ямар хэмжээний их мөнгийг хэн авах гээд байна, ямар хэмжээний хөрөнгө оруулагчдыг бодож, төлөвлөж та хэдийг оруулж ирсэн байна гэдэг дээр байр суурийг чинь асуумаар байна?

3 дугаарт яах вэ олон компаниуд байна. Би энэ дулааны цахилгаан станц эд нар дээр үнэндээ.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Байхгүй боловч энэ МИАТ-ийн асуудал байна л даа. МИАТ одоо бол үйл ажиллагаа нь нэлээн өргөжиж явж байгаа. Тэгээд МИАТ өөрөө ингэж өсөн нэмэгдэж байгаа, ашиг нь өргөжиж байгаа компанийн хувьд 10 хувийн одоо байгаа хувьцаагаа төр зарна гэдэг нь ямар логиктой юм бэ? Эсвэл бусад энэ компаниудтайгаа адилхан шинээр гаргаад, тэр стратегийн хөрөнгө оруулагчаа оруулж ирэх ёстой биш үү? МИАТ-ийн 10 хувийн хувьцааг зарж төр төсөвтөө энэ мөнгийг авснаар юу нэмэр болох юм бэ? Яагаад ийм 3 үе шаттай юмыг МИАТ дээр ер нь төлөвлөсөн байгаа юм бэ гэдэг дээр нэмэлт хариулт авъя.

Р.Сэддорж: Хариулт 2 номер Цэнгэл дарга.

Б.Цэнгэл: Номинчимэг гишүүнтэй санал нэг байна. Их Хурал үндсэн чиглэл батлаад өгчихвөл өөрөөр хэлбэл бид Их Хурлаас эрхээ авах гэж байна шүү дээ. Ингэвэл засаг дараагийн ажлууд хийгээд, таны яг хэлээд байгаа энэ ажлуудыг бүгдийг нь төлөвлөж байгаа. Өөрөөр хэлбэл хамгийн багадаа ер нь 6 сар ордог юм хамгийн багадаа шүү. Тэгээд энийг үе шаттай явж байгаад бид эрэмбэлээд Засгийн газар жагсаалтаа батлаад явах юм. Өөрөөр хэлбэл ямар, бэлтгэл хангачихсан компаниудаа, дээрээс нь бид зах зээлийн судалгаануудаа харна, энэ бүх олон юмнуудыг хийгээд үнэлгээ оруулна, аудитыг оруулна, андеррайтеруудаа авна, андеррайтерын компаниудаа авна, ингээд ажил дэс дараатай ингээд төлөвлөгөө гараад явдаг юм. Энэ төлөвлөгөөнийхөө дагуу яваад, эхний ээлжид оруулах жагсаалтаа бололцоотой гэсэн компаниудаа 26 ондоо мэдээж оруулна. Ингээд 27, 28 ондоо ингээд хийгээд явахаар төлөвлөж байгаа. Энийг танд хэлье гэж бодож байна.

Ер нь бид энэ 33 компаниас нэн ялангуяа эхний 18 компаниуд бид нэмэлт хувьцаа гаргаж, гол нь багахан хэсгийг нь төсөвт төвлөрүүлнэ. Ер нь дийлэнх нь компанийн өөрийнх нь хөгжүүлэлтэд зарцуулна. Өртгийн аргаар тооцож үзэхэд ерөнхийдөө энэ бүх арга хэмжээг авсны үр дүнд 2,6 их наядын хөрөнгө төвлөрүүлэхээр ийм урьдчилсан тооцоололд гарсан ийм гарсан байж байгаа. 2,6 их наяд, тийм.

МИАТ дээр та асууж байна. МИАТ-ийг бол бид ер нь энгийн хувьцааны тодорхой хэсгийг стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгоно, тэгээд энгийн хувьцааг нэмж гарган олон улсын биржээр нээлттэй худалдах үе шаттайгаар хэрэгжүүлэхээр ингэж үндсэн чиглэлд тусгаж оруулсан байж байгаа. Тэгээд эхлээд энгийн хувьцааны 10 хүртэлх хувийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид санал болгох замаар нээлттэй компани эхлээд болгох юм. Энийгээ болгож авчхаад, дараа нь төрийн мэдлийн энгийн хувьцааг худалдаж олсон тэр орлогыг нь, тодорхой орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлэхээр байж байгаа. Яагаад гэхлээр бид 2026 оны хөгжлийн хөгжлийн төлөвлөгөөнд 200 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр орсон. 200 тэрбум төгрөг төвлөрүүлэхийн тодорхой багахан хувийг нь МИАТ-аас орж ирэх буюу энэ орлогоос бүрдүүлж байгаа. Нөгөө хэсэг нь Төрийн банкныг худалдах юунаас нэг тодорхой 160-аад орчим тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр ингэж тусгасан байгаа. Бусад нь төсөвт орж ирэхгүй ийм байдалтай байгаа юм. Баярлалаа.

Р.Сэддорж: 1 минут Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: МИАТ дээр одоо байгаа 10 хувиа зараад, тэрийгээ төсөвт аваад, тэгсэн мөртөө нээлттэй компани болгоно гэхээр процессын хувьд нэлээн нарийн харах ёстой. Би өөрөө яг энэ чиглэлийн хуулийн зөвлөгөө олон улсын хуулийн фирмд өгч, 10 хэдэн жил олон улсад ажиллаж байсны хувьд тэр нарийн деталь асуугаад байна.

2 дугаарт 2,6 их наядыг та бүхэн ер нь үнэлгээтэйгээр ингэж гаргах хувьцаа гаргах гэж үзэж байгаа юм байна л даа. Тэгээд манай Монгол Улсын хувьд одоо чинь мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж юм хөгжөөгүй, институшн хөрөнгө оруулалт байхгүй, иргэдийн хувьд Монголын хөрөнгийн бирж дээр гарч байгаа хувьцааг үнэндээ яаж үнэлж авах талаар мэдлэг боломж хомс, байгаа мэдээлэлд ойрхон хэдэн томоохон чадавхтай хэдэн компаниуд л боломж байдаг, эсвэл банкнуудад тийм үү? Тэгэхээр яг хөрөнгө оруулагчийн хувьд тэгээд л төрд байсан хувьцаа маань ийшээгээ очно л гэж ер нь төсөөлөөд байна уу? Тэр стратегийн хөрөнгө

оруулагчийг бид ойлгож байна, гаднын ч юм уу, юу гэдэг юм нэг тийм юм байх гэж байгаа юм. Гэхдээ ихэнх би энэ тогтоол дээр байгаа юмнуудыг харахаар зүгээр л.../минут дуусав/

Р.Сэддорж: Асуулт уу? 3 номер Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тэгэхээр энэ 2,6 их наядын чинь 2,2 их наяд нь хоёрхон компани байгаа юм Эрдэнэс Тавантолгойн 10 хувь, Эрдэнэт үйлдвэрийн 10 хувь шүү. Энэ бол үндсэндээ Ашигт малтмалын хуульд заасны дагуу л оруулж байгаа юм. Энийг оруулахгүй бол хууль зөрчлөө, Засгийн газар хууль зөрчөөд оруулж ирсэнгүй гэж загнана. Тийм болохоор хууль зөрчихгүйн тулд оруулж ирсэн. Тэгээд үлдсэн 400 тэрбум дээрээс нь тийм үү 280 орчим тэрбум нь Төрийн банк, үлдсэн нь ингээд яагаад ийм бага болоод байгаа юм бэ гэхээр нөгөө компаниудын чинь 34-өөс 49 хувийг, 51 хувь, 100 хувь гэхивэл яахаараа 51 хувь, 100 хувь гээд төрд өгөх гээд байгаа юм. Нөгөө 90-ээд оны өмч хувьчлалын алдаа тийм үү, хуйвалдаж байгаад хулгай хийдэг ийм юм хийх гэж байгаа юм биш үү гэж та бас сая жоохон цухалзуулж байх шиг байна. Энэний цаад талд чинь авчих хөрөнгөтэй хүмүүс байгаа юм уу, хэнд зориулах гээд байна гэж. Тийм болохоор тийм л хардлага яваад байдаг. Ингээд л нөгөө бие биеэ хардаад байдаг. Яах аргагүй урьд өмнө нь 90-ээд онд алдаа гарчихсан, энэ алдааг давтахгүйн тулд бид олон нийтэд нээлттэй, ил тод дуудлага худалдаа.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Б.Жаргалан: Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байна. Өнөөдөр 12 дугаар сарын 23 шинэ жил болтол 7 хоногийн хугацаа үлдчихсэн. Тэгээд яг ийм олны анхаарал сарничихсан ийм цаг үед их чухал тогтоол орж ирж байна. Тэгээд энэ тогтоолын төслийн товч танилцуулга дээр байгаа ганц нэг тоо баримтыг та бүхэнд уншиж өгье. ТӨК компаниуд нь 2024 оны жилийн эцсийн тайланд нийт хөрөнгө 59,4 их наяд төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 74,3 хувь, нийт орлого 26 их наяд төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 32,5 хувь гэсэн байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд Ардчилсан нам энэ Монголын эдийн засаг чинь ерөөсөө тэр чигтээ төрийн эрх мэдэлд оччихлоо. Манайд ер нь хувийн хэвшил гэж байхгүй ерөөсөө ийм төрийн эдийн засаг болчихлоо гээд яриад байгаагийн нэг тод илрэл энэ тоо нар.

Тэгээд ер нь үндсэндээ ямар нөхцөл байдал үүсчихсэн бэ гэхлээр сүүлийн 10 гаруй жилийн туршид энэ эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдсээр, нэмэгдсээр энэ ТӨК-удын байр байдал данхайсаар үндсэндээ бид 90 оны тэр нөгөө шилжилт хийх цаг мөч дээр оччихсон байгаад байгаа юм. 90 онд бид ерөөсөө ямар ч хувийн өмчгүй нийгмээс яаж хувийн өмчтэй болох тэр том шилжилтийг маш өндөр үнэтэйгээр хийсэн шүү дээ. Гэтэл өнгөрсөн хугацаанд ингээд буцаагаад нийгэмчилсээр байгаад одоо эргээд бараг тэр нөхцөл байдалдаа оччихсон байна гэж дүгнэж болохоор байна. Тэгэхээр бид энэ өмч хувьчлал дээр өмнөх алдаа дутагдлаа давтахгүй, аль болох юу гэдэг юм иргэдийн оролцоог хангасан энэ чинь бараг баялгийн өмчийн дахин хуваарилалт явах гээд байна шүү дээ. Тэгэхээр энд энэ ийм шударга ёсыг баримталсан ийм цогц бодлого хийхгүй бол зөвхөн нэг үндсэн чиглэл гээд нэг хэдэн компанийн жагсаалт оруулж ирээд, тэгээд түүгээрээ явчхаж болохгүй байр байдал үүсээд байна гэдгийг хүмүүс хэлээд байх шиг байна.

Тэгэхээр энэ үндсэн чиглэл гэж нэрлэсэн хэр нь ингээд зөвхөн нэг хэдэн компаниудын жагсаалт оруулаад ирж байгаа байхгүй юу. Гэтэл тэр нөгөө зарчмууд

нь яг тодорхой юу байх юм энэ тэр гэдэг асуудал дээрээ бид бүүр ийм нийгмийн хэлэлцүүлэг явуулж байж, одоо энэ нөхцөл байдлаасаа яаж гарах вэ, тэр 90 оны алдаагаа яаж давтахгүй байх вэ, ер нь бидний тэр худалдан авагч нь хаана байна энээ тэрээ гээд маш олон асуудлыг яримаар байгаад байгаа юм.

Тэгээд 2 асуулт. Нэг нь биржээс асуумаар байна. Биржээр олон нийтэд нээлттэй арилжина гээд 18 компанийн жагсаалт оруулж ирсэн байна л даа. Тэгээд би энэ 18 компанийнх нь өөрийнх нь хөрөнгийг нь зүгээр тооцоолж үзлээ. Тэгсэн чинь 42 их наяд 264 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй компаниуд байгаад байна. Манай Монголын хөрөнгийн биржийн ер нь нийт нөгөө зах зээлийн үнэлгээ чинь болохлоор 10 гаруй их наяд төгрөг байгаад байгаа шүү дээ. Тэгээд тэр зах зээлийн багтаамж нь хаана байна гэдэг асуудал байна. Тэгээд минут.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгээд яах вэ ингээд биржээр арилжаалаад олон нийтэд нээлттэйгээр ингээд яваад, IPO хийчихвэл гоё болчихно гэж бодоод байгаа юм. Гэхдээ өнөөдөр манай бирж зөндөө олон асуудалтай байгаад байгаа юм. Цөөнх хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хангагдахгүй байна. Нөгөө алдарт Их дэлгүүрийн кейс байж байна. Дээрээс нь болохлоор нөгөө цаг тухайд нь тайлангаа өгдөггүй компаниуд маш олон байгаа гэх мэтчилэн бирж дээр байгаа маш олон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ асуудлууд дээр биржийн шинэ удирдлага ямар байр суурьтай байна вэ тэрийг сонсмоор байна?

2 дугаарт Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр энэ цөөнхийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг яаж хангаж байгаа энэ өнгөрсөн хугацаанд бид зөндөө олон асуудлууд ярьсан, ямар ахиц дэвшил гарч байгаа тал дээрээ нэг тайлбар хиймээр байна. Мөн аудитаас хүн байгаа юу? Энэ нөгөө жагсаалтад орсон компаниуд дээр аудитын тайлангууд ер нь ямар байр байдалтай байгаад байгаа юм бэ, хэчнээн хувь дээр нь хязгаарлалттай дүгнэлттэй байгаа юм гэдэг асуулт?

Р.Сэддорж: Эхлээд Бямбацогт сайд, дараа нь бирж, аудит, Засгийн газраас хариулах хэрэгтэй байна, Санхүүгийн зохицуулах хороо хариулъя. 3 номер.

С.Бямбацогт: Жаргалан гишүүн чухал асуудал хөндөж байна. Бид чинь ингээд долоохон хоногийн дотор шинэ жил болох гэж байхад энийг хурдан хэлэлцүүлээд, хурдан батлах зорилго байхгүй. Хэлэлцэх эсэхийг нь шийдүүлээд, тэгээд ажлын хэсэг байгуулаад, бид аль болох нөгөө Нийтийн өмчийн тухай хууль, Компанийн засаглал, ил тод үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль төрийн өмчийн компаниудын энэ хуулиудаа батлахдаа үүнтэйгээ зэрэгцүүлээд ингээд хамтад нь хаврын чуулганаар ингээд маш сайн ярьж байгаад ажлын хэсэг байгуулж байгаад, гадна, дотно явж туршлагаа судалж байгаад энэ ТӨК-уд дээр очиж ажиллаж байгаад, ингээд энэ үндсэн чиглэлийг батлаад өгөөч л гэж оруулж ирж байгаа.

Их Улсын Их Хурлаас оруул гэсэн учраас оруулж байгаа. Тэгээд одоо яаран сандран юу гэдэг юм шинэ жилээр далимдуулаад нөгөө нэг уламжлалт хардлагын дагуу хурдан батлуулах гэсэн зүйл, зорилго санаа огт байхгүй. Та бүхэн зөв ойлгоорой. Тэгээд нээлттэй хаврын чуулганаар сайхан нэлээн сайн бөөсийг нь түүж байгаад, усыг нь, шүүсийг нь шахаж байгаад батлаад өгөөрэй гэж та бүхнээс хүсье.

Энэ нөгөө нийт өмчийн асуудал дээр би түрүүн хэлсэн 2001 оноос хойш биш, 91 оноос хойш нийтдээ 2 мянгаад аж ахуйн нэгжийг хувьчлаад, эндээс 280 тэрбум

төгрөгийн орлого олжээ. Тэгвэл бид үндсэндээ энэ Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой гээд хэдэн том компаниуд маань энэ уул уурхайн салбарт, стратегийн салбарт үйл ажиллагаа явуулаад, эндээсээ нийт ТӨК-уд дийлэнх ашиг олж байгаа. Энэний зөвхөн олж байгаа ашиг нь гэвэл жилдээ 6 их наяд төгрөгийн татвар, төлбөр, хураамжийг, өнгөрсөн жил ямар их хөрөнгө хувьчилсан билээ өнгөрсөн хугацаанд. Тэгвэл тэрнээс 280 тэрбум л олж байсан бол 6 их наядын татвар, төлбөр, хураамжийг улсын төсөвт орж, түүгээр нь хүүхдийн мөнгө, цалин, тэтгэвэр тавьж байна. Төрдөө тийм үү 1 их наяд төгрөгийн ноогдол ашиг жил болгон 1 их наяд төгрөгийн ноогдол ашиг өгч байна. Энэ талаасаа харвал хэдэн компаниуд нь гайгүй ажиллаж байна. Ашиггүй ажиллаж байгаа, алдагдалтай ажиллаж байгаа компани байгаа. Тэрэн дээр бид илүү сайжруулах ёстой. Энэ дээр та бүхэн нэг бодлого чиглэл гаргаад өгөөсэй.

Мөн хөрөнгийг нь аваад үзвэл зөвхөн Эрдэнэс Тавантолгой компанийн хөрөнгө нь өөрөө лиценз нь тэр үнэлгээ нь 20 их наяд төгрөг, 20 их наяд төгрөгөөр үнэлэгдэж байгаа хөрөнгө нь. Иймэрхүү байдлаар ингээд нийт хөрөнгө гээд юу гэдэг юм ДНБ-ний тэдэн хувьтай тэнцэх хөрөнгөтэй болчихсон байна шүү дээ гээд. Энэний цаад талд нэг иймэрхүү ганц, хоёрхон том компаниуд дээр явж байгаа нэг хөрөнгүүд л байгаа шүү. Тэгээд бусдаар ТӨК-уд олноор нь байгуулаад, ТӨК-уд хувийн хэвшлийн орон зайг булааж эзлээд ингээд төр данхайчихсан, ТӨК-уд нь олон болчихсон зүйл биш. Энийг та бүхэн дахиад нарийвчлан харвал харагдах байх гэдгийг хэлье.

Мөн ялгаа байхгүй энэ хувьчлах гэж байгаа хөрөнгийн чинь хөрөнгө нь тэд байна шүү дээ гээд яг мушгигдсан байдлаар асуугдаж байна шүү. 40 хэдэн их наядын хөрөнгөтэй гэж байгаа боловч, би түрүүн хэллээ шүү дээ 2,4 их наядын орлого олно гэж ярьж байгаа боловч, 2,5 их наядын үүнийх нь Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт үйлдвэр нь 2,2 их наядын хувьцаа гаргана гэж байгаа. Энэ хуульд заасны дагуу оруулж ирж байгаа. Гэхдээ гарц гаргалгааг та бүхэн гаргаад өгвөл хэрэгжих байх. Тэгэхгүй бол хэрэгжих жоохон бололцоогүй олон жил явчихсан. Ийм байдлаар энэ 2 компанийн хөрөнгө гэвэл наад 40 их наядын чинь нэг үндсэндээ дийлэнх нь энэ 2 компанийн хөрөнгө болоод явчихна. Үлдсэн тэр 34-өөс 49 хувь, зарим компани дээр 51 хувь, 66 хувь хувьчлах гэж байгаа энэ компаниудын хөрөнгө юу гэдэг юм хувьчлах гэж байгаа олох гэж байгаа орлогоосоо нэг их тийм давсан хувьчилчих нь байхгүй болов уу. Энийг та бүхэн сайн нягталж үзээсэй. Энэ дээр нэмээд манай Цэнгэл дарга хариулаад өгөөсэй гэж хүсэж байна. Эхлээд Хөрөнгийн бирж, дараад нь Санхүү зохицуулах хороо, дараад нь аудит, дараад нь Цэнгэл дарга.

Р.Сэддорж: Хөрөнгийн бирж хаана байна вэ? 1 номер дээр суучих. 1 номер, өөрийгөө танилцуулна.

Д.Мөнхбат: Сайн байцаана уу. Монголын хөрөнгийн бирж /МХБ/-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхбат байна. Гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 13,25 их наяд төгрөгийн үнэлгээтэй байна. 22 онд үүний өмнө үндсэн чиглэл батлагдаж байсан үетэй харьцуулбал зах зээлийн үнэлгээ 2 дахин өссөн үзүүлэлттэй. Үүн дээр банкнуудын болон томоохон ААН-үүдийн олон нийтэд нээлттэй болсон энэ ажлууд нөлөөлсөн байх. 25 онд нийт анхдагч зах зээл дээр 380 тэрбум, 2 дахь зах зээл дээр 470 тэрбум, нийтдээ 850 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжсан байна. Зах зээлийн үнэлгээнийхээ ойролцоогоор 4-өөс 5 хувьтай тэнцэхүйц ийм хөрвөх чадвартай байна гэж ойлгож болж байна. Ер нь 27 он хүртэлх манай дунд хугацааны стратеги.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер нэг минут.

Д.Мөнхбат: Баярлалаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьд хүргэж зах зээлийн үнэлгээг өсгөх ийм төлөвлөлттэй ажиллаж байгаа. Тэгэхээр түрүүн хэлсэнчлэн 2,3 их наядын хөрөнгийг дотоодын хөрөнгийн бирж дээр босгох зорилтын хүрээнд бэлтгэл ажлуудыг хийгээд үе шаттай явж болно гэж харж байгаа юм. Арилжааны банкнууд дээр байгаа харилцах хадгаламжийн үлдэгдэл 30 орчим их наяд төгрөг байгаа. Энэний 10 хувийг нь хөрөнгийн зах зээл рүү татахад ийм хэмжээний ажлыг зохион байгуулах боломжтой гэж харж байна. Засаглалын хувьд түрүүн асуусан хөрөнгийн бирж анх IPO хийхдээ нийт үнэлгээ нь 36 тэрбум төгрөгийн үнэлгээтэй, үүнээс 34 хувийг нь буюу 11,9 тэрбумыг олон нийтээс татсан. Өнөөдөр манай байгууллагын зах зээлийн үнэлгээ 102 тэрбумын үнэлгээтэй буюу анх хөрөнгө оруулж байсан хүмүүсийн үнэ цэн 3 дахин өссөн. Мэдээллийн ил тод байдал, хугацаа, тайлагналууд дээр олон улсын түвшинд хүргэхээр ажиллаж явж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Санхүүгийн зохицуулах хороо, Аудит, Төрийн өмчийн хороо 2 номер.

Б.Цэнгэл: Сая Хөрөнгийн бирж ерөнхийдөө хэлчихлээ л дээ. Тэгээд яах вэ бид зах зээлийн багтаамжийг судалж үзэж байгаа. Нэн ялангуяа нөгөө банкны асуудалтай холбогдуулаад Олон улсын байгууллагаас гаргасан л судалгаа байна л даа. Тэгэхээр ерөнхийдөө 2 болон 2,4 их наядын багтаамж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энийгээ бид яах вэ Төрийн банк, Төрийн банкны 45 хувийг гаргах гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энд ерөнхийдөө аваад үзэхлээр бололцоотой гэж үзэж байгаа. МИАТ болон зарим газар дээр сонирхох сонирхлоо илэрхийлж байгаа олон улсын байгууллагуудаас бид зөвлөх үйлчилгээ аваад явж байгаа. Ер нь боломжийн хэмжээнд явчих болов уу гэж харж байгаа. Тийм учраас ерөнхийдөө Засгийн газар жагсаалтаа батлах учраас бид энэ бүх юмнуудыг тооцож үзэж байж ер нь хэрэгжих магадлалтай.../минут дуусав/

Р.Сэддорж: Цэнгэл дарга жоохон зоригтой байна шүү, аягүй олон үе шатыг туулчихсан, туршлагатай байна шүү дээ хувьчлалын. Жаргалан гишүүн сүүлийн 1 минут.

Б.Жаргалан: Тэгэхээр энэ эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах энэ хэрэгцээ шаардлагагүй ТӨК-удыг хувьчлах асуудлыг Ардчилсан намын гишүүний хувьд үзэл санааны хувьд дэмжинэ. Гэхдээ бид энэ асуудалд маш тийм тооцоо судалгаатай хандахгүй бол энэ эргээд нөгөө эдийн засгаа буцаагаад унагаачих магадлалтай, аль эсвэл энэ баялгийн хуваарилалтыг ахиад бүүр буруу зүг рүү явуулчих магадлалтай ийм асуудал. Тэгэхээр энэ долоо хоногтоо батлахгүй гэж ойлголоо. Тэгээд ер нь энэ дээр ажлын хэсэг гаргаад, тэгээд ингээд тал талаас нь ажиллаад, тэгээд цаашдаа явж байж, нөгөө бусад хуулиудтайгаа хамт батлахгүй бол тэгээд яг зүгээр би сүүлдээ бүүр айлаа шүү дээ энийгээ долоо хоногийн дотор батлах гэж байгаа юм байх гэж бодоод. Тийм. Тэгэхээр тийм бодолтой байна. Тэгэхээр энэ асуудал дээр хэдүүлээ тал талаас нь ул суурьтай хандаад, тэгээд нэлээн дорвитой тийм үр дүнд хүрэх ёстой л гэж харж байна.

Р.Сэддорж: Үг хэллээ. Батсүмбэрэл гишүүн.

М.Батсүмбэрэл: Хэдэн асуулт байна. 1 дүгээрт энэ бид тойрч яриад яах вэ. Ер нь өмч хувьчлал өмнө нь алдаа гарчихсан шүү дээ. Өмч хувьчлалын хулгай луйвар 2 гэдэг юм руу явчих вий. Өмч хувьчлалаар нэг хэсэг нь уурхайтай, зочид буудалтай, архины компанитай болж үлдсэн. Нэг дийлэнх ард түмэн ядуу үлдсэн. Энэ бодитой үнэн. Тэгээд энэ олон түмэн ард иргэд маань энэ өмч хувьчлалын талаар, үнэт цаасны талаар ойлголттой болж чадсан юм уу? Үүнийг Хөрөнгийн бирж нэг мэдээлэл өгөөч.

2 дугаарт сая тэр аудит байгаа юм уу, байхгүй юм уу? Энэ Жаргалан гишүүний асуултад хариулсангүй, тэр хариултаа өгөөч.

Ер нь Төрийн өмчийн хороо энэ улаан, цэнхэр тасалбарт иж бүрэн дүгнэлт өгсөн юм уу? Тэр дүгнэлт, тэр үйл явц ер нь ямар байдалтай дууссан юм бэ? Одоо тэн дээр хохирсон юм уу, юмаа дуусгаагүй хүмүүс байдаг юм болов уу, ямар байдалтай байдаг юм бол гэж асууя?

Тэгээд тодруулаад энийг нэлээн хэдэн ААН-үүд л орж ирчихсэн байж байгаа. Энэ дулааны эх үүсвэрүүдээ хувьчлах асуудал байгаад байгаа. Энэ нь тэгээд зөв гэж үзэж байгаа юм уу бодлогынхоо хувьд, энэ дээрээ ямар байдалтай процессын дүгнэлтүүд хийгдчихсэн юм энийг нэг хэлж өгөөч?

Тэгээд түрүүний хэлдэг мэдээлэлд ойрхон, эрх мэдэлд ойрхон олон түмний хэлдгээр нөгөө олигархууд өмчөө зузаатгах ажил хийгдчих вий дээ. Түрүүчийн өмч хувьчлалын эздийн завшигчдын үр шим бидэнд байж байгаа. Бид юм уншдаг судалдаг, мэддэг, ярьдаг, тойрч цэрвээд байх шаардлагагүй. Тэгээд энийг бид энэ дээр яаж энэ мэргэжлийн байгууллагууд нь дүгнэлт судалгаа хийсэн юм бэ? Өмчийн тухай хуулиа явуулж байгаад энийг оруулж өгөхгүй яасан юм бэ гэдэг юм дээр ямар тодорхой дүгнэлттэй байгаа юм бэ?

Тэгээд Бямбацогт сайд, Цэнгэл дарга 2 л голчлоод хариулаад байна, компаниудын захирлууд байх шиг байна. Бүх захирлууд хариулчхаарай. Танай компани дээр хэн гэдэг менежер томилогдоод, ямар үр дүн гаргав? Тэр менежерүүдээ нэг хэлээд, ямар ажил, үр дүн гаргаснаа нэг хэлчхээч. Тэгээд энэ та бүхэн мэдээллээр авч л байгаа. Тэгээд олон менежерүүд чөлөөлөхөөс болж зарим хүмүүс шөнө унтаж чадахаа больчихоод байна шүү дээ даралт нь өндөрсөөд. Хариулт аваадахъя.

Р.Сэддорж: Хариулт Бямбацогт сайд 3 номер.

С.Бямбацогт: Ер нь өнгөрсөн энэ 5 удаагийн үндсэн чиглэл өмч хувьчлах бодлого Улсын Их Хуралд Засгийн газраас оруулж ирээд, тэдгээрийн нэг амжилтгүй хэрэгжсэн шалтгаан бол энэ хардлага сэрдлэг, ялангуяа тэр 1990-ээд оны үед хийгдсэн өмч хувьчлал мэдээлэлд ойрхон, арай жоохон мөнгөтэй эх үүсвэртэй ийм улсууд нь хуйвалдаад хулгайгаар нууцаар илүү төрийн үнэ цэнтэй өмчийг үнэгүйдүүлээд хувьдаа авчихсан энэ 90-ээд оны алдаанаас болж өнөөдөр үндсэндээ энэ өмч хувьчлалын өнгөрсөн олон жилийн амжилтгүй болоод байгаа шалтгаан энэ хардлагатай холбоотой. Яах аргагүй алдсан уу алдчихсан, дахиад алдчих вий гээд харддаг. Түүнээсээ болоод хувьчлал ТӨК-ийнхаа үнэ цэнтэй болгоод ард иргэддээ хувьчилж, төр хувьд хөрөнгөө шилжүүлэх энэ асуудал маань нэлээн саад бэрхшээлтэй явж байгаа. Энэ дээр манай Жаргалан гишүүн энэ аль болох төрийн оролцоог эдийн засагт багасгах энэ бодлогын хувьд дэмжинэ гэж ярьж

байгааг би дэмжиж байгаа. Хардахаа больё, төрийн оролцоог биш, хувийн хэвшлээ дэмжсэн бодлого явуулъя гэж.

90-ээд онд чинь яасан гэвэл нөгөө бүх юм хаалттай, ганцхан Үнэн сонинтой, ганцхан телевизийн мэдээлэлтэй, тэр нь бүх юм цензуртэй. Тийм болохоор мэдээлэл байдаггүй. Хүн болгон үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх ийм бололцоо боломж нь бага. Хүн болгон мөнгөтэй биш, хэт их мөнгөтэй биш, хэдхэн цөөхөн бизнес мөнгөтэй болчихсон. Өнөөдөр үндсэндээ бүх мэдээлэл ил тод болсон байна, нээлттэй болсон байна, хүн болгон үзэл бодлоо илэрхийлэх, үгээ хэлэх тийм үү чөлөөтэй эрхтэй болсон байна. Бизнес хийх, хувийн өмчтэй байх бүх бололцоо боломжууд бий болсон байна. Тийм болохоор тэгээд 90-ээд оны алдаа энэ цаг үед давтагдахгүй байх ялгаатай нийгэм бий болжээ. Энэ өнгөрсөн үед Монгол Улсын Их Хурал, Засгийн газар үе үеийн бүгдээрээ л зүтгэж байсан хүмүүсийн үр дүн байх. Хувийн хэвшлийнхний маань ч гэсэн идэвхтэй татвар төлж, баялаг бүтээж явсны үр дүн байх.

Тийм болохоор бид жоохон урагшаагаа хараад, нэг жоохон өөдрөг бодоод явахгүй бол тэгээд алдчих вий гээд л бээвийгээд суугаад байвал юу ч хөдлөхгүй. Түүний оронд өмнөх сургамж дээрээс дүгнэлт хийгээд, илүү боломж бидэнд байна гээд урагшаа хараад явах нь зөв болов уу. Тэгээд ингээд явахад л нэг их алдаа давтагдахгүй байх. Гэхдээ мэдээж бид бүхэн ч гэсэн Их Хурал дээр ингээд ярьж байгаа маань тийм үү нээлттэй, ард түмэн ил тод сонсож байна. Хэнд, ямар боломж олгогдох нь вэ, ямар компаниуд яаж хувьчлах гэж байгаа юм байна гэдгийг хүн болгон нээлттэй харж байна. Тийм болохоор үүн дотор нэг энэ ил тод байдал, шилэн байдлын цаад талд бүгдээрээ нээлттэй энэ хэлэлцэж байгаа байдлын цаад талд тийм хууль зөрчсөн, хулгай хийх тийм үйлдлүүд гарчихгүй байх. Урд нь чинь үндсэндээ 14 онд тэр Хөтөлийн цемент шохойн үйлдвэр дээр гарсан алдааг бид давтахгүй л гэж ярьж байна шүү дээ. Хөтөлийн цемент шохой. Тэгтэл чинь тэр бол ингээд хэрвээ алдаа хийчихвэл, хууль зөрвөл дараад нь нэг өдөр энэ нь ил болоод, дахиад ингээд л хэдэн жилийн маргаан болоод асуудал үүснэ. Тийм болохоор иймэрхүү алдаа гарчихгүй болов уу. Ийм алдаа гарах эрсдэлүүд энэ тогтоолын төслүүд дээр байвал та бүхэн маань сайжруулаад засаад өгөөрэй л гэж та бүхнээс хүсье.

Тэгээд ТӨК-ийн захирлууд бүгдээрээ хариулах гэж арай яах байх. Тэгье бүгдээрээ хариулъя. Захирлууд ээлжлээд суугаад байгаарай.

Р.Сэддорж: Хэн хариулах вэ? МИАТ компани, МИАТ компани, дараа нь Эрдэнэс Монгол. Гараа өргөөрэй, 4 номер.

Б.Даваадалай: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Даваадалай асуултад хариулъя. Зөвхөн Эрдэнэс Монгол компанийн хүрээнд нийтдээ 5 менежер байгаа. Тэгээд өчигдөр ажил байдалтай нь танилцсан. Тодорхой тодруулах зүйлүүд байгаа, зарим нь үр дүн гаргаж байна, зарим нь үр дүн нь тодорхойгүй асуудлууд байна. Тийм учраас миний бие ажил аваад үндсэндээ 2 хонож байгаа учраас яг бүрэн ийм байна, тийм байна гэж хэлэх жоохон эрт байна. Гэхдээ Засгийн газраас бодлогын хүрээнд үр дүнтэй ажиллаж байгаа менежерүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах, үр дүн дээр нь суурилж зарим бүтэц, орон тоог өөрчлөх ийм зарчим барьж байгаа гэж ойлгож байгаа. Манай нэгдлийн хүрээнд харьяалагдаж байгаа бусад компаниуд ирсэн учраас өөрсдийнхөө менежерийн талаар та бүхэнд мэдээлэл өгнө.

Р.Сэддорж: МИАТ байгаа юм уу? 1 номер.

Н.Цэгц: Оройн мэнд хүргэе. МИАТ компаниас Санхүү, удирдлагын газрын захирал Цэгц. Гишүүний асуултад хариулъя. Манайд 2024 оны Засгийн газрын шийдвэр тогтоолоор 2 менежер томилогдсон. Бүтээмжийн менежер, хяналтын менежер. Өнгөрсөн хугацаанд бүтээмжийн менежерийн хувьд авлигын эсрэг ISO 37001 тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийг ахалж ажиллаад тухайн тогтолцоог бид нэвтрүүлсэн. Нэвтрүүлсний хүрээнд авлигатай тэмцэх тодорхой шинэчилсэн журамтай болж, шүгэл үлээх процесстой, энэ асуудалтай тэмцэх хороо гэх мэт зохион байгуулалтын ажлуудыг хийгээд, энэ тогтолцоо нь ингээд баталгаажсан байгаа. Ийм ажлын үр дүнтэй байна. Өнгөрөгч долоо хоногт ТУЗ-өөс мөн Засгийн газрын үүрэг чиглэлийн дагуу хуралдаад тус 2 орон тоог байхгүй болгох бүтцийн өөрчлөлт хийх шийдвэрийг гаргасан.

Р.Сэддорж: Эрчист Монгол, 6 номер.

Г.Амартүвшин: Эрчист Монгол компанийн хувьд 3 менежер томилогдсон байгаа. Энэ менежерүүдийн ажлын үр дүнг энэ оны эцсээр дүгнээд, өөр чиг үүрэгт шилжүүлэх, өөр ажилд шилжүүлэхийг нь шилжүүлээд, ажлын бүтээмж нь хангалтгүй гэж үзсэн менежерүүдийг чөлөөлөх тийм үйл ажиллагаа явуулна.

Р.Сэддорж: 1 номер.

Д.Мөнхбат: МХБ компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхбат. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт Хөрөнгийн биржээс олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалтын тухай асуудал байсан. Манай байгууллага олон нийтэд үнэт цаасны зах зээлийн талаар ойлголтыг түгээх дээр давтамжтай анхан шатны болон ахисан шатны сургалтуудыг цахимаар болон биечлэн тогтмол хүргэдэг байгаа. Мөн 25 онд онцлоход 21 аймагт хүрч үнэт цаасны зах зээлийн тухай танилцуулгуудыг хийсэн байдаг.

2 дахь асуултад нь МХБ дээр аливаа менежер томилогдож ажиллаагүй байгаа.

Р.Сэддорж: Өөр, 2 номер.

Б.Цэнгэл: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Яах вэ гадуур 128, 400 гээд л тоо явдаг юм. Яг томилгоонд нь ТӨБЗГ оролцсон учраас миний хэлэх гэж байгаа тоо бол үнэн бодитой тоо. Ер нь 78 менежер томилогдсон юм. Энэ 78 менежерүүд 3 намаас гурвуулангаас нь томилогдсон. Монгол Ардын намаас 20 орчим 19 хүн байдаг юм, Ардчилсан намаас 20 хэдэн хүн, ХҮН намаас нэг тэр хэмжээний хүн. Ер нь 130-аад хүний анкет ирсэн, ингээд 77, 8 дээр ирээд л зогссон. Дахиж томилгоо хийгдээгүй. Засгийн газрын тэмдэглэл гарахдаа ямар агуулгаар гарсан бэ гэхлээр ажлыг нь дүгнэ, тэгээд ажлыг нь дүгнээд бүтээмжтэй сайн ажилласан улсуудынх нь дараагийн ажлынх нь асуудлыг нь шийдэх нь зүйтэй гэдэг агуулгаар Засгийн газрын тэмдэглэл гарсан байж байгаа. Энэ.../минут дуусав/

Р.Сэддорж: 2 номер.

Б.Цэнгэл: Үгүй ээ үгүй, өмч хувьчлалын тухай яриагүй л дээ. Нөгөө менежерүүдийн томилгооны талаар Батсүмбэрэл гишүүн асуусан учраас л хариулж байна л даа бид. Тийм. Үгүй ээ үгүй.

Р.Сэддорж: Одоо хэн байгаа юм бэ, өөр хэн байна вэ? 1 номер.

Б.Жавхлант: Үндэсний давхар даатгал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Жавхлант. Манай компаниас баталсан ТУЗ-ийн хүрээнд менежерийн орон тоо, бүтэц байхгүй. Манайд томилогдоогүй.

Р.Сэддорж: Цэнгэл дарга хүмүүсээ яагаад суулгаад хариулаарай. 4 номер.

Н.Ганхуяг: Эрхэм гишүүдийн энэ оройн мэндийг хүргэе. Цемент шохой, Стратеги төлөвлөлт, бизнес хөгжлийн газрын дарга Ганхуяг. Манай компани дээр Ардчилсан намын Мөнхболд, ХҮН намын Бархасбадь гэдэг 2 менежер томилогдон ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Цэнгэл дарга 2 номер.

Б.Цэнгэл: Батсүмбэрэл гишүүнд би яг жагсаалтаар нь танд гаргаад өгье. Надад бүх жагсаалтууд нь утасных нь дугаартай бүх юмнууд нь байж байгаа. Томилогдсон, томилогдоогүй нь хүртэл байж байгаа. Тэрийг би танд маргааш өглөө өгчихье бүх тэгэх үү? Тэгье.

Р.Сэддорж: Бямбацогт дарга. Батсүмбэрэл гишүүн тодруулна.

М.Батсүмбэрэл: Тэр юунд тодруулж хариулт авъя тэр нөгөө өмнөх ягаан, цэнхэр, улаан, цэнхэр тасалбарууд дээр ер нь төрийн өмчийн байгууллагаас иж бүрэн дүгнэлт хийсэн юм байгаа юу? Тэгээд нэг зүйлийг тодорхой бид ойлгох ёстой байгаад байгаа юм. Энд ард түмэн буюу олон нийт маань яг оролцоход бэлэн байна уу, мэдээлэлтэй байж чадах уу? Үүнийг худалдан авах чадвар байгаа юу? Өмнөх жишгээрээ урьдчилаад уурхайтай болчихсон, буудалтай болчихсон, компанитай болчихсон хүмүүс маань дахиад хөрөнгөө зузаатгачих юм биш үү? Нөгөө ашиггүй гээд байсан ААН давсан орлоготой, дансандаа сейфтээ мөнгөтэй байсан гэж яригддаг. Тэр давтагдах юм биш биз дээ? Нөгөө эмчилгээ тэжээлийн газарт очиж байсан уурхай маань шинэ ордтой болсон шиг явдал гарах вий дээ. Энийг нэг тодруулж асууя.

Р.Сэддорж: 2 номер.

Б.Цэнгэл: Гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад өмч хувьчлалын процесс 1990 оноос эхэлсэн түүхтэй байдаг. Анх өмч хувьчлал гэж эхлээд Монгол Улсын иргэд буюу нийслэлчүүд орон сууцаа үнэгүй хувьчилж авсан 1 дүгээрт.

2 дугаарт малыг малчдад нь хувьчилсан. Монгол хүн өмчтэй болох эхлэлийг бол шинэ Үндсэн хууль олгосон. Энэний дагуу өмч хувьчлах процесс ингэж эхэлсэн түүхтэй. Их, бага тасалбарууд гарч ирээд ингээд Төрийн өмчийн хороо 1996 онд байгуулагдаад, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 96 онд батлагдаад, дараа нь Компанийн хууль батлагдаад явсныг та бүхэн мэдэж байгаа байх. Бид энэ хугацаанд алдаа, оноотой ч гэсэн өмч хувьчлалыг хийсэн. Бид та бид Худалдаа хөгжлийн банкаа 100 хувь хувьчилсан, Нефть импорт концерноо 100 хувь хувьчилсан, Төрийн өмчийн даатгалаа 100 хувь хувьчилсан, АПУ-гаа 100 хувь, Шарын голоо 100 хувь, Хонгор үнэт цаасны.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут.

Б.Цэнгэл: Ингээд зэрэг нийт 28 ААН-ийг ихэнх нь 100 хувь, зарим нэг нь 34, Төрийн банкныг 5,71 хувиар ингээд хувьчилсан байдаг. Энэ тодорхой хэмжээгээр энэ өмч хувьчлалын орлого улсын төсөвт тухайн үед ордог байсан. Энэнээс сая манай Бямбацогт дарга хэлсэн. Нийт 2019 ААН-ийн 278,5 тэрбум төгрөг улсад улсын төсөвт төвлөрч орж ирсэн байдаг. Ер нь 2020 оноос хойш төрийн өмчит компаниудын төсөвт татвар, хураамж хэлбэрээр 18,7 их наяд, ногдол ашиг хэлбэрээр 1 их наядын төгрөгийг төвлөрүүлсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг 100 хувь үгүйсгэж болохгүй л дээ. Мэдээж тодорхой хэмжээгээрээ энэ өмч хувьчлал үр дүнгээ өгсөн. Гэхдээ мэдээж алдаа оноотой асуудлууд болсон уу гэвэл болсон. Энэ дээр бид Засгийн газрын, юу Их Хурлын тогтоол дээр 5 удаагийн үндсэн чиглэл дээр үнэлэлт дүгнэлт өгье гэж.../минут дуусав/

Р.Сэддорж: Пүрэвдорж гишүүнийг нэмье асуулт дээр. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 90-ээд оны өмч хувьчлал нэлээн эрчимтэй явагдсан. Тэгээд Бямбацогт сайд энд сууж байна. Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Ховд аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Галбадрах гуай нэг судалгаа хийсэн байдаг. Өөрөөр хэлбэл Ховд аймагт 82 ААН хувьчлагдсанаас 79-ийг нь тухайн үеийн Монгол Ардын хувьсгалт намын дарга нар авсан байдаг юм. Өөрөөр хэлбэл нэгдлийг нэгдлийн дарга, аль нэгэн компани ААН байвал тэр ААН-үүдийг бүгдийг нь тухайн үеийн дарга нь хийж байсан, намын хорооных нь дарга хийж байсан тэр хүмүүс хувьчилж авсан байдаг юм л даа. 3, 4-хөн ААН-ийг тухайн үеийн чөлөөт ямарваа нэгэн тийм намын харьяалалгүй байсан тэр хүмүүс авсан байдаг юм л даа.

Тэгээд өмч хувьчлал тодорхой хэмжээгээр гажуудалтай явсан уу гэдэг л үнэн. Жишээ нь НИК компанийн бүх агуулах савыг бүгдийг нь хувьчлахын өмнө бүгдийг нь акталсан. Акталсны дараагаар НИК компанийн үнэлгээ тогтоосон. НИК компанийг хувьчилсан. Тэгэнгүүт үнэ нь буурсан, буцаагаад яасан бэ гэхээр НИК компанийн тэр акталсан агуулах савууд бүгд ажиллаад эхэлсэн байхгүй юу даа. Тийм учраас яг энэ Батсүмбэр гишүүний асуугаад байдаг чинь зөв байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл одоо ингээд алдагдалтай байж байгаад баахан агуулах савтай юмтай байж байгаад, тэрнийгээ нүүрсний мөнгөөр хувьчлаад авчхаад, тэгээд дараа нь эрх мэдлээ ашиглаад хувьчилж авчхаад тэгээд түүнийгээ ашиглаад явчих вий гэдэг ийм болгоомжлол байгаа нь үнэн.

Өнөөдөр бид энэ банкнууд дээр 20 хувийн, дээд тал нь 20 хувийг эзэмших тухай энэ Их Хурлын тогтоол гарсан. Өнөөдөр Монголын банкнууд дээр хэн орж ирж байгаа юм 1 ширхэг ч гадаадын хүн орж ирээгүй. Яагаад гэвэл манай Монголд итгэх итгэл нь тийм доор байна гэсэн үг. Тийм учраас энэ хувьчлал дээр тодорхой хэмжээний хяналтын багцыг нь хувьчлахгүй, цөөхөн жаахан хувийг хувьчилбал энэ хувьчлал чинь үр дүнтэй явахгүй байхгүй юу даа. Тэн дээр тодорхой шийдвэр гаргадаг эрх мэдэл дээр очиж байж л тэр компаниудын чинь хувьцааг авна уу гэхээс бусдаар нэг Их Хурлын дарамттай хуулийнхныг барьчихсан, төрөө барьчихсан тэр нэг Их Хурлын гишүүн, сайд нарын цүнх баригч оччихоод тэрнийг нь дийлж, тэр компанийг ашигтай ажиллуулж хувьцаагаа оруулсан хувиа ноогдол авна гэдэг чинь асар том ачаа байхгүй юу. Тэгээд яагаад ч бүтэхгүй.

Тийм учраас энэ хувьчлалд чинь хүн идэвхтэй орох уу, орохгүй юу гэдэг чинь том асуудал байгаа. Тийм учраас яг энэ тогтоол бол зарим нэгэн компанийг цөөхөн жаахан хувиар хувьчилж байгаа нь энэ зүгээр.../минут дуусав/

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Очирбат гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Очирбат.

Г.Очирбат: Би өдөр хэлсэн юм. Нэг ийм нэг зүгээр нэг өнгөн маягаар ингэж Их Хурлын тогтоолын төслийг гаргадгаа одоо болих хэрэгтэй л болчихоод байгаа юм. Урьд нь ингээд 4, 5 удаа гаргасан байна, хэрэгжилт 33 хувьтай. Яг одоо яг тэр загвараараа л орж ирж байгаа юм. Тэгэхээр бид ер нь цаашдаа энэ Их Хурлын гишүүд ч хэлээд байна. Зүгээр ингээд хэлэлцэх эсэхийг нь шийдээд цаашаа явуулчихдаг. Тэгээд сайжирсан юмгүйгээр очоод л батлагддаг нэг ийм юм руугаа л орчихоод байгаа юм. Тэгэхээр энэ хэлэлцэх эсэх дээрээ ялангуяа энэ мэргэжлийн Байнгын хорооны энэ гишүүдийн хэлж байгааг сонсоод, яриад, тэгээд энэ асуудлаа нэг арай нэг зөв чиглэл рүү нь оруулж ирээд, Их Хурлын тогтоолуудыг цаашдаа ингээд батлаад явдаг болмоор байгаад байгаа юм. Тэгэхгүй бол энэ янзаараа явбал өмнөх 30 жилийн түүх чинь дахиад л давтагдах гээд байна.

Яг бодитой тэдэн компани, тэдэн хувийг нь, энэ нь тийм учраас, нөгөө нэг тэр 101 компаниас чинь энэ 33-г нь ингэж, ингэж сонгогдсон юм, тэгээд энэнийхээ тэдэн хувийг нь ингэх гэж байгаа юм гээд бүүр тодорхой оруулж ирэхгүй бол яг л өмнөх түүх л давтагдах гээд байна. Тэгэхээр би дэмжихгүй байгаад байгаа. Их Хурлын гишүүддээ бас уриалж байна. Ер нь цаашдаа нэг ийм байдлаар хэдүүлээ явахаа больё. Ялангуяа энэ өмч хувьчлалтай холбоотой асуудалтай юман дээр манай Ардчилсан намынхан ч гэсэн бүлэг дээр их сайн ярилцах хэрэгтэй байгаад байгаа. Энэ 1990 оны хувьчлал, чөлөөт эдийн засаг, эрх, эрх чөлөө, шударга ёсны төлөө энэ Ардчилсан нам гарч ирсэн. Тэгээд юу болсон 35 жил Монгол Ардын намынхан маань л эрх барьж байгаа шүү дээ. Нэг удаа Ардчилсан нам дөнгөж нэг олуулаа л болсон. Тэгээд энэ хугацаанд хийж чадаагүй, яг тэр загвараар л одоо орж ирж байна гэж харж байна.

Тэгэхээр ажлаа сайжруулах хэрэгтэй байна. Их Хурлын гишүүд дээр нэлээн тийм, энэ Байнгын хороодоор ялангуяа мэргэжлийн Байнгын хороодоор дахиж энийг ярих ёстой. Тэгээд энэ гишүүдийн хэлж байгаа юмнуудыг авах хэрэгтэй. Тэгэхгүй зүгээр нэг сонссон маягтай болоод ингээд түрээд, түрээд явдаг энэ тогтолцоог одоо зогсоох хэрэгтэй. Олон гишүүд хэлж байна шүү дээ. Яах вэ тэгээд яг тэгж явдаг юм. Бид чинь олон юмыг ингээд харчихлаа шүү дээ Бямбацогт сайдаа. Яг хэлэлцэх эсэх нь шийдэгдэнэ гээд тэгээд л цаашаа явна, Ажлын хэсэг байгуулдаг. Ажлын хэсэг дээрээ яг энэ концепцоор нь шахсаар байгаад л явдаг шүү дээ. Нэг их өөрчлөгдсөн олон юм бол байдаггүй шүү дээ. Олон л юм бид харлаа шүү дээ, тийм биз дээ? Тийм саналтай байна.

Тэгээд Их Хурлын гишүүд маань энэ, ялангуяа энэ өмч хувьчлалтай холбоотой юмыг энэ намынхаа бүлгүүдээр оруулж ирэх хэрэгтэй гэж харж байна. Ардчилсан намын бүлгээр энэ бол зайлшгүй орж ирэх ёстой. Гишүүд маань нэгдсэн байр сууринд хүрэх ёстой байх манай Ардчилсан намынхан. Тэгж байж явах ёстой юм болов уу гэж харж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Ерөнхийдөө зүгээр уг асуудлыг гаргаж ирж ярих нь зөв байгаад байгаа юм. Ярихаасаа өмнө нөгөө энэ олон нийтийн болгох өмч хувьчлалыг зохион байгуулах өмнөх алдааг давтахгүйн тулд үр нөлөөтэй, эдийн засгийн үр өгөөжийг нь

бүх нийтээрээ яг тэгш, шударгаар хүртэхийн тулд бэлэн байдлын үнэлгээг бүх талдаа анхаармаар байгаа юм. Төр өөрөө бэлэн үү, зах зээл бэлэн үү, өмч хувьчлал буюу энэ олон нийтийн болгосны дараах хууль, эрх зүйн орчин бэлэн гээд энэ асуултуудад хариулт өгч байж, тодорхой болгож байж энэ өмч хувьчлал үр нөлөөтэй явна. Тэгээд сая Бямбацогт сайд өөрөө Нийтийн өмчийн хууль болон тэр Төрийн өмчит компанийн засаглалтай холбоотой хууль батлагдсаны дараа энийг уялдуулж гаргая гэдэг саналаа өөрөө хэлж байгаа. Энийг би протоколд заавал үлдээсэй гэж бодож байна. Тэр хууль, эрх зүйн орчин гараагүй байж байхад энэ өмч хувьчлалыг явуулж болохгүй, ер нь бол ...нь. Тэр хуулиа бид хэд маш зөв гаргачхаад, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг нь хаанаа хамгаалагдах юм, стратегийн хөрөнгө оруулагчдыг аль, аль салбар дээр оруулж ирж болох юм.

Хэрэвзээ ерөнхийдөө 100 хувь юм уу, 50-аас, 51-ээс дээш хувьд байдлаар хувийн хэвшилд өгвөл хориг тавих эрхүүд авах уу, үгүй юу. Маш олон зүйлүүдийг тодорхой болгомоор байна. Тэгээд ер нь Өрсөлдөөний хууль тогтоомж, эргээд энэ Монополын хууль ч байдаг юм уу энэ бүх зүйлүүд чинь тодорхой болж байж энэ IPO үнэ цэнтэй болж, үр ашигтай ажиллана. Тэгээд оруулсан хөрөнгө оруулалтыг ч гэсэн хамгаалах хууль, эрх зүйн орчин байх ёстой. Энэ бүх зүйл тодорхой болоогүй байна гэдгийг сая олон гишүүд хэллээ. Анар гишүүн хэллээ, Очирбат гишүүн хэллээ, Пүрэвдорж дарга хэллээ, Батсүмбэрэл гишүүн хэлж байна. Энэ юмнуудаа хийгээч, дэс дарааллыг нь яг зөв алдагдуулахгүй хийгээсэй. Тэрнээс биш эсэргүүцээд байгаа зүйл биш. Яг энэ 30 хэдэн компаниас ерөөсөө амжилттай болох ерөөсөө 2, 3-хан л гарах юм байна лээ. Тэгээд МИАТ л байх л даа, Төрийн Төрийн банк. Энэ рүү л чиглэж байна. Одоо хардаад байгаа, битгий хардаад бай, мушгиад бай гээд байгаа. Угаасаа ойлгомжтой л байна шүү дээ.

Тийм учраас үндэсний баялаг, энэ Үндсэн хуульд заасан баялагтаа эзэн байхын тулд, Ашигт малтмалын хуулийн 5.6-г бас амилуулахын тулд магадгүй тэр төрийн өмчит уул уурхайн компанийн тодорхой ажиллагсад нь хувьцааг нь эзэмшүүлдэг баймаар байна. Уул уурхайн салбарыг орон нутагт хүлээн зөвшөөрүүлэхийн тулд сумын түвшнээсээ, аймгийн түвшнээсээ дэс дараатайгаар хувьцааг нь авах боломжийг нь эхлээд олгодог болмоор байна. Ийм байдлаар бид энэ уул уурхайгаас түшиж босож ирэх энэ бүх зүйлүүдээ энэ өмч хувьчлалын бодлогодоо зөв хийж чадвал бид зөв явна. Энэ дээр ч гэсэн хөрөнгийн зах зээл амилна. Ийм зүйлүүдийг ингээд анхаараач. Түүнээс биш стратегийн хөрөнгө оруулагч нэртэй 10 хувийг авсан ч гэсэн шийдвэр гаргалт дээр оролцохгүй бол хэн ч орж ирэхгүй, ийм тэнэг хүн байхгүй. Тэгэхээр магадгүй 10-аас 15, 20 хувь, 34 хүртэлх хувийг оролцууллаа гэхэд ийм, ийм эрх дээр та нар зөвлөх, туслах, ингэж оролцох эрхтэй гэж хуулийг нь баталж байж, эсвэл Засгийн газар тэр стратегийн хөрөнгө оруулагчидтай тодорхой хэмжээний гэрээ байгуулах эрхийг нь олгож байж энэ чинь явна.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйн орчин чинь бүгд бэлэн биш байна. Хөрөнгө эрсдэлээ гэхэд яаж татах юм бэ гэдэг Төлбөрийн чадваргүйдлийн хууль нь алга байна. Ийм байхад бид өмч хувьчлал гэдэг зүйлүүдийг ийм олон нийтэд 30, 40-өөр нь хувьчлах гээд байгаа юм шиг ийм зүйл байж болохгүй. Тэгээд амархан байна л даа. АЗЗА ашиггүй ажиллаад байвал татан буулгачихна. Үгүй ээ тэр даваа гүвээ дээр чинь угаасаа цас мөс орох нь ойлгомжтой. Хэзээ ч АЗЗА-н чиг үүрэг ерөөсөө алга болохгүй байхгүй юу. Харин тэр замыг өмчлөлийг АЗЗА-даа хариуцуулаад, замын хураамж төлбөрөө авдаг болох уу, тэр замыг бүхэлд нь хариуцдаг болох уу энэ тэр гээд бид хэд менежментээ сайжруулаагүй байж ийм зүйл рүү явж болохгүй. Тэгээд сая Цэнгэл дарга хариуллаа шүү дээ. Баахан улс төрийн томилгоотой

менежерүүд оччихоод байхад ер нь манайд өмч хувьчлалын өмнө ийм зүйл ярьж байхад орж ирэх үү. Тэгэхээр бид хэд мэргэжлийн бөгөөд актив удирдлагатай яг томилогддог болох тэр хууль, эрх зүйн орчноо эхлээд бүрдүүлэх ёстой юм. Өөрөөр хэлбэл сонгон шалгаруулалтаар энэ яг чаддаг хүмүүс нь томилогддог болох ёстой. Ингэж байж энэ хөрөнгө оруулалт энэ тэрд чинь итгэнэ. Түүнээс биш одоо зүгээр нээрээ сая хэн хэлчхэв, намын хүмүүстэй зодолдох гэж хэн ч хөрөнгө оруулалт хийж орж ирэхгүй байхгүй юу даа. Энэ үнэн шүү.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн.

М.Батсүмбэрэл: Ярьж болно биз дээ Сэддорж дарга, өнөөдөр нэлээн юутай байх чинь, урьд шөнө жоохон нойр муутай байсан уу. Би энэ тогтоолын төслийг дэмжихгүй, энэ цаг нь болоогүй байна. Хууль, эрх зүйн орчин нь нээгдээгүй байна. Энэ ААН-үүд нь, төрийн өмчийн компаниудын захирал нь Амартүвшин захирлаас өөр хүн ирээгүй байна шүү дээ олигтой хүн. Тэгээд одоо ийм байж ямар юмныхаа өмч хувьчлалыг нь ярих вэ дээ. Тэр хэд ямар бодолтой байгаа юм санаа бодлыг нь сонсох ёстой.

Харин Эрдэнэс Монгол дээр Даваадалай томилогдсон юм байна, амжилт хүсье. Энэ олон улсын боловсролтой нэг сайн залуугаа томилогдсон байна. Тэгээд ер нь энэ мэдээлжсэн, олон түмэн мэдээлэлтэй болсон гэдэг худлаа шүү. Улаан, цэнхэр тасалбарынхаа учрыг олоогүй хүмүүс олон байгаа шүү. Энд хохирсон, хаягдсан, гээгдсэн хүмүүс олон байгаа шүү. Болдог бол энэ өмч хувьчлалаар нээлттэй сонсгол хиймээр байгаа юм, Түр хороо байгуулмаар байгаа юм. Тэр олон зочид буудал, төрийн өмч, уул уурхайнуудыг хэн авсныг нь олон түмэн мэдмээр байгаа юм. Сонины цаас, шар хуудсаар сонсдог биш, энийг олон нийтэд ил гаргаж тавимаар байгаа юм. Ингэж байж энэ өмч хувьчлал гэдэг юмыг чинь ойлгох юм.

Ардчилсан намынхан энэ дээр бухимдалтай байгаад байгааг ойлгож байгаа. Монголын орчин үеийн улс төрийн түүхэнд нэг удаа үнэмлэхүй ялалт байгуулсан 96-аас 2000 онд. Тэр үедээ өмч хувьчлал гэдэг юмыг хийж өм цөм шаасан. Нөгөө Ардчилсан нам бол яг өмч хувьчлалыг бол хуссан нам шүү дээ. Төлөөллүүд нь жоохон уурлаад байгаа, тэгээд уурлаад байгаа. Тийм учраас энэ өмч хувьчлалын асуудлыг их ултай суурьтай ярих ёстой. Ийм учраас, Пүрэвдорж гишүүн түр байж байх уу, манай Пүрэвдорж гишүүн бас энэ өмч хувьчлал дээр хоцорчих гээд байгаа асуудлууд байх шиг байгаа юм. Өмнө нь ч хоцорчихсон юм шиг байгаа юм. Тэгээд энэ өмч хувьчлалын асуудлыг жоохон хойшлуулчихъя гэдэг ийм саналтай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Батсүмбэрэлд хэлэхэд өнгөрсөн хугацаанд энэ Ардын намын хулгай зэлгийг болиулахын төлөө үхтлээ зүтгэлээ. Энэ хугацаанд асар их хулгай хийлээ. Үгүй ээ та нарын хийсэн хулгай мөн ч их дээ. Тэгээд тэр болгоноосоо маш асар их мөнгө олсон. Тэр нүүрсний хулгайны мөнгө бүгдээрээ яаж тэрнийгээ цэвэршүүлэх вэ гэдэг ийм л юм явж байгаа.

Тэгээд би танд нэг ганцхан тоо хэлье. Ер нь өнгөрсөн хугацаанд би хэлж байна шүү дээ. Ховд аймагт 83 ААН хувьчлагдсан тэрний 79 нь тухайн үеийн нэгдлийн дарга байсан, тэр ААН-үүдийн, Монгол Ардын намын хорооны дарга байсан тэр хүмүүс л бүгдээрээ авцгаасан байхгүй юу даа. Тэгээд өнөөдөр энэ хувьчлал явлаа гэхэд хамгийн ашигтай хэдхэн компани дээр орно гэдэг нь үнэн. Бусдаар 10 хувийг нь хувьчилсан энэ юман дээр орохгүй. Тэгээд энэ дээр ер нь нэг

л юм ил болно. Тэр нь нүүрсний хулгайны мөнгөнүүд бүгдээрээ албан ёсны хөрөнгө болж хувирна. Энэ бүх зүйлийг сая Очирбат гишүүний хэлсэнчлэн тодорхой хэмжээгээр нэлээн ул суурьтай асуудалд хандаж байж, ярьж байж юмаа шийдэхгүй бол арай л ийм хуудуутай орж ирж байна. Мэдээж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Цэнгэл дарга бол яг энэ компаниудынхаа талаар нэлээн сайн мэдлэгтэй байгаа.

Тэгэхдээ энийг хэчнээн та их зөв зүйл бодож байгаа ч гэсэн цаана чинь энэ юман дундуур нь тэгээд сиймхийгээр нь ашигладаг маш их олон нөхдүүд ард таны олон дарга нар байгаа. Тэд чинь л энэ зүйлийг ашиглаж, энэ хулгайн мөнгөө бүгдийг нь албан ёсны болгох тэр л ажлыг хийх гэж байна гэж харж байна. Тийм учраас энэ бол тэгээд их л, энэ чинь хяналтын багцыг нь өгөхгүй бол гадаадын хөрөнгө оруулагчид орж ирэхгүй.

Тэгээд юу болох вэ гэхээр ямар ч үнээр хамаагүй хөрөнгөө албан ёсны болгох гэж байгаа энэ 9 жилийн туршид энэ төр засаг барьж, энэ олон хулгайнаас хийсэн тэр мөнгөнүүдээ бүгдийг нь албан ёсны болгох гэсэн тийм хүмүүсийн л хүсээд байгаа зүйл болж хувирна шүү гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж дуусаж байна. 2 хүн, би эхлээд хэлчих үү, нэлээн их ярилаа. Энэ 34 хувийг нь төрдөө үлдээгээд, 33 хувийг нь МХБ-ээрээ дотоодын ААН-үүддээ, хөрөнгийн биржээ л ажилд оруулна гэсэн үг шүү дээ. Хөрөнгийн бирж чинь байгаа энэ байгаа боломждоо маш гайгүй ажиллаж байгаа юм байна лээ шүү дээ ер нь. Тэгээд 33 хувийг нь Монголын ард түмэндээ, ялангуяа тэр 1072 хувьцаагаа нэмж нөгөө дорвитойхон ноогдол ашиг өгчихөөр ингэж өгөх хэрэгтэй. Тэгээд одоогийн хуулиар 34 хувь нь төрдөө байгаад, ингээд 33 хувь нь ард түмэндээ байгаад, ингээд тэгээд дотоодын ААН-үүддээ чөлөөтэй МХБ-ээ маш сайн ажиллуулаад ингээд явах боломжийг та бүхэн маань энд яг хариуцсан албаны хүмүүс нь байна. Энийг Бямбацогт сайд тэргүүтэй, Цэнгэл дарга, бусад бүх хүмүүс маш олон жил ярьж байгаа шүү дээ. Одоо бид ярихгүйгээр хэзээ ярих вэ гэж бодож байна. Одоо яг өнөөдөр цаг нь ирсэн, ирээгүйг сайн мэдэхгүй.

Гэхдээ энэ чинь ашиггүй ажиллаад байгаа үйлдвэрийг яах юм бэ, ашиггүй ажиллаад байгаа үйлдвэрийн захирал хийх чинь хэцүү шүү дээ. Тэгээд л байнга нэг ашиггүй ажиллаж байгаа үйлдвэрийн захирал гээд, алдагдалтай гээд л ингээд л хүн харсан ч гэсэн нэг. Цэнгэл дарга бол тийм олон байгууллага хариуцаж явж байгаа. Дээрээс нь 51 хувиас дээш хувьцаа эзэмшихгүйгээр хүн орж ирэхгүй шүү дээ тийм ээ. Банк л биш бол, 30 хувь, 5 хувь, 10 хувьтай бол тэр компанид ямар ч нөлөө байхгүй шүү дээ тийм ээ. Тэгэхээр энийгээ яг нэг хөдөлгөж байгаа юм бол нээлттэй 34 хувиас 51 хувь ингэж хөдөлгөж энэ компаниудаа идэвхжүүлсэн нь дээр байх гэсэн ийм саналуудыг хэлье.

Тэгээд Эрдэнэс Тавантолгой байна Монгол Улсаа тэжээгээд л байдаг, Монгол Улсын валютын нөөцийг бүрдүүлээд л байдаг муу нэртэй. Тэгэхээр энэ бол ирээдүй ерөөсөө л ингэж олон хяналттай болгох л хэрэгтэй. Олон талаасаа хяналттай байвал энэ компанид чинь хэн ч халдаж чадахгүй. Баярлалаа. Одбаяр гишүүн, Бямбацогт гишүүний нэрийг үгэн дээр нэмье. Одбаяр гишүүн эхлээд ярих уу?

Э.Одбаяр: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ уг нь чөлөөт эдийн засагтай, зах зээлийн эдийн засагтай нийгэмтэй улс оронд зайлшгүй хийгдэх өөрөөр хэлбэл төр өмчөөсөө салах, цомхон

байх, эдийн засаг дахь төрийн оролцоо багасгах гээд бидний явж байгаа зүйл рүү ороход их тийм гүн, өөрөөр хэлбэл төрийн оролцоог хязгаарлах, хазаарлах, төрийн өмчит ААН, төрийн алба дээр аль алин дээр нь чухал үйл явдал л даа. Тэгэхдээ одоо би гайхаад л хараад байна. Яг хуучнаараа сэтгээд байна л даа. Хуучин нийгэмчилнэ гэдэг шиг шууд тоогоор нь заагаад төрийн өмчит ААН-үүдээ бөөнөөр нь хувьчилж байгаа нэртэй хувьцааных нь тодорхой хэсгийг Хөрөнгийн биржээр дамжуулаад гээд яах вэ өмнөхөөсөө ялгаатай нь нэг тийм үг нэмчхэж байгаа юм.

Гэхдээ анх 90 оны дараа хийгдэж байсан өмч хувьчлалын үеэс хойш одоо 35 жилийн дараа дотоодын болоод олон улсын энэ хөрөнгийн зах зээл, энэ валют, олон улсад энэ хөрөнгийн зах зээлийн гарах урсгал чинь нээгдчихсэн, энэ бүх боломжуудыг тооцсон юм алга. Хувьчлахаар оруулж ирж байгаа компаниудынх нь нийт зах зээлдээ хэдэн хувийг эзэлж байгаа юм бэ гэдэг тийм зах зээлийн судалгаа алга. Ер нь нэг талдаа хувьчлалыг оруулж ирж байгаа, бодлогыг нь оруулж ирж байгаа юм шиг мөртөө нөгөө талаараа жинхэнээсээ энэ ажлыг явуулах сонирхол энэ Ардын намынханд байхгүй байна гэж би харж байгаа. Зүгээр энэ улс төрийн хэрүүлтэй үед нь энийг оруулж ирье л гэдэг бодол байх шиг байна.

Тэгээд дээрээс нь сая тэр нэг дэд сайдууд энэ тэр томилохдоо төрийн өмчит ААН-үүд дээр баахан Ардчилсан намын хяналтын менежерүүд томилчихсон юм шиг тийм мэдээллийг олон нийтэд түгээж байгаад ингээд хойноос нь энэ хувьчлал гэдэг юм уу, юу гэдэг юм энэ ажлыг хийнэ. Ар дээр нь яах вэ гэхээр өмнө Ардчилсан намаас хэдэн хүмүүс томилогдчихсон байсан тэгээд энэ failed-сэн л гэдэг яриа хийхээр би бэлдэж байгаа юм болов уу гэж ойлгож байгаа. Мөн чанар дээрээ бол юу вэ гэхээр баахан л сандал ширээ дарга цэрэг нар солигдож, Ордон дотор өрөөнүүд нүүгээд л, нөгөө албан тушаалуудаа хуваарилаад дуусчихсан дэд сайдууд, элчин сайдуудаа томилж дуусаад, одоо тэр томилгоо хуваарилалт нь төрийн өмчит ААН-үүд рүүгээ орж байгаа юм байна гэж ойлгож байна.

Тэгээд одоо энийг хэдүүлээ нэг тийм бялуу хуваах байдлаар биш, жинхэнээсээ энэ чөлөөт эдийн засгийг дэмжих, төрийн өмчийг багасгах, төрийн өмчит ААН-үүд хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байдаг энэ байдлыг багасгах, дээрээс нь IPO хийж хөрөнгө оруулалт татаж, олон нийтэд хувьцаагаа гаргаж санал болгосноороо тухайн компанийн мөнгөн урсгалын хэмжээ сайжирч, үйл ажиллагаа нь нэмэгдэх энэ чиглэл рүү нь буюу сонгодог утгаар нь хөрөнгө оруулалтыг нь нэмэгдүүлж хувьчлах энэ чиглэл рүүгээ явах сэтгэл зүйн бэлтгэл энэ эрх барьж байгаа намд одоогоор байхгүй байна гэж анзаарч байгаа учраас энэ асуудлыг би дэмжихгүй гэдэг байр суурьтай байгаа. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ хандаж хэлэхэд цаг нь арай болоогүй юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр хойшлуулах нь зүйтэй байх л гэж бодож байна.

Р.Сэддорж: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Яг бидний Их Хурлын байж байгаа байдал энэ л дээ. Тэгээд л худлыг үнэн болгох гээд л, үнэнийг худал болгох гээд л, тэгээд айхад аргал хөдөлнө гэдгээр хардаад л сэрдээд л бие биеийгээ. Одоо энэ, харин шинэ гишүүд, залуу гишүүдтэй болсон илүү прагматик, илүү либерал, илүү урагшаагаа харж, өнгөрснийг биш урагшаагаа харж ажилладаг болсон гэж ойлгосон. Гэтэл яг л ялгаа алга л даа маниустайгаа адилхан юм байна. Тийм. Тийм, харин тийм. Харин тийм, зарим нэг, зарим нэг шүү, уучлаарай. Ингээд үнэхээр тэгээд л хардаад, сэрдээд, өнгөрснөө яриад л, үгүй ээ 90 оны хувьчлалын хувьд аль, аль нь алдсан байх. Одоо нэгэнтээ өнгөрсөн юмыг яриад яах юм бэ бид энд. Алдаан дээрээсээ сургамж аваад, урагшаа

хараад, урагшаа л харж аль болох зөв болгоод, сайн болгоод энэ цаг үеийнхээ хөгжил, нийгэм, эдийн засгийнхаа амьдралд нийцүүлээд дасгаад ингээд л зөв болгоод явцгаая л гэж байгаа шүү дээ.

Тэгээд Улсын Их Хурал өөрөө Засгийн газарт үүрэг өгсөн шүү дээ 26 онд багтааж үндсэн чиглэлийг нь оруулж ир гэж. Тэгээд 26 ондоо багтаагаад л оруулаад ирэхээр нийлж байгаад эд нар чинь нэг хулгай хийх нь дээ гээд ингээд л бие биеэ хардаад л, улам зүв зүгээр ингээд сайхан явчих ажлаа тийм үү, энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон шүү дээ, 26-аас 30 онд Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд орчихсон шүү дээ, жилийн төлөвлөгөөнд орчихсон шүү дээ. Их Хурал өөрөө энэ бүгдийг баталсан шүү дээ. Тэгээд Их Хурал л Засгийн газар энийг оруулж ир гэж шахсан шүү дээ. Хуулиар, хууль албажуулж үүрэг өгсөн шүү дээ. Тэгээд энийг нь ингээд оруулаад ирэхээр тэгээд ингээд л худлаа үлгэр зохиогоод л, үнэнийг худал болгоод л, худлыг үнэн болгож ард иргэдийн дунд айдас төрүүлээд л, аль өнгөрсөн баларсан юм ярьж ингээд бие биетэйгээ хоорондоо хийрхээд л, сая ингээд хоорондоо хийрхээд л асуудал болж байна шүү дээ. Тэгээд ингээд өнгөрсөн баларсан юм яриад байх ямар хэрэгтэй юм, урагшаа хараад бас нэг жоохон өөдрөг бодолтой ажиллацгаая л даа.

Тэгээд ингээд бие биеийнхээ хооронд Ардын нам, Ардчилсан нам, танайх хулгайч, манайх хулгайч, танайх хулгайч биш, манайх хулгайч биш, танайх бага хувьчлал авсан, манайх бага хувьчлал авсан гээд ингээд л ийм нэг шалдар булдар юм ярьж хоёрын хооронд улс төржих ямар хэрэгтэй юм. Их Хурлын гишүүн бол Их Хурлын гишүүн шиг байцгаая л даа. Төрийн түшээ юм бол төр түшилцэх юм бол түшилцсэн шиг л түшье л дээ. Тэгээд нэг жижигхэн юм яриад л, жижигхэн чавганцын хэрүүл хийгээд л, энэ жоохон онцгүй байна шүү тийм. Ийм байдлаар асуудалд уул нь хандмааргүй байна шүү. Энэ чинь төрийн бодлого шүү дээ, 5 жилийн үндсэн чиглэлд орсон үндсэн чиглэл шүү дээ. Үгүй ээ унагаа, унагаа хамаа алга. Тийм. Их Хурал оруулж ир гээд Их Хурлын өгсөн үүргийг биелүүлж байгаа. Бусдаар юу гэдэг юм худал хуйвалдаад, хулгай хийх гэж байгаа юм ерөөсөө байхгүй. Тэгээд л бие биеэ хардаад л, өөрсдөө их мундаг шударга хүмүүс. Бусад хүмүүс нь их хар хэрээ, хулгайч хүмүүс гэдэг ойлголт нийгэмд өгөөд л, тэгээд тэр нийгэм тэрийг нь авч сэвээд л, эдний ёстой болохгүй гээд л.

Тийм болохоор энэ Улсын Их Хурлаас баталсан Үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн Хамтдаа хөгжлийн төлөөх зориг гээд Ардын нам, Ардчилсан нам хамтраад л баталсан мөрийн хөтөлбөр байгаа шүү дээ. Тэн дотор чинь маш тодорхой 3, 4 заалттай суучихсан байгаа юм. Тэрийгээ л хэрэгжүүлье гэж уул нь өнгөрсөн жилийн 24 оны 12 сарын 12-ны өдөр Улсын Их Хурал 52 дугаар тогтоол баталж, 26 ондоо багтааж оруулж ир гэсэн, энэний дагуу Засгийн газар оруулж ирлээ. Их Хурлын гишүүд маань нэг жоохон том харцгаая, жоохон бас нэг жоохон бодлого бодоцгооё. Тэгээд энэ нээлттэй, ил тод, 90 он биш, бүх юм тийм үү цаг үе өөр болсон. Тийм болохоор нэг хардахаасаа илүү ил тод, нээлттэй, илүү яаж ард иргэддээ өгөөжтэй, төрдөө үр ашигтай, тэгээд энэ бодлого маань хэрэгжээд, хувийн хэвшлээ дэмжсэн, төрийн эдийн.../минут дуусав/

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүнийг үгэн дээр нэмье. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Миний хувьд энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Бид яах вэ өмнөх хийгдсэн хувьчлалын түүхүүд, гаргаж байсан алдаа дутагдлыг ярьж байна, ярьж байгаа нь зөв. Олон жил улс төрд явсан ах нар маань алдаа гаргасан, алдаагаа давтаж болохгүй гэдгээ мэдэж байгаа. Түүнийгээ хэлж

ярьж байгаа нь сайн хэрэг. Одоо бид харин тэр туршлага дээрээ үндэслээд алдахгүй л явах хэрэгтэй. Илүү сайн л хийх хэрэгтэй.

Хууль, 2 ч төрлийн хууль явж байгаа. Энэ ажлын хэсэг шинэчлэн байгуулагдахаар Улсын Их Хурлын даргын захирамжийн төсөл явж байна. Удахгүй батлагдах байх. Хуулийн асуудлыг бид хаврын чуулганаас эхлээд, хэлэлцэх эсэхээ дэмжүүлээд ингээд процесс явахад бол эргээд л намрын чуулган өнгөрнө, бараг л бүтэн жилийн ажил болно. Тэр хооронд энэ компаниудыг нээлттэй болгох, хувьчлах энэ асуудлууд нь бэлтгэлээ хангаад л явж байг л дээ. Энэ чинь өнөөдөр шийдвэр гараад, маргааш хувьчилчих тухай асуудал биш. Процессын маш олон шат дамжлагатай ажлууд хийгдэнэ. IPO гаргахын тулд хамгийн наад зах нь л олон улсын аудитын байгууллагаар аудит хийлгэхээс эхлээд л, хөрөнгийн үнэлгээ хийлгэхээс авхуулаад л их л олон процессын ажлууд байгаа шүү дээ. Тэгээд энэндээ төлөвлөлтүүд нь хийгдээд л, Их Хурлын тогтоолоо үндэслээд л бэлтгэл ажлаа хангаад явж байг л дээ.

Үнэхээр өөрчлөх шаардлагатай зүйл хуулийн төслөөр гараад ирвэл, хууль дээр гараад ирвэл хуульд орсон өөрчлөлтийнхөө дагуу тогтоолын төсөл өөрчлөх асуудлаа хамт өргөн бариад л явчихна шүү дээ. Уялдуулж болохгүй асуудал бол ерөөсөө биш гэж харж байгаа. Улсын Их Хурал Засгийн газарт үүрэг чиглэл өгч, мөрийн хөтөлбөрийг нь батлахдаа 5 жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөг нь батлахдаа өгчихсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг нь дэмжиж явах нь зүйтэй гэж бодож байгаа. Хэлэлцэх эсэхээ дэмжээд тогтоолд оруулах зарчмын асуудлууд байгаа бол явцын дунд өөрчлөөд л явна биз. Энд болохгүй зүйл байхгүй гэж харж байна. Тэгэхээр хэдүүлээ нэг нэгнийхээ ажилд яах вэ улс төр байлгүй яах вэ. Гэхдээ бүгдээрээ бид сонгуульд аль, аль нам нь л амлаж гарч ирсэн. Эдийн засгийн эрх чөлөөг дэмжье, бэхжүүлье, энэ аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай төр зууралдаж, ТӨК-уд булаацалддагаа больё, энэ ТӨК-удыг цөөлье, хувьчилъя, IPO гаргая, нээлттэй засаглалтай болгоё гээд л бүгд амласан шүү дээ. Тэгээд тэрнийхээ эхний алхмыг үе шаттай хийгээд явахад яагаад болохгүй гэж.

Тэгээд энийг дэмжээд, тодорхой алхмуудыг нь хийлгээд, ажлын төлөвлөлтөд нь харин Улсын Их Хурал эндээ хяналтаа тавиад явах нь зүйтэй гэж бодож байгаа. Тэгээд хэдүүлээ улс төржих сэдэв дээрээ тодорхой зааг хязгаартай баймаар санагдах юм яг үнэнийг хэлэхэд. Бид парламентын түүхэнд 126-лаа болсон анхны парламент. Энэ парламентын засаглалын нэр хүндийг хамгаалж байх үүрэг нь би парламентын гишүүн болгонд байгаа гэж бодож байгаа. Аль нам, эвслээс үл хамаараад. Тэгээд баахан томилгоо хийлээ, парламент юм хийсэнгүй намрын чуулганаар л гээд байгаа юм. Тэгээд энэ томилгоо чинь яагаад хийгдсэн юм бүгд Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнууд бүгд хугацаатай, хугацаа нь дуусаад, хуулиар тогтоосон хугацаа нь дуусаад зайлшгүй томилгоо хийх хугацаа нь яг энэ үед л таарчихлаа шүү дээ. Тэгээд л энийг нэг томилгоо хийх өөр хүсэл сонирхолгүй юм шиг, томилгоо хийхээс өөр ажилгүй юм шиг энэний төлөө л энд хэдэн гишүүд суугаад байгаа юм шиг өөрсдийнхөө ажлыг ингэж нийгэмд буруугаар ойлгуулж, буруугаар харлуулах ямар хэрэгтэй юм. Бидний хамтын ажлын л үр дүн шүү дээ. Энэ парламентын хийсэн ажлын л үр дүн шүү дээ. Тэгээд энэ асуудал дээрээ хэдүүлээ нэг жоохон зааг ялгаатай хандаж баймаар байна.

Тийм учраас эрхэм гишүүдээс би энэ тогтоолын төслийг дэмжээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, харин сайжруулаад, цаашдаа хуультайгаа нийцүүлэх, өөрчлөх асуудлуудаа үе шаттайгаар яриад, энэ бэлтгэл ажлыг хангуулаад явах нь зүйтэй

гэдэг дээр би санал хэлмээр байгаа юм. Ганц жишээ хэлэхэд энэ тогтоолын төсөлд орсон Эрдэнэт үйлдвэрийн асуудал. Би хамгийн ойр мэдэж байгаагаараа жишээ аваад хэлье. 10 хувийн асуудлыг хувьчлалын асуудлыг оруулахын тулд эхлээд 49 хувийн маргааны асуудлыг шийдвэрлэх ёстой, яг энэ тогтоолын төсөл дээр орсон байна лээ. Энэ 49 хувийн асуудлыг дуусгаад, 10 хувийг нээлттэй хувьчлах асуудлыг оруул гээд. Тэгээд энд бол бас процесс явна. Тэгэхээр Их Хурал эндээсээ үүргээ өгөөд явж байх нь зүйтэй. Тийм учраас та бүхнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. 12-оос дээш гишүүд ирцэд орсон байх ёстой, санал хураалтад бэлдсэн байх ёстой.

Саналын томъёоллыг уншъя. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-аас 2028 онд биржээр болон олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-аас 2028 онд биржээр болон олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд, гараа өргөөрэй. Чуулганы нэгдсэн хуралдаанд унших Үүрийнтуяа, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа танилцуулна. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

16.42 цаг

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах талаар Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны даргын хувьд ажлын хэсгийн ахлагчид Улсын Их Хурлын гишүүн Мандхайн нэрийг дэвшүүлж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох хүсэлтэй гишүүд саналаа өгье? Мандхай гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Уянга гишүүн. Ингээд 3 гишүүн, 3 гишүүнээр байгуулъя. Цаашаа хүн нэмэх боломжтой ажлын хэсэг дээр. Өөр нэг гишүүн байна уу? 3 байна. Соронзонболд гишүүн орох уу? Уянга гишүүн хасагдаж байна. Мандхай гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Соронзонболд гишүүн. Хэн Очирбат гишүүн орох уу? Ингээд 3 гишүүнээр байгуулчихъя. Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье? Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбогдуулж, тогтоолын төсөлтэй холбогдуулж.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай

хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Мандхай, ажлын хэсгийн бүрэлдэхүүн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Эдийн засгийн байнгын хорооны дарга. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Дамдинням гишүүн орсон уу? Тийм, ажлын хэсэгтэй холбоотой, тогтоолын төсөлтэй холбоотой? Алга байна. Асуулт, саналтай гишүүд алга байна. Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Би бас энэ ажлын хэсэгт оръё.

Ингээд саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг, тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 59,1 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоол батлагдлаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

16.50 цаг

Тав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 5. Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолтой холбогдуулан боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг баримтлан боловсруулсан тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

М.Энхцэцэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын дарга Учралын санаачилгаар Монгол Улсыг хөгжүүлэх 2026-аас 30 оны чиглэлд, мөн Засгийн газрын 2024-өөс 28 оны хөгжлийн хөтөлбөр дээр ногоон эрчим хүч, тэр дундаа тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх гэж заасан байгаа. Тэгэхээр энэ ажлуудыг эрчимжүүлэх зорилготой чиглэлийг өгөх ийм тогтоолыг Улсын Их Хурлаас гаргаж байгаа. Энэ тогтоолын хүрээнд ер нь тархмал эх үүсвэрийг 3 чиглэлээр эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ чиглэл рүү ажилла гэсэн ийм чиглэл өгч байгаа. Энэ 3 чиглэл болохоор 1 дүгээрт нь айл өрхийн тархмал эх үүсвэр, 2 дугаарт нь аймаг, сумдын тархмал эх үүсвэр, 3 дугаарт нь автомашиныг цэнэглэх тархмал эх үүсвэр гэсэн ийм 3 чиглэлээр ногоон эрчим хүч, тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх чиглэл өгч байгаа.

Айл өрхийн тархмал эх үүсвэрийн хувьд та бүхэн мэдэж байгаа сүүлийн үед ялангуяа гэр хорооллын айл өрхүүдэд нарны панель батарей халаагууртаа нь суурилуулаад, яндангаа салгаад, агаарын бохирдлыг бууруулах, улмаар хэрэглэгч маань илүүдэл цахилгаанаа сүлжээ рүү борлуулаад орлого олох, тийм боломжийг бүрдүүлэх төслүүд нэлээн олноор хэрэгжүүлж байгаа. Эхнээсээ 3 жил болоод үнэхээр бидний панелиараа, нарны эрчим хүчээр айл өрхийг яндангаас салгаж болох юм гэдгийг ингээд харуулаад батлаад явж байгаа. Гэхдээ энэ төслүүдийн хувьд яг одоогоор ингээд хэрэгжүүлж байгаа тоо нь аягүй цөөхөн учраас нэг айлын хөрөнгө оруулалт харьцангуй өндөр байгаад байгаа.

2 дугаарт нь болохоор энэ айл өрхийн тархмалын эх үүсвэрийг сүлжээнд холбох асуудал нэлээн хүндрэлтэй байгаа. Бараг техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлаа туршилт тохируулга хийх шалгуулах гээд бараг 6 сар болж байж сүлжээнд холбох гээд гэх мэтчилнээр маш олон хүндрэлтэй асуудлууд 1 дүгээрт байгаад байгаа. Тийм учраас энэ айл өрхүүдийн тархмал эх үүсвэрийн асуудлыг ийм цөөхөн тоогоор биш, их хэмжээтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ингэж байж нэг айлын хөрөнгө оруулалт багасна. Ингэж байж энэ айлууд яндангаасаа салснаас агаарын бохирдлыг бууруулахад үзүүлж байгаа нөлөө маань маш том зургаараа нөлөөлөл нь харагдана гэдэг ийм чиглэлийг өгч байгаа. Тэгээд үүн дээрээ аль болох айл өрхүүдийн тэр жижиг оврын нарны тархмал эх үүсвэрийг болохоор сүлжээнд холбохдоо маш хялбар байдлаар холбох шаардлагатай байна. Энэтэй холбоотой тэр журмыг шинэчилж, сайжруулах шаардлагатай байна гэсэн ийм чиглэлүүдийг өгч байгаа.

Дээрээс нь энэ айл өрхийн тархмал эх үүсвэрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг, олон улсад бол санхүүгийн дэмжлэг үзүүлээд явдаг. Тухайлбал та бүхэн мэдэж байгаа Австрали улс яг энэ нарны панель, айл өрхийн нарны панелиар дэлхийд тэргүүлдэг. Тэгэхээр Австрали улсын хувьд яадаг вэ гэхээр 30 хувь дээр нь санхүүгийн дэмжлэг олгодог. Өөрөөр хэлбэл агаарын бохирдол үүсгэж байгаа татвар, дээрээс нь тэр эрчим хүчээ хэмнэх шаардлагатай үүрэг хүлээсэн хүмүүс этгээдүүдийн татвар, дээрээс нь нэг хувийн татвар, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулж байгаа татвар гэх мэтчилэнгээр маш олон төрлийн санхүүжилтийг яг энэ агаарын бохирдол үүсгээд байгаа айл өрхүүдийг яндангаас салгах, дээрээс нь энэ тархмал эх үүсвэр, ногоон эх үүсвэрийг дэмжихэд ингэж дэмжлэг үзүүлдэг байгаа. Тэгэхээр энэ чиглэл рүү санхүүгийн схем, механизмыг боловсруулах шаардлагатай гэдэг ийм чиглэлийг өгч байгаа. Айл өрхийн тархмал эх үүсвэрийн хувьд.

2 дугаарт нь болохоор аймаг, сумдын тархмал эх үүсвэр. Тэгэхээр та бүхэн мэдэж байгаа. Дөнгөж саяхан Эрдэнэт дэд станц дээр тасралт гарахад 8 аймаг, 143 сум цахилгаангүй болсон. Өөрөөр хэлбэл төвлөрсөн эрчим хүчний системээс алс зайд байрласан аймаг, сумдын хувьд цахилгаан хангамжийн найдвартай байдал маш хүнд байгаа. Жишээ нь энэ Эрдэнэтэд болсон гэмтэл жишээ нь хэрвээ өвөл тохиолдсон бол маш олон аймаг, сумдууд хөлдөх хэмжээний тийм эрсдэлд аваачиж байгаа. Дээрээс нь энэ аймаг, сумдын хувьд хүчдэлийн уналт асар өндөр байгаа. Гишүүд ингээд орон нутгаар явахад хамгийн их гомдол ерөөсөө эрчим хүчтэй холбоотой. Ерөөсөө л нэг нөгөө 220 вольт гэдэг хүчдэл маань бараг 160, 70 вольттой байна. Гэрэл нь нэг ёлтойсон байдалтай байна. Энэ бол нөгөө урт шугамаар цахилгаанаар хангагдаж байгаа асуудал.

Тэгэхээр энийг сайжруулах нэг шийдэл бол ерөөсөө аймаг, энэ сумын төвүүд дээр дунд оврын чадалтай тархмал эх үүсвэр, нарны панель батарей, тэгээд тэр сүүлийн үед нарны панель батарей маань өөрөө бие даагаад ажиллах боломжтой

болчихсон. Өөрөөр хэлбэл зун ингээд аймаг, сумаар явахаар шугамд засвар орж байгаа гээд хэдэн долоо хоногоор ингээд цахилгаангүй сууж байдаг юм байна лээ. Гэтэл энэ нарны панель батарей буюу тархмал эх үүсвэр өөрөө бие даагаад ажилладаг учраас шугаман дээр засвар орох, шугаман дээр тасралт гарахад яах нь вэ түр хугацаанд тэр аймгуудыг нөгөө цахилгаанаар хангаад ингээд байж байх бүрэн боломжтой. Тийм учраас энэ аймаг, сумдын тархмал эх үүсвэрийг хөгжүүлж, аймаг, сумдын цахилгаан хангамжийг найдваржуулах, тэр чадал энергийн алдагдлыг багасгах зайлшгүй шаардлагатай байна гэсэн ийм 2 дугаар чиглэл.

3 дугаар чиглэл та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр бид түлш шатахууны хомсдолтой байна. Энэ дээр үнэхээр яалт ч байхгүй л бид хараат байдалд байгаа. Цаашдаа цахилгаан машин, ер нь цахилгаан машиныг бид өргөн хэрэглэж байна. Гэхдээ цахилгаан машины хэрэглээг нэг хязгаарлаад байгаа зүйл маань яалт ч үгүй нөгөө цахилгаан машиныг цэвэр цэнэглэх байгууламж маань ер нь бидэнд нэлээн ховор байгаа. Тэгэхдээ цаашдаа бид энэ тархмал сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр дээр үндэслээд энэ цэнэглэх байгууламжуудыг, цахилгаан машины цэнэглэх байгууламжуудыг, ялангуяа энэ логистикийн төвүүд, тэгээд энэ орон нутгийг холбосон шугамуудын дагуу байдлаар ингээд байгуулах гэсэн ийм чиглэл ингээд өгч байгаа.

Ерөнхийдөө ийм 3 чиглэлээр ногоон эрчим хүчийг хөгжүүлэх, тархмал эх үүсвэрийг хөгжүүлж байж энэ эрчим хүчний хараат байдлыг бууруулах шаардлагатай байна гэсэн ийм чиглэлийг өгч байгаа. Тэгэхээр ингээд та бүхэн маань энэ тогтоолыг дэмжээд, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, ялангуяа хэрэглэгчийн аюулгүй, найдвартай цахилгаан хангамжаар хангуулах, дээрээс нь агаарын бохирдлыг бууруулах энэ үйл ажиллагааг эрчимжүүлэхэд Засгийн газарт өгч байгаа үүрэг даалгавар буюу энэ тогтоолыг батлаад, цаашдаа хэдүүлээ хамтдаа хэрэгжилтэд хяналт тавиад ингээд явъя гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Гишүүд, тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье? Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцаар тасалж байна. Улсын Их Хурлын гишүүн Очирбат.

Г.Очирбат: Энэ тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Яг энэ цаг үеэ олж ирсэн тогтоолын төсөл орж ирж байна гэж харж байгаа. Өнөөдөр манай эрчим хүчний салбар бол хамгийн хүнд сурталтай салбар болсон. Асар их хэмжээний зөвшөөрөл нэхдэг, асар их хэмжээний хүнд суртал гаргадаг нэг ийм болчихоод байгаа юм. Тэгээд яг энэ Их Хурлын энэ тогтоолын төсөл юуг яг энэ загвар дээр нэг жоохон өөрчлөлт оруулах боломж байгаа юу, байхгүй юу?

Миний асуух гэж байгаа асуулт бол Эрчим хүчний тухай хуулиараа өрх, ААН-үүд, өрх бол 20квт хүртэл гэж байгаа шүү дээ, ААН-ийн 1,5 мегабайт байгаа байх. Тэрийг хийхэд нь ямар нэгэн хүнд сурталгүйгээр нэг зургаар, нэг хэв маягаар явах ийм боломжийг нь нээж өгөх боломж байх байгаа юу, байхгүй юу? Энэ нөгөө тогтоолын төслийн 4.3 дээр байна уу 5квт хүртэл гэхихсэн байгаа. 4.4 дээр 10квт хүртэл гэхихсэн байгаа. Энийгээ 20квт болгоод нэмэгдүүлэх боломж байгаа юу? Энэ талаар асуулт асуучихъя.

Тэгээд ер нь ингээд яг энэ эрчим хүчтэй холбоотой өрхүүд өөрөө өөрийнхөө эрчим хүчийг үйлдвэрлэх гэхээр асар их хүнд суртлууд байгаа. Би зүгээр Энхцэцэг гишүүнийг байгаа дээр та мэргэжлийн хүн мэдэж байгаа байх. Тэгээд бусад гишүүддээ хэлэхэд энэ харьяа газрын техникийн нөхцөл заавал авдаг. Тэгээд араас

нь техникийн нөхцөлийн дагуу зургийг зургийн компаниар зуруулдаг, тэр нь сая 500-аас 2 сая, 20 сая төгрөгийн өртөгтэй. Тэгээд зурсан зургаа, зуруулсан зурган дээрээ тусгай зөвшөөрөл авна тийм биз, тусгай зөвшөөрөл авсныхаа дараа газардуулгын хэмжилтээ ААН-үүдээр хийлгэнэ, ингээд ингэснийхээ дараа ажлын зургаа мөн тусгай зөвшөөрөлтэй компаниар хийлгэнэ. Энэ дээр дараа нь Эрчим хүчний үндэсний төвөөр нарны үүсгүүрт холбуулах болон техникийн дүгнэлт хийлгэнэ тэгнэ биз. Тэгээд тоолуураа харьяа түгээхтэй зөвшилцөнө. Энэний дараа харьяа цахилгаан дамжуулах компаниуд бүх бичиг баримтаа цахимаар болон бичгээр өгч дахин зөвшөөрөл авдаг. Үгүй ээ тэгээд ийм олон зөвшөөрөлтэй. Тэгэхээр ер нь манай энэ эрчим хүчний салбар үнэхээр ийм хүнд суртал буглачихсан, бугшчихсан газар болчихсон байгаа. Тэгэхээр бид ямар ч байсан Их Хурлын тогтоол гаргаж, ийм чиг үүргийн энэ тогтоолоо аягүй чиг үүргээ тодорхой болгож өгөөд, тэгээд энэ тогтоолынхоо араас шаардаад ажиллах нь зөв зүйтэй юм болов уу гэж харж байгаа юм 1-д.

2-т гэвэл Энхцэцэг гишүүн бас Эрчим хүчний тухай хууль байгаа. Хууль дээр авах юм байгаа, авахгүй юмнууд байгаа. Бид өөрчлөлт оруулах юмнууд байгаа. Та бас нэлээн ажиллаж байгаа гэж харж байна. Би энэ намраас яг Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль дээр тодорхой зүйл, заалтууд дээр нийгэмд болон ААН-үүд, мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлэг хийгээд, тэгээд нэг тантай хамтраад ч юм уу энэ хуулийн төсөл оруулж санаачлах ийм санаачилгатай явж байгаа шүү. Тэгээд та энэ дээр яг тэр 4.3, 4 хоёр дээр тэр 5 квт-ыг 20 квт руу, 4 дээр байгаа 10 квт-ыг 20 квт руу болгох, тэгж өөрчлөх боломж байгаа юу?

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн хариулъя.

М.Энхцэцэг: Очирбат гишүүндээ баярлалаа. Очирбат гишүүн яг энэ сэргээгдэх эрчим хүчний тархалт эх үүсвэр дээр ажлын хэсэгт ороод нэлээн энэ чиглэл рүү ажиллаж байгаад маш их баярлаж байгаа. Тэгэхээр яг хэлж байгаа Очирбат гишүүний шүүмжлэл бол яг зөв. Тэгэхээр тэр шүүмжлэлүүдийг байхгүй болгохын төлөө л энэ тогтоол 1 дүгээрт гарч байгаа.

2 дугаарт тэр нөгөө нэг бид ялангуяа айл өрхийн халаагууртай холбоотойгоор 5 квт-аас хүртэл ингээд онцгойлон энэ юу руу оруулж өгсөн техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг төрлийн зураг, нэг стандартаар түгээх сүлжээнд холбооч гэсэн ийм юмыг хүчээр энэ тогтоолд оруулж өгсөн гэсэн үг. Тэгээд 5квт-аас дээш чадлын хувьд яагаад чухам энд оруулж өгөөгүй юм бэ гэхээр тухайн чадлын хувьд яг түгээх сүлжээ маань нөгөө шингээх чадвараа тооцож үзэх ёстой. Өөрөөр хэлбэл үндсэн шугам нь даах юм уу, даахгүй юм уу, хайлаад уначих юм уу, уначихгүй юм уу гэдгийг тооцож үзэх ёстой учраас тэд нар нь яах вэ ингээд арай жоохон том чадалтай учраас техникийн нөхцөлтэйгөө яваасай гэдгээр оруулж өгсөн байгаа.

2 дугаарт тэр 4.4 дээр болохоор та бүхэн мэдэж байгаа, ингээд жишээ нь зөвхөн өөрийнхөө хэрэглээг хангах зориулалтаар өөрийнхөө сүлжээнд ингээд нарны эх үүсвэр барьчхаад, тэгсэн мөртөө нөгөө одоогийнхоо хуулиараа, одоогийнхоо журмаараа маш их хэмжээний техникийн бичиг баримтууд шаардаад сүлжээнд холбодоггүй. Тэгэхээр энийг ямар хэрэгтэй юм бэ, сүлжээ рүү тэртээ тэргүй нийлүүлэхгүй, зөвхөн өөрийнхөө хэрэглээг хангая гэж байгаа тохиолдолд энийг шууд сүлжээ рүү холбооч гэсэн ийм 2 хүчтэй заалтыг бол оруулж өгсөн байгаа.

3 дугаарт нь болохоор тэр 4.2 дээр болохоор та бүхэн мэдэж байгаа нөгөө журам гээд байж байгаа. Тэгэхээр энэ та бүхний, бид бүхний нөгөө шүүмжлэлийг

Эрчим хүчний яам маань хүлээж авч байгаа учраас журам дээр өөрчлөлт оруулах ийм ажлын хэсэг байгуулчихсан ажиллаж байгаа. Тэгээд яг таны хэлдэг үнэн, юу гэхээр манай журмаар энэ тархмал эх үүсвэрийг холбоход бүхэл бүтэн 6 оролцогч талтай. Сая Очирбат гишүүн яг дурдаж байна Эрчим хүчний яам, зохицуулах хороо, хөгжлийн төв гээд. Тэгээд энэ нэг жижигхэн алгын чинээ нарны панелиа сүлжээнд холбоход манайд бараг 6 сар болж байгаа байхгүй юу. Гэтэл бусад улс оронд болохоор жишээ нь Австрали, Японд яадаг вэ гэхээр ерөөсөө 1,5-аас 2-хон сар болдог, дээрээс нь ерөөсөө 3-хан оролцогч талтай. Тийм учраас бид ялангуяа энэ тархмал эх үүсвэрийн хувьд процессын дахин инженерчлэл хийж үзээд, Монголд хэдэн процесс, хэдэн үе шат дамжлагатай байгаад байгаа, бусад улс оронд энэ маань ямар цөөхөн шат дамжлагатай, илүү хялбар болоод байгаа гэдгийг гаргаж үзээд, энэ журмыг шинэчлэх дээр нэлээн оролцож ажиллаад, энийг сайжруулна гэсэн ийм зорилготой явж байгаа.

Р.Сэддорж: Очирбат гишүүн тодруулъя.

Г.Очирбат: Энэ Энхцэцэг гишүүнээ харин ингээд байгаа юм. Нийслэл дээр энэ бас хийгдсэн юм байна лээ. Тэгээд тэрэн дээр 3,5 квт дээр 5 квт-аар хийчихсэн, зөвхөн дулаан гээд явчихсан. Одоо дэлхий яаж өөрчлөгдөөд байгаа юм гэхээр дулааныхаа асуудлыг, өрхийн хэрэглээнийхээ цахилгааны асуудлыг хамтад нь шийдээд яваад байгаа байхгүй юу. Тэгээд тэр бол одоо манай яг өнөөдрийн нөхцөл байдлын тооцоо бол хууль дээр 20 хүртэл киловатт гэххээд байгаа юм. Тэгэхээр яг тэр хуулиа бариад 20 гээд оруулаад өгчихвөл бид дулаанаа шийдчихэж байгаа юм, өрхийн хэрэглээнийхээ эрчим хүчийг шийдчихэж байгаа юм, хоол хүнсээ бас эрчим хүчээр хийчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг 20квт болоод өгвөл их л хэрэгтэй байгаад байна. Та бас энэ дээр тооцоо судалгаа нэлээн хийсэн байгаа байх. Тэгэхгүй зөвхөн дулаан гээд цаашаагаа явчихвал дахиад нөгөө ахуйн хэрэглээнийхээ эрчим хүчийг яах вэ гээд л дахиад дутагддаг асуудал болдог, тэгээд дахиад л маргаан болдог. Тэрнээс нь хойшоо дахиад л 20 квт дээр баахан зөвшөөрөл ингээд болоод, хүнд суртлууд чинь нэмэгдээд явчихна шүү. Тэгэхгүй бол.../минут дуусав/

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн.

М.Энхцэцэг: Яах вэ эрчим хүчний систем чинь онцлогтой л доо. Юу гэхээр та бүхэн мэдэж байгаа нөгөө ийм нэг нарийхан утаснаас нэг ийм хэдэн зуун айлууд л тэжээгдэж байгаа шүү дээ. Гэтэл ингээд бүгд 20, 20 гэхихвэл тэр нөгөө үндсэн шугамаа солих шаардлага үүсдэг. Тэр утгаараа бид яг нөгөө 20 гэдэг дээрээ тооцоогоо хийгээд, техник нөхцөлөө олгоод ингээд яваг. Зүгээр 5 дээр бол юун дээр техникийн нөхцөл олгохгүйгээр жижиг чадалтай учраас айл болгонд ингээд жигд байдлаар ялангуяа энэ нөгөө нэг ийм халаалтыг шийдэх гэдгээрээ 5 гэдгээр оруулж өгсөн.

Тэр 4 дээр болохоор киловатт гэхихсэн байна. Энэ болохоор киловольт гээд түгээх сүлжээ хүчдэлийн асуудал байгаа шүү. Тийм. Тэгэхээр яах вэ 5 квт-ыг 20 луу оруулаад, техник нөхцөлгүй гэхээр арай л жоохон юутай болчих байх, техникийн талаасаа бол нэлээн асуудалтай болчихно гэдгээрээ л бид 5 гэж хязгаарласан байгаа. Тийм. Одоо болохоор яах вэ нөгөө нэг тухайн ... дээр байгаа энэ нэг нарийхан шугам дээр байгаа олон айлуудаас ганц, хоёр айл л.../минут дуусав/

Р.Сэддорж: Очирбат гишүүн дахиад сүүлийн 1 минут.

Г.Очирбат: Энэ дээр бид ингээд бодлогын шийдвэр гаргаж байгаа юм. Их Хурал Их Хурлын тогтоолоороо чиглэл өгөх гэж байна шүү дээ. Тэгэхээр бодлогын шийдвэр гаргах гэж байгаа юм. Тэгэхээр ер нь процесс дээрээ очоод манай түгээхийнхэн таны хэлж байгаа тэр шугамын ачааллыг тооцоогоо хийгээд, өргөтгөөд өргөтгөх ёстой 1-д.

2-т гэвэл хэрвээ 20 квт хүртэл болгоод өгвөл бид нөгөө иргэдийн орлого олох боломжийг нэмэгдүүлээд байгаа шүү дээ бас тийм биз? Тэгэхээр чинь өргөх станцуудаа ч гэсэн барих ёстой түгээх. Энэ бол тэдний процессын ажил, заавал хийх ёстой. Бид энд бодлогоор яг өнөөдөр эрчим хүчний 24 хувийн дутагдалтай байгаа энэ үе дээр иргэн бүр маань өөрсдөө 20 квт-аа үйлдвэрлээд, өөрийнхөө хэрэглээнд 10-аас 12-оо хэрэглээд, үлдсэн 8 квт-аа төвийн сүлжээнд өгөөд, тэгээд энэ дээр чинь 365 хоног дээр симуляц хийгээд үзэхээр нэг сардаа 2-оос 3 сая төгрөгийн орлого олох бололцоо байгаад байгаа байхгүй юу. Тэгээд та энэ тогтоолын төсөл дээрээ бичсэн байна шүү дээ. Тэр орлогыг хүртэл цаг хугацаанд нь шилжүүлж байх ёстой гээд. Тэгэхээр өнөөдөр бид Их Хурлын гишүүний хувьд иргэдээ яаж орлоготой болгох вэ, ялангуяа энэ техник технологи шинэ инновацыг ашиглаж яаж орлоготой болгох вэ.../минут дуусав/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Их Хурлын даргын санаачилгаар ийм тогтоол боловсруулаад миний бие оролцоод саналаа тусгаад явсан. Тэгээд Энхцэцэг гишүүн, Очирбат гишүүний хэлж байгаа саналуудыг маш зөв гэж бодож байна. Энүүгээр ямар боломж нээгдэх гээд байгаа юм бэ гэдгийг ялангуяа хувийн хэвшил болон өрхүүд маань ойлгоосой гэж бодож байна. Байшин гэрээ дулаалах, эсвэл эрчим хүчний хэмнэлттэй сууц бариулах, тэгээд тэнчээнээ сэргээгдэх эрчим хүчийг ашиглаад, нарны хавтан ашиглаад явбал илүүдэл цахилгаанаа төвийн сүлжээнд зарах боломж нь бүрдэнэ. Төвийн сүлжээнээс хамааралгүйгээр бие дааж сэргээгдэх эрчим хүч ашиглаад явна гэвэл тусгай зөвшөөрөл, энэ олон үе шатлалтай дарга нараас гарын үсэг цуглуулдаг техникийн нөхцөл энэ тэр гэсэн тийм бүх асуудлууд алга болно гэсэн үг.

Ялангуяа орон нутгийн Засаг дарга нар маань энэ дээр анхаараасай гэж бодож байна. Тог тасарчихлаа гээд сүлжээнд холбож өг гээд, цахилгаан станц барь гэдэг асуудал улсын төсөв дээр тавих ёсгүй шүү. Орон нутаг маань бие даагаад эрчим хүчээ шийдэх боломж бололцоо нь энэ тогтоолоор нээгдэж байгаа юм. Өнөөдөр энд хэдүүлээ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд нэгдсэн чуулганаар дэмжигдээд явбал ирэх хаврын чуулганаар энэ тогтоолын төслийн гүйцэтгэлийг бид Засгийн газраас сайд нараас асууна. Энэ журмууд бүгд байхгүй болсон уу, яагаад хүн өөрөө эрчим хүч үйлдвэрлээд, тэнчээнээ сайхан тог нь тасрахгүй, дулаахан өвөлжье гэж байхад төр засаг нь гарч ирчхээд зөвшөөрөл өгнө гээд гарын үсэг зураад суугаад байдаг тэрнийг бүгдийг нь болиулна гэсэн тогтолцоо байгаа. Тэгэхлээр маш богино хугацаанд Засгийн газар маш их ажлыг хийх буюу иргэдэд ээлтэй, хувийн хэвшилдээ ээлтэй ийм журам тогтолцоогоо дахин загварчлах гэсэн ийм тогтоолыг оруулж байгаа.

Тэгээд миний хувьд сүүлийн 5 сарын хугацаанд Улаанбаатар аянаараа төвийн 6 дүүрэг болон Налайх дүүргээр яваад, байшин гэрээ зөв дулаалах мэдээллийг мэргэжлийн байгууллагуудтай, олон улсын холбоотой хамтраад мэдээлэл түгээгээд явлаа. Иргэдээс тавьж байгаа шаардлага бол бас тийм байна. Цахилгаан халаагуурт шилжээд утаагаа шийдье гээд ороод ирсэн чинь цахилгаан

нь тасалдаад байдаг, хүчдэл нь хүрдэггүй. Тэгээд эсрэгээрээ сэргээгдэх эрчим хүч тавья гэхлээр журам нь хэцүү байдаг, баахан процессын олон давхар дамжлага дамждаг, хүнд сурталтай байна гэсэн асуудлуудыг хөндөж байсан. Тэгэхлээр энэ хэлэлцүүлгийг, тогтоолын төслийг энэ хэлэлцүүлгээрээ бүгдээрээ дэмжээд явъя гэсэн уриалгыг хэлмээр байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Дамдинням гишүүн үг хэлнэ. Анар гишүүнийг нэмье. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Энэ их чухал тогтоол. Улсын Их Хурлын дарга Эдийн засгийн яамны сайд, Тэргүүн шадар сайд байхад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтарч боловсруулаад явж байсан тогтоол юм байгаа юм. Өнөөдөр энэ тогтоолын ямар чухлыг бид бүгдээрээ харцгааж байгаа. Өөрөөр хэлбэл энэ түлш шатахууны хамааралт байдал бид 100 хувь импортын түлш шатахуунаас хамааралтай ийм улс байгаа. Хөрш Оросын холбооны улсаас бид нийт хэрэглээнийхээ 95 хувийг авдаг. ОХУ-ын маань дотоодын нөхцөл байдал туйлын хүнд байгаа учраас 12 дугаар сард бидэнд нийлүүлэх ёстой шатахууныхаа дөнгөж 50 хувийг нийлүүлж байна авто бензиний. Энэнээс болж энэ их очерлолт, энэ их тасалдал үүсэж байгаа.

Эдийн засаг маань өсөөд томроод байдаг, уул уурхайн үйлдвэрлэл маань томроод байдаг. Гэтэл өнгөрсөн хугацаанд манай улс сав, нефтийн бүтээгдэхүүний агуулах савынхаа хүчин чадлыг огт нэмээгүй. Сар хүрэхгүй хугацааны нөөцөө хадгалж чаддаг. Энэ сар хүрэхгүй хугацааны нөөц нь тухайн сардаа дуусаад, дараачийнхыгаа татаж авах хооронд л хоосорчихдог. Ингээд хомсдолд ордог. Өөрөөр хэлбэл 10 сард нөхцөл байдал нэг өөр, энэ жилийн тухайд 10 сард 92 бензин тасалдаж, дизель түлш хэвийн, 11 сард 92 бензин хэвийн, дизель түлш асуудалтай, 12 сард дизель түлш хэвийн, 92 бензин асуудалтай. Яагаад вэ гэвэл бидний хадгалах чадвар ийм сул байхгүй юу. Өөрөөр хэлбэл бид түлш шатахууны хамааралт байдалд гүн гүнзгий байгаа. Газрын тосны бүтээгдэхүүн хэрэглэж эхэлсэн цагаасаа л хойш бид ийм хамааралтай байгаа. Хамаарлаасаа гарах бодлогын алхам хийж байгаагүй. Цор ганц хийсэн бодлогын алхам бол Хүрэлсүх Ерөнхий сайд байхад, одоогийн Ерөнхийлөгч Ерөнхий сайд байхдаа гаргасан газрын тос боловсруулах үйлдвэр. Энэ бол стратегийн маш том бүтээн байгуулалт, манай энэ хамааралгүй байдлын нэг том шийдвэр болно.

2 дахь нь энэ ногоон эрчим хүч, тархмал эх үүсвэр. Монгол орны 70 гаруй байрлалд нар, салхи батарейн хосолсон машин цэнэглэдэг ийм төвүүдийг байгуулах тухай ийм тогтоол юм. Айл өрхүүд илүү гарсан нар, салхины цахилгаанаар цуглуулсан энэ эрчим хүчээ нийтийн сүлжээнд зарах тухай тогтоол юм. Өөрөөр хэлбэл түлш, шатахууны хамаарлаас гарах ойрын ирээдүйд хэрэгжиж болохуйц том хэмжээний төрийн бодлого явах гэж байгаа ийм тогтоол юм. Тийм болохоор энэ тогтоолыг цаад гүн гүнзгий утгыг нь ойлгож, Их Хурлын гишүүд маань дэмжиж өгөөрэй гэж та бүгдээс хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Анар.

Ч.Анар: Энэ тогтоолын төсөл орж ирж байгаад их баяртай байна. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2024-өөс 2028 дээр сэргээгдэх эрчим хүч, тархмал эх үүсвэрийг оруулахын тулд Лувсанжамц гишүүн бид хоёр нэлээн их юм болсон. Бид өөрснөө эрчим хүчний хараат байдалтай, тэрийгээ нүүрсээрээ шийдэх гээд яваад байдаг. Тэгээд сэргээгдэх эрчим хүчийг нөгөө Эрчим хүчний яам,

холбогдох мэргэжилтнүүд төвийн эрчим хүчинд доголдол үүсгэдэг, тэгээд өртөг өндөртэй гэдэг асуудлыг ярьж гацаасаар ирсэн юм байна лээ бодит байдал дээрээ.

Гэхдээ энэ чинь бол аль 10 жилийн өмнөх технологи шүү дээ. Орчин үед сэргээгдэх эрчим хүч өртөг нь хямдарчихсан, тэр төвийн эрчим хүчийг доголдуулдаг асуудал байхгүй болчихсон. Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн доголдол, дээрээс нь дамжуулах сүлжээний алдагдлыг нэгхэн жилийн дотор шийдэх бололцоо байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь бол ерөөсөө л энэ тархмал эх үүсвэр. Тэгээд энийг ер нь шууд хэлэхэд санаатайгаар холбогдох яамд, хамаарал бүхий этгээдүүд гацаадаг юм байна лээ шүү. Ашиг сонирхол бүхий тэр Эрчим хүчний зохицуулах хорооны журам дээр 2 журам дээр байгаа. Тэр журмыг энэ тогтоол дээр өөрчлөхийг оруулж ирсэн байна. Их сайшаалтай.

Өөрөөр хэлбэл албаар хүнд суртал үүсгэж, шинэ технологийг нэвтрүүлэхэд өртгийг нь өндөр болгож, өөрсдийн хамаарал бүхий байдалд ашиг сонирхлыг шингээж боосон байдалтайгаар Монгол Улсын эрчим хүчний салбарыг боогдуулж байж энэ олон төслүүд явуулдаг. Тэгээд энэ Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, эрчим хүчний бие даасан байдлаас илүү эрх ашиг байдаг ямар бодлого тэр хүмүүст байдаг юм бэ үнэхээр. Тэгэхээр энэ Их Хурлаас гаргаж байгаа энэ тогтоолын хэрэгжилт дээр нь Их Хурал цаашлаад, энэ Байнгын хороо цаашлаад яг хяналт тавиад, маш богино хугацаанд бол үнэхээр бодитойгоор эрчим хүчний хямралаасаа гарах бололцоо бий шүү. Тэгэхээр энэ тогтоолын төслийг дэмжиж байна.

Тэгээд гол нь дахиад хэлье Их Хурлаас гарч байгаа тогтоолуудын хэрэгжилт 22-оос 27 хувь. Тэгэхээрээ бид Их Хурал өөрөө тогтоол гаргаж, хууль боловсруулаад орхих биш араас нь заавал ч үгүй хяналт тавьж цаашаа явах ёстой. Тэрийгээ ажлын хэсэг болгоод, Байнгын хороод хойноос нь тогтоолынхоо хэрэгжилтэд анхаарч ажиллахыг хүсье. Баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын даргаас нэлээн цаг үеэ олсон ийм тогтоолыг санаачилж оруулж ирж байгаа гэж үзэж байгаа. Тэгээд манай Монгол Улс нарлаг Монгол орон гэж ярьдаг. Тэгсэн хэр нь тэр нарны эрчим хүч эд нараа сайн ашигладаггүй. Ашиглая, ингээд хосолсон системээр ашиглая гэхээр эрчим хүчний зөвшөөрлүүд нь учир нь олддоггүй. Тэгэхээр энэ тогтоолыг сайн хэрэгжээсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Анар гишүүн сая эрсдэлүүдийг нь хэллээ. Энэ тогтоолыг хэрэгжүүлж, энэ утаа, энэ нөгөө гадаадаас авдаг тог эд нарт маань маш их тус дэмтэй ийм тогтоол гарч байгаад баяртай байгаа. Тэгээд Улсын Их Хурлаар батлагдана гэдэгт итгэж байна.

Цахилгаан машины татварыг, цахилгаан машины зээлийг энэ дээр яаж банк, санхүүгийн байгууллагууд яаж дэмжих ёстой юм бэ гэдгийг, гэдэг дээр нэг саналтай байгаа. Жинхэнэ цахилгаан машины зээлийг л их дэмжиж, дэмжих ёстой гэж үзэж байгаа. Ялангуяа Улаанбаатар хотын хувьд, аймгуудын төвийн хувьд бол. Тэгээд дахин, энд бол нөгөө газын юу бол орохгүй байгаа юм байна лээ. Тэгээд газар ажилладаг машинуудын татварыг нэмсэн ийм асуудал гарсан юм билээ. Татварыг нэмсэн үү, ямар ч байсан миний авсан мэдээллээр энэ газар ажилладаг машинууд орж ирэх нь багассан гэж ярьж байгаа юм билээ. Тэгээд энэ дээр энэ тогтоол дээр бол газ орохгүй юм билээ. Тэгээд энэ ямар учиртай юм бол? Тэн дээр Энхцэцэг гишүүн мэдэж байгаа бол хэлээрэй гэдгийг хэлье.

Манай улсын хувьд хөдөөгийн малчид нарны энергийг хамгийн сайн хэрэглэдэг ийм орон бол манай Монгол Улс. Тэгээд маш олон тоотой, хүн амд нь харьцуулахад маш олноор хэрэглэдэг ийм орон байгаа. Тэгээд ер нь малчид энэ газар хоол ундаа хийгээд, нарны энергиэр утас юмнуудаа цэнэглээд, гэрэлтүүлгээ хийгээд ингээд явж байгаа. Энэ тогтоол гарснаараа энэ аймаг болон нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүд бол хосолсон ийм ашигтай системээр, нарны панелиар дулаанаа шийдээд явах ийм боломжууд, үүд хаалганууд ингээд нээгдэх юм байна. Одоо бол энэ 10 сая төгрөгийн үнэтэй байгаа юм байна гэж ойлгосон. Тэгээд энийг цаашдаа татаасаар төрөөс дэмжих энэ зүйлүүдийг энэ тогтоолоор хийгээсэй гэсэн саналуудыг хэлье. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Засгийн газарт чиглэл өгөх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны дугаар тогтоолд тусгасан ногоон эдийн засгийг дэмжих, ногоон төслүүдийг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх замаар эрчим хүчний импортын хараат байдлыг бууруулж, үндэсний эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний алдагдлыг бууруулах, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, ногоон технологид суурилсан тогтвортой аялал жуулчлал болон байгаль орчинд ээлтэй зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, олон улсын стандартад нийцсэн ногоон барилга болон хот байгуулалтын технологи шийдлийг нэвтрүүлэхэд чиглэсэн ногоон төслийн санал санаачилгыг дэмжих.

2.Өрхийн болон орон нутгийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, айл өрхүүдэд нарны панель, батарей, халаагуур хосолсон системийг үе шаттай суурилуулах. Хэт урт шугамаар тэжээгддэг аймаг, сум, суурин газрын сэргээгдэх эрчим хүчний бие даасан эх үүсвэр, эрчим хүч хуримтлуур бүхий системээр хангах замаар төвлөрсөн шугам сүлжээний ачаалал, алдагдлыг бууруулах, хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг сайжруулах.

3.Цахилгаан тээврийн хэрэгслийн нийтийн болон хурдан цэнэглэх дэд бүтцийг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурласан сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр бүхий олон улсын шаардлагад туршлагад нийцсэн цахилгаан тээврийн хэрэгслийн цэнэглэх дэд бүтцийн багц төслийг нэвтрүүлэх.

Хоёр.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан удирдамжийн хүрээнд гадаад улстай байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар карбон кредитийг хөгжүүлж, энэ тогтоолын нэг дэх заалтад заасан арга хэмжээтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд үр өгөөжтэй байдлаар ашиглах.

Монгол Улсад орох хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэхийг чиглэл болгон ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

Гурав.Цахилгаан эрчим хүчний импортыг бууруулах, алслагдсан хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилтийн хөрөнгө оруулалтын боломжийг өргөтгөх, тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчин бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосугай.

Дөрөв.Энэ тогтоолын 1 дэх заалтыг богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1.Ногоон төслийн бэлэн байдлыг хангуулах хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах арга хэмжээг зохион байгуулах.

2.Тархмал эх үүсвэрийг түгээх сүлжээнд холбох, илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан дүрэм журмыг иргэн, хувийн хэвшилд ойлгомжтой, хэрэглэгчдэд ээлтэй, шийдвэр гаргалт, үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох талаар боловсронгуй болгож өөрчлөх.

3.5 квт хүртэлх хүчин чадалтай нарны панель батарейн системийг техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг стандартыг хангуулан түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон орлогыг тухай бүр авах боломжийг бүрдүүлэх.

4.Зөвхөн өөрийн хэрэглээг хангаж, эрчим хүчээ хэмнэх зорилготой түгээх сүлжээнд цахилгаан нийлүүлэхгүй тархмал эх үүсвэрийг техникийн нөхцөл шаардахгүйгээр 10 квт хүртэлх хүчдэлийн түгээх сүлжээнд холбох боломжийг бүрдүүлэх.

5.Айл өрхүүдэд нарны панель батарей, халаагуур хосолсон системийг үе шаттайгаар нэвтрүүлж, халаалтын асуудлыг шийдвэрлэх, агаарын бохирдлыг бууруулах, цэвэр, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх.

6.Төвлөрсөн эрчим хүчний системээс алслагдсан, хэт урт шугамаар цахилгаанаар хангагддаг, эрчим хүчний алдагдал өндөртэй бүс нутгуудад тархмал эх үүсвэр, зай хураагуурын нэгдсэн шийдлийг үе шаттайгаар нэвтрүүлэх.

7.Тархмал эх үүсвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд төслийн нэгж хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, урт хугацааны хөнгөлөлттэй санхүүжилт татах, нийлүүлэлтийн сүлжээг оновчтой зохион байгуулах арга хэмжээ авах.

8.Тархмал эх үүсвэр бүхий халаалтын системийг нутагшуулах зорилгоор олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, зураг төсөл, угсралт суурилуулалт, туршилт тохируулга, засвар үйлчилгээ, ашиглалтын инженер, техникийн ажиллагсад, гүйцэтгэгчдийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр мэргэжлийн холбоо, сургалтын байгууллагатай хамтран чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хүний нөөцийг орон нутгаас бэлтгэж, төслийн бүтээн байгуулалт, ашиглалт, засвар үйлчилгээ, тохируулгын ажилд орон нутгийн ажиллах хүчний оролцоог дэмжих.

9.Тархмал эх үүсвэрээс эрчим хүч худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг түншлэгч төсөл хэрэгжүүлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тусгай нөхцөлөөр байгуулж, сонгогдсон байршлуудад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох, эсхүл улсын тусгай хэрэгцээнд авч төслийг саадгүй хэрэгжүүлэх боломжоор хангах.

10.Олон улсын, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто зам, аялал жуулчлал, логистик худалдааны коридор дагуух стратегийн байршлуудад сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсгүүр бүхий цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх станц байгуулах, үйлдвэрлэсэн ногоон эрчим хүчийг дотоодын хэрэглээнд үр ашигтайгаар шингээх, нийтийн хурдан цэнэглэх дэд бүтцийг хэт болон хот хоорондын авто тээврийн бодлоготой уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

11.Бүрэн цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл болон туулах уртасгагчтай цахилгаан хөдөлгүүрт тээврийн хэрэгслийг байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслийн ангилалд оруулж, замын хөдөлгөөний дугаарын хязгаарлалтад хамруулахгүй байх зохицуулалтыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх.

12.Эрчим хүчний болон ногоон барилга байгууламжийг барих, цэнэглэх станцын барилга байгууламж тоног, төхөөрөмжийг болон агаарын бохирдол, эрчим хүчний алдагдлыг бууруулах зорилтын хүрээнд гэр, хувийн сууц, барилга байгууламжийн дулаан хязгаарлалтын төслүүдийг Ногоон төслийн ангилалд хамруулж, зөвшөөрөл олголтыг хялбаршуулах, холбогдох зөвшөөрлийг олгох болон төсөл хэрэгжүүлэгчид Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан Тогтворжуулах гэрчилгээ олгох. Ногоон төслүүдийн хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлүүдийг тодорхойлж, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

13.Хот байгуулалт, дахин төлөвлөлт, эрчим хүчний сүлжээний өргөтгөл, орон сууцын бодлого, агаарын бохирдлыг бууруулах бодлоготой уялдуулан дулаалгын төслүүдийг хэрэгжүүлэх. Төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид дулаалгын ажлыг үлгэрчилсэн байдлаар хэрэгжүүлж, зах зээлийн тогтвортой эрэлтийг бий болгох.

14.Дулаалгын төслийн үр дүнд бий болох эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хий ялгарлын бууралтад үндэслэн карбон кредит тооцох, бүртгэх, арилжаалах боломжийг бүрдүүлэх, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

15.Дулаалгын ногоон төслүүдийн хэрэгжилт, санхүүжилтийн үр ашиг, бодит үр нөлөөнд тогтмол мониторинг хийх, агаарын бохирдлыг хэмжих үндэсний сүлжээг бий болгож, үнэлгээ хийх, хэрэгжилтийн үр дүнд тулгуурлан бодлогын дэмжлэгийн механизмыг үе шаттайгаар сайжруулах.

16.Агаарын бохирдлын төлбөрөөс төсөвт төвлөрөх орлогыг агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын өрхүүдийг тархмал эх үүсвэрт холбох болон

дулаалгын төслийг хэрэгжүүлэх эх үүсвэрт төвлөрүүлж, олон улсаас ногоон санхүүжилт татах бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх.

Тав.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгасугай.

Зургаа.Энэ тогтоолын 4 дэх заалтад заасан арга хэмжээний явц, биелэлтийн талаар 2026 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Долоо.Эрчим хүчний бие даасан байдлыг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн уялдаа холбоог хангуулах, эрчимжүүлэх, хяналт тавьж нэгтгэн танилцуулах талаар эрхлэх асуудлын хүрээнд арга хэмжээ, үр дүн, арга хэмжээ авч, дүнг танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд тус тус даалгасугай.

Найм.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Улсын Их Хурлын дарга. Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд нэрээ өгье. Очирбат гишүүнээр тасалж байна. Улсын Их Хурлын гишүүн Очирбат.

Г.Очирбат: Энэ тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Тэгээд тогтоолын төслийн 4.3 дээр 5 квт хүртэлх хүчин чадалтай нарны панель батарейн системийг техникийн нөхцөл шаардахгүйгээр нэг стандартыг хангуулан түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон орлогыг тухай бүр авах боломжийг бүрдүүлэх гэгчхэж байгаа юм. Тэгээд энэ яах вэ 5 квт хүртэл гэдэг бол одоо Эрчим хүчний тухай хуулиараа өрх 07 газардаад 20 хүртэл киловаттын өөрийн гэсэн станц барих бололцоотой байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг 20 болгож өгөөч гэсэн санал байна.

Дараагийнх нь санал 4.4 дээр зөвхөн өөрийн хэрэглээг хангаж гэж, зөвхөн өөрийн гэж байгаа юм шүү. Зөвхөн өөрийн хэрэглээг хангаж, эрчим хүчээ хэмнэх зорилготой түгээх сүлжээнд цахилгаан нийлүүлэхгүй, тархмал эх үүсвэрийн техникийн нөхцөл шаардахгүйгээр 10 квт хүртэлх хүчдэлийг түгээх сүлжээнд холбох боломжийг бүрдүүлэх гэж байгаа юм. Энийг бас 20 болгож өгөөч гэсэн зарчмын зөрүүтэй санал байгаад байна. Энэ яаж байна гэхээр ерөнхийдөө бол одоо яг өвлийн улирал та бүхэн мэднэ Монгол Улс 4 улиралтай, зуны улирал гайгүй, хаврын улирал гайгүй байдаг, намрын улирлын сүүлээр өвлийн улиралд энэ 5 квт-аар эрчим хүч бол өөрөө өөрийгөө өрх хэрэглээгээ хангаж чадахгүй. Бидний гол концепц бол энэ дээр юу явж байна гэхээр өөрийнхөө хэрэглээг хангая, эрчим хүчнийхээ системд дарамт болохгүй байя, илүү үйлдвэрлэснээ төвд өгөөд орлого олъя гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 5 гэдэг яг ийм хязгаарлалтад оруулж байгаа ийм тоо орж ирээд байна. Тэгэхээр энийг яг хуулийн дагуу 20 хүртэл болгож өгөөч.

Нөгөөдөх нь төвд өгөхгүйгээр зөвхөн өөртөө 20 квт, би жишээ нь өвөл яг ингээд плиткээ ажиллуулаад, дулаанаа шийдээд, утсаа цэнэглээд, зурагтаа ажиллуулахад 13-аас 15 орчим киловаттыг хэрэглэдэг цагт оргил ачааллынхаа үед. Тэгэхээр 20 квт болгочихвол би өөрийнхөө хэрэглээг хангалттай өөрөө үйлдвэрлэж байна гэсэн үг. Төвд өгч орлого олохгүй гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ дээр 20, 10 гэгчихээр 10 чинь юу гэдэг юм хамгийн оргил ачааллын сар буюу 12, 1, 11 саруудад

хүрэхгүй, заавал төвөөс авах ёстой болчихно. Тэгэхээр Их Хурлын эрхэм гишүүд маань та бүхэн маань энэ дээр яг Эрчим хүчний тухай хууль дээр заасан зүйл, заалт 1-д, 2-т гэвэл бас иргэд маань өөрөө өөрсдийнхөө эрчим хүч олох бололцоог бий болгож өгөөч. Яг 5 квт-аар гэхивэл 5с квт өрхийн хэрэглээнд хүрэхгүй шүү, хэрэглээнд хүрэхгүй. Ялангуяа энэ өвлийн улиралд, хаврын улирал, намрын сүүл улирлуудаар хүрэхгүй. Тэгэхээр энийг 20 квт болгож өгөх зарчмын зөрүүтэй нэг санал.

Дараагийнх нь төвийн сүлжээнд нийлүүлэхгүй, зөвхөн өөртөө хэрэглэх гэж байна шүү дээ. Тэгэхэд дахиад энийг 10 квт-аар хязгаарлаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хуульд нийцүүлээд 20 квт болгож өгөөч гэсэн нэг ийм 4.3, 4 хоёр дээр зарчмын зөрүүтэй санал байна. Гишүүд маань дэмжиж өгөөч.

Р.Сэддорж: Шууд санал хураалтад л бэлдэх юм байна. Энхцэцэг гишүүн. Гишүүд санал хураалтад бэлдье.

Улсын Их Хурлын гишүүн Очирбатын гаргасан горимын санал. 4.3 дээр “5 киловатт хүртэлх хүчин чадалтай” гэснийг 20 киловатт тийм ээ, “20 киловатт хүртэлх хүчин чадалтай нарны панель” гэж өөрчлөх. Очирбат гишүүн өөрөө юундаа орох юм байна шүү санал хураалтдаа. Ингээд Очирбат гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор, 4,3 тийм, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Очирбат гишүүн үү, 2 дахь саналаа Очирбат гишүүн татах юм уу, хураалгах уу? Та микрофонд хэлэх юм байна. Очирбат гишүүн.

Г.Очирбат: 2 дахь гаргасан зарчмын зөрүүтэй санал маань энэ тогтоолын төсөл дээр үсгийн алдаа гарчихсан юм байна. Ватт, хүчдэлийг киловатт гээд Т үсэг хойно нь нэмчихсэн юм байна. Тэгэхээр би энэ саналаа татчихъя. Т үсгээ засаарай.

Р.Сэддорж: Саналаа татлаа. Тогтоолын төсөл дээр гишүүд саналаа хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье. Тогтоолын төслийг батлах санал хураалт.

Саналын томьёолол. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг баримтлан боловсруулсан Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Бэлэн үү? Санал хураалт. 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг танилцуулна. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

17.37 цаг

***Зургаа. “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Ингээд хэлэлцэх асуудал 6, сүүлийн асуудал. 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Оюу толгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Түр хорооноос боловсруулсан тогтоолын төслийг хэлэлцэх үед хуралдаан даргалагчаас тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах талаар өгсөн чиглэлийн дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хянан шалгах түр хорооноос боловсруулсан тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдал танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Оройн мэнд хүргэе Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүддээ. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 сарын 2-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулагдсан.

Хянан шалгах түр хороо 6 хянан шалгагч, 12 шинжээч ажиллуулж, 27 байгууллагуудаас баримт материал гаргуулан, 17 байгууллагад газар дээр хяналт шалгалт гүйцэтгэж, 92462 хуудас бүхий нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийн 13 удаагийн Түр хорооны хуралдаан, 3 удаагийн нотлох баримт шинжлэн судлах нээлттэй сонсгол хийсний үндсэн дээр Түр хорооны санал, дүгнэлтийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Түр хорооны санал, дүгнэлтийг боловсруулах явцад Засгийн газарт хэд хэдэн удаа чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх шаардлагатай гэж гишүүд үзсэн тул энэ Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд Оюу толгой бүлэг ордын ашиглалттай холбогдуулан дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтэд нийцүүлэн авч хэрэгжүүлж, үр дүнг Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулж шийдвэрлүүлэх Монгол Улсын Засгийн газарт даалгана. Энэ хугацаанд тогтоолоор өгсөн үүргийн явцыг улирал тутам Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд нээлттэй танилцуулж, ил тод байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

Тогтоолын төсөлд дараах арга хэмжээ авахыг даалгана. Үүнд 1 дүгээрт, стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил заагт орших Жавхлант Шивээтолгой ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягталж, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлүүдийг цуцлах хүртэл арга хэмжээ авах. Ашиглалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулах. Ирээдүйд Монголын талд хүртэх өгөөжид сөрөг нөлөөлөл, үр дагавар бүхий санхүүжилт, хөрөнгө оруулалтын аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

2 дугаарт, Эрдэнэс MGL хариуцлагатай хувьцаат компани, Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд, Оюу толгой Нидерланд /БиВи/, Оюу толгой хариуцлагатай

хувьцаат компанийн хооронд 2011 оны 6 сарын 8-ны өдөр байгуулсан хувь нийлүүлэгчдийн гэрээ нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосны хэрэгжилтийг харилцан дүгнэх, алдагдсан боломжийн өртгийг тооцоолж, дүгнэлт гаргах, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнд холбогдох бусад гэрээ, эрх зүйн баримт бичгийг нийцүүлэх, хувь нийлүүлэгчийн болон гуравдагч этгээдийн санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээг зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах.

3 дугаарт, стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой /ОТ/ бүлэг ордын геологи хайгуулын судалгааг үргэлжлүүлж, үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар тус ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх, ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

4 дүгээрт, Монголын талын үр өгөөжийн хувь хэмжээ 53-аас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах. Уг хувь хэмжээ 5 жил тутамд харилцан хянан үзэх зарчмыг нэвтрүүлж ОТ хариуцлагатай ХК-ийн жилийн тайланд талуудад ногдох үр өгөөжийн тооцоог тусгайлан тайлагнах. 4 дүгээрт, давхар орчихсон байна. 4 дүгээрт сая уншихлаа. Уншихсан тийм ээ?

Тэгээд хоёрдугаарт нь энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Сэддорж/-д даалгасугай гэсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулж байна, шийдвэрлэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Р.Сэддорж: Тогтоолын төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Асуулт байгаа, үг байхгүй. Лувсанжамц гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Уянга.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Энэ ОТ-той холбоотой сонсголын үр дүнд Монгол Улсын Их Хурлаас Засгийн газарт өгөх гэж байгаа энэ Улсын Их Хурлын тогтоолын 1 дүгээр зүйл дээр нэг тийм найруулгын заавал саналыг оруулах шаардлагатай байгаа. Тэгээд энийг яах вэ зарчмын зөрүүтэй саналаар Эдийн засгийн байнгын хороон дээр санал хураахгүй гэж ойлгосон. Тийм учраас маргааш яг Түр хорооны гишүүд хуралдах үеэрээ энийг заавал авч үзээд, тэгээд тусгаарай гэдэг дээр саналыг протоколд тэмдэглүүлэн үлдээе.

Энэ ОТ бүлэг орд бол стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гээд 2007 онд яг жагсаалтад орчихсон ийм орд байгаа. Энэ нь өөрөө юу гэсэн үг юм бэ гэхээрээ энэ тусгай, энэ ордтой холбоотой тусгай зөвшөөрөл хайгуулаа хийх үү, ашиглалт явуулах уу энэ бүгд нь Ашигт малтмалын тухай хуулийн 8.1.5-аар Улсын Их Хурлын бүрэн эрх байгаа. Тэгэхээр энэ 1 дүгээр зүйл дээр, 1 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт дээр хууль зүйн үндэслэл, хуульд нийцсэн байдлыг нягтлаад, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах нь Засгийн газрын хийх ажил биш. Энэ бол Ашигт малтмалын тухай хуулиараа стратегийн орд гэдэг утгаараа Улсын Их Хурлын эрх, үүрэг учраас найруулгад нэг ийм саналыг тэмдэглүүлэх шаардлагатай байна.

Жавхлант Шивээтолгой ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягтлах, ашиглалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж гээд ийм байдлаар явахгүй болохоор угаасаа Засгийн газрын эрх мэдлээс хэтэрсэн асуудлыг бид

Засгийн газар луу даалгах гээд байгаа учраас энэ дээр нь заавал Түр хорооны ажлын хэсгийнхэн анхаарал хандуулж, найруулга дээр нь өөрчлөлт оруулах шаардлагатай гэдгийг тэмдэглэхийг хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Уянга гишүүн саналаа хэллээ. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт дээр тусаад, маргааш манай Хянан шалгах түр хороо хуралдах байгаа. Тэгээд таны гаргасан саналыг Түр хороон дээрээ бид авч үзээд, шийдвэрлээд, эцсийн төслөө Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар оруулъя. Саналд баярлалаа.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Бямбацогт сайд яах уу? Бямбацогт сайдыг нэмье.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Манай Хянан шалгах түр хороо маш сайн ажилласан, ажил хэрэгч байсан. Өмнө нь ерөөсөө ил гарч байгаагүй мэдээллүүдийг бүгдээрэнг нь 3 хоногийн хугацаанд ил тод гаргаж тавьсан. Энэний гол зорилго бол алдаа байвал засъя, сайжруулах зүйл байвал цаашдаа сайжруулаад явъя. Их Хурлын зүгээс ард түмэнд ашгийн дийлэнх нь ноогдож байна уу, үгүй юү гэдгийг ил тод болгоод, гэрээний хэлэлцээр дээрээ шинэчлэх үед нь айлын талтай тохиролцоод явъя гэсэн тийм зорилготой байгаа. Тэгээд Батнайрамдал гишүүнд тусгайлан баярлалаа гэж хэлмээр байна.

Энэ тогтоолын төсөл дээр 1.1 дээр 4 дүгээр мөрөн дээр байгаа найруулгын санал хэлмээр байна. Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах гэсэн энэ хэсгийг хасмаар байна. Засгийн газарт тийм эрх байхгүй, Улсын Их Хурлаар л энийг шийддэг. Засгийн газартаа Их Хурал нь өөрөө бидний хийх ёстой ажлыг хий гэж чиглэл өгөх нь буруу. Их Хурал бол Засгийн газрыг хянаж ажиллана, даалгавраа бол өгсөн. Гэхдээ өөрсдийнхөө эрх мэдлийг Засгийн газарт өгдөг ийм өмнөх 76 гишүүнтэй парламент шиг хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал 2 нь хутгалдаад явж байдаг зарчмын ийм алдаатай зүйлийг бид хийж болохгүй.

Тэгэхлээр Их Хурлын бүрэн эрхээ бид өөрсдөө авч үлдээд, энэ 4 дүгээр мөрөнд байгаа хэсгийг маргааш хэлэлцэх Түр хорооны ажлын хэсэг дээрээ та хэд маань заавал тусгаад, нэгдсэн чуулганаар оруулж өгөхийг хүсэж байна. Хэрвээ энэ чигээрээ орж ирвэл би нэгдсэн чуулган дээр энэ тогтоолын төслийг дэмжихгүй.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн, байж байгаарай Бямбацогт гишүүнийг нэмье, Үүрийнтуяа гишүүнийг нэмье.

О.Батнайрамдал: Лувсанжамц гишүүнд баярлалаа. Тэгэхээр Уянга гишүүнтэй яг адилхан санал гэж ойлголоо. Тэгээд бид бүхэн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтэд тусаж байгаа учраас маргаашийн Хянан шалгах түр хорооны хурал дээр бид бүхэн авч үзээд, тэгээд эцэслээд нэгдсэн чуулганд оруулъя. Баярлалаа.

Р.Сэддорж: Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Энэ ОТ төслийг Хянан шалгах түр хорооныхон ажиллаж нийтийн дунд ингээд нээлттэй сонсгол хийсэн та бүхэнд баяр хүргэе. Энэ бол

Монгол төрийн зүгээс хийсэн хамгийн том үйл ажиллагаа болж түүхэнд үлдэх байх гэж бодож байна. Яагаад гэвэл үнэн юмыг үнэнээр нь, худлаа юмыг худлаагаар нь яг сайхан гаргаж өгсөн. Энэ ОТ төсөл манай улсад маш их ашигтай ажиллаж байгаа, татвар их төлж байгаа, амнат, хандив тусламж, цалингийнх гээд ингээд их тийм юм ярьдаг байхгүй юу. Энэ нь байна шүү дээ 3,9 тэрбум доллар. Манай улс энэ 16 жилийн хугацаанд 20 тэрбум долларын өрөнд орсон. Татвар буюу бусад орлого нь 3,9, манай улсын орсон өр нь, хуримтлагдсан өр нь 20 тэрбум доллар. Тэгэхээр энэ бол яаж ч бодсон ашиггүй гэрээ болчихоод байгаа байхгүй юу.

Туркойз Хилл нь энэ төсөлд өгсөн зээлээсээ авсан ашгийг нь би та бүхэнд хэлж өгье. Зээлийн хүүгийн орлогоос 4,2 тэрбум, менежментийн төлбөрийн орлогоос 0,8, зээлийн баталгааны шимтгэл 0,3, бусад зөвлөх үйлчилгээ, цалингийн орлогоос 0,8 гээд нийтдээ 6,1 тэрбум долларын орлого олчихсон байгаа. Эндээсээ бас дахиад энэ төсөлд оруулсан санхүүжилтээсээ 4 тэрбум долларын зээлийн хүүг манайхаар төлүүлсэн. Ингээд 6,1. Нийтдээ эдний ашиг 10,1 шүү. Зөвхөн зээлээс 10,1 тэрбум долларын ашгийг Туркойз Хилл олчихсон байгаа байхгүй юу. Ингээд манай улс 2034 оноос ашиг хүртэнэ гээд байгаа. 37 оноос хүдрийн агууламж нь буурчхаж байгаа юм. Тэгэхээр энэ төсөл анхнаасаа ямар зээл тавих вэ, тэндээс зээлийн хүүгээр бид ямар ашиг олох вэ, ямар үед хүдрийн агууламж буурах вэ гэдгийг маш сайн бодож олсон санхүүгийн луйвар гэдгийг бид ойлгож авсан. Энийг Монголын ард түмэн бүгд ойлгосон байх.

Тэгэхээр Батнайрамдал даргаа ийм л юм асууя. Өмнө нь 2 удаа Улсын Их Хурлын тогтоол гарч байсан 92 дугаар тогтоол, 103 дугаар тогтоол. Энэ дотор дурдсан байна. Одоо дахиад тогтоол гарна. Тогтоол хэрэгждэггүй, энэнд хэн ч хяналт тавьдаггүй. Улсын Их Хурал өнөөдөр тогтоол гаргаад л байна, араас нь ямар ч хяналт тавьдаггүй, ажлын хэсэг байгуулаад л байна, хууль батлаад л байна, ямар ч хяналт байхгүй. Нэг энийг яаж хянах юм бэ?

2 энэ гэрээг байгуулахад худлаа амлаж, энэ гэрээг Монголын ард түмэнд ашигтай гэж тархи угааж батлуулсан хүн хүмүүстээ өнөөдөр ямар хариуцлага тооцох юм бэ? Санжийн Баяр гэж хүн байна, ялаа эдэлчихсэн. Гэхдээ энэ хүн тухайн үедээ өөрийгөө ертөнцийн төв гэж бодоод, Баярцогт энэ хоёр бид хар толгойгоороо хариуцна гэж хэлж байсан байхгүй юу. Одоо тэр хар толгой нь цагаан толгой болчихсон, тэр цагаан толгойгоор ч бид яах юм, Монголын ард түмэн яах юм. Тэгэхээр энэ хүмүүстээ ямар хариуцлага тооцох юм бэ? Үе үеийн Засгийн газар энэ гэрээг.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут, Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Монгол Улс нь, ард түмэн нь алдагдалд ороод байгааг мэдсээр байж байж эс үйлдэхүй гаргасан үе үеийн Засгийн газар, Улсын Их Хурал ямар хариуцлага хүлээх юм бэ? Би хариуцлагын 2 л асуулт асуулаа. Хэрвээ энэ талаар тодорхойгоор хийгээгүй бол өөрсдийнхөө энэ Улсын Их Хурлын тогтоолд та бүхэн ярьж, оруулж тусгаж өгөөч. Бүр тодорхой болгож.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Бидний Хянан шалгах түр хорооны тайланд нэлээн дэлгэрэнгүй туссан байгаа. ОТ төсөл дээр анх хөрөнгө оруулалтын гэрээ хийгдсэнээс хойш хэд хэдэн тогтоолууд гарсан. 92 дугаар тогтоол гарсан, 103 дугаар тогтоол гарсан. Хэрэгжилт нь бас одоо хүртэл

хангалтгүй байгаа. 103 дугаар, 92 дугаар тогтоолоос бүрэн хэрэгжсэн нэг заалт байхгүй. 103 дугаар тогтоолоос бас хэрэгжих шатдаа гээд л явж байгаа.

Тэгэхээр бид бүхэн бодсон л доо. Хэрэгжилтийг хангуулахын тулд дахиад л Улсын Их Хурлаас тогтоол гарлаа, 1 дүгээрт яах вэ хэрэгжилтийг хангах дээр бид ардаас нь хөөцөлдөх ёстой. 2 дугаарт тогтоолын төсөл дээрээ ч тусгаж өгсөн юм л даа. Ямар ч байсан Засгийн газарт өгч байгаа чиглэлдээ 2025 оны, 26 оны намрын ээлжит чуулгандаа саналаа боловсруулаад оруулж ир. Харин энэ хугацаанд улирал тутамдаа яг өнөөдөр бидний энэ ярьж байгаа мэргэжлийн Эдийн засгийн байнгын хороон дээрээ танилцуулаад яв, хэрэгжилтийг бид шаардаж явъя. Энийг Засгийн газарт үүрэг болгож өгье гэж бид тогтоолын төсөлдөө оруулсан байгаа юм.

Ер нь урьд урьдын тогтоолын төслийг харахад ийм заалт ерөөсөө байгаагүй юм байна лээ. Тэгэхээр энэ бол яг манай Хянан шалгах түр хорооны эрхэм гишүүдээс яг гарсан санал л даа. Яг таны энийг бид дотооддоо нэлээн ярьсан. Улирал тутам Эдийн засгийн байнгын хороон дээрээ яг энэ хэрэгжилт нь юу болж байгааг бүгдээрээ Засгийн газарт даалгаад хангаад явъя. Санал боловсруулаад дуусаад, энэ хугацаа дуустал нь хэрэгжилтийг нь хангаад явъя. Тэрнээс цаашаагаа бас бид хэрэгжилтээ шаардаад л явах хэрэгтэй. Улсын Их Хурлын тогтоол болж гарсан бол Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүргээ биелүүлэхгүй бол хариуцлага тооцох механизм байгаа шүү дээ Улсын Их Хуралд.

Та бас 2 дахь асуулт хариуцлага тооцохтой холбоотой асуудлууд ярьж байна. Тэгэхээр энэ Хянан шалгах түр хороо, тэр дундаа үүний хүрээнд явуулсан сонсгол ерөөсөө л энэ 16 жилийн турш ОТ төсөл дээр ямар арга хэмжээ авсан юм, ямар үйлдэхүүнүүд гарсан юм, ямар эс үйлдэхүүнүүд гарсан юм, хэн, юу хийсэн юм энийг хамгийн гол нь нийт иргэд, сонгогчдод бүгдийг нь дэлгэж, дэлгэх ёстой л байсан бодит байдал дээр нь. Олон нийтийн мэдэх эрх хангагдсан, олон нийтийн хүлээлт үүссэн, одоо олон нийт нэг ёсондоо нөгөө талаасаа шаардлагаа тавиад явна гэсэн үг. Энийг холбогдох хуулийн байгууллагууд бүгдээрээ үзсэн байх. Бидэнд ирж байгаа нотлох баримт, мөн сонсголын үеэр хэлсэн хүмүүсийн үг бүгдээрээ нотлох баримтаар үлддэг. Тэгэхээр бид дээр 92 мянган хуудас, цаашлаад 35.../минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хороон дээр 92424 хуудас нотлох баримт 1 дүгээрт, 2 дугаарт 3 өдрийн турш 35 цагийн бичлэг үлдэж байгаа. Энэ бүгдээрээ нотлох баримтаар тооцогдоно гэсэн үг. Тэгэхээр эндээс цаашаагаа холбогдох хуулийн байгууллагууд ажлаа хийх ёстой, Улсын Их Хурал бол ажлаа хийсэн. Мэдэх эрхээр нь хангасан. Харин ажлаа аливаа газар хийхгүй бол олон нийтэд өөрсдөө хариулах хэрэгтэй. Яагаад болохгүй байгаа юм, яагаад хийхгүй байгаа юм, яагаад хариуцлага тооцохгүй байгаа юм. Тэн дээр нь ард түмэн дүн тавих хэрэгтэй гэсэн үг. Баярлалаа.

Р.Сэддорж: Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Хянан шалгах түр хорооныхонд хэр их дарамт ирсэн бэ? Та бүхнийг өмнө нь ингээд хурлаа хийж байхад Рио Тинто буюу Оюу толгойн зүгээс ерөөсөө огт хүмүүс ирдэггүй байсан. Хэд хэдэн удаа шаардлага хүргүүлсэн. Тэгсэн хэр нь сүүлчийн яг тэр сонсгол дээр ирсэн байхгүй юу. Энэ ямар ялгаатай байсан юм бол? Тэгээд та бүхнийг хэр дарамт шахалтад оруулсан бэ? Би хөндлөнгөөс харж

байхад та нарыг нэлээн тийм цухалдуулж, нэлээн дарамтад оруулж байна гэж харсан. Улс болоод ард түмний хохирлыг нэхэмжлэх нь Улсын Ерөнхий прокурор байдаг л даа. Тэгэхээр Улсын Ерөнхий прокурор өнөөдөр юу хийх вэ гэдгийг нийт Монголын ард түмэн харсан, хэвлэл мэдээллийнхэн харсан. Тэгэхээр энэ мөрөөр ямар нэгэн ажил хийхгүй бол хэвлэлийнхэн буюу ард түмэн шахаж шаардах эрхтэй үлдэж байна гэж ойлголоо. Зөв үү?

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хороо бол түр хороо л доо. Тэгэхдээ бид ажил явуулахын тулд Байнгын хороо шиг бараг долоо хоног болгон хуралдсан. 13 удаа хуралдахад бид ОТ компанийн гүйцэтгэх удирдлага ирж танилцуулгаа хийгээч гэж 6 удаа урьсан. Албан тоот ч явуулсан, олон нийтийн хэвлэл мэдээллээр ч гэсэн нээлттэй хэлсэн. 6-ланд нь ирээгүй, ирэхгүй гэдэг шийдвэрийг тэднийх өөрсдөө гаргасан. Тэгээд ямар ч байсан сүүлдээ сонсголд ирсэн.

Мөн сонсголд ирэх, ирэхгүй өөрөө хуулийн зохицуулалттай. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар хэрвээ гэрчээр дуудагдаад, сонсголд хүндэтгэх шалтгаангүйгээр ирэхгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн хариуцлагатай. Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газраас биднийг хариуцаж байгаа ажлын алба байгаа. Энэ ажлын албан дээр хүндэтгэх шалтгаантай хүмүүс хуулийнхаа дагуу материалуудаа бүрдүүлж өгсөн. Хүндэтгэх шалтгааны материал өгөөгүй.../минут дуусав/

Р.Сэддорж: Одоо болсон. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Юуны өмнө сонсголыг зохион байгуулсан Түр хорооны дарга, гишүүддээ Монголын ард түмнийг мэдэх эрхээр нь хангасанд талархлаа илэрхийлье. Улсын Их Хурлын тогтоолын төсөл 4 заалттай. Тогтоолын төсөл дээр заалт болгон дээр асуух зүйл байгаад байна. 1 дүгээр заалт дээр орсон тэр тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр ажиллагаа нь хуульд нийцсэн эсэхийг нягтална гээд байгаа юм. Тэгээд шаардлагатай бол тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авах гээд. Тэгээд энэ өөрөө 2 асуудал дагуулаад байгаа юм л даа. 1 дүгээрт сонсголын явцад хэрвээ хууль зөрчсөн аливаа үйлдэл тогтоогдвол Түр хороо хууль хяналтын байгууллагад шилжүүлэх үүрэгтэй гэж ойлгож байгаа юм тухайн асуудлыг нотлох баримтын хамт. Тэгэхээр яг ийм нөхцөл байдал тогтоогдсон уу?

Үгүй бол хэрвээ шаардлагатай тохиолдолд гэдэг нь ямар тохиолдлоор орж ирж байгаа юм бэ, шаардлагатай тохиолдол сонсголоор гарч ирсэн үү? Яг ингээд үгүй ээ гээд ингээд ороод ирэхээр Засгийн газрын хуулиар хүлээсэн үүрэг нь өөрөө хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Тэгэхээр энэ яг Засгийн газрын дотоод процессыг очиж заагаад байгаа юм шиг Их Хурлаас ийм, ийм ажлаа хий гээд. Тэгэхээр бусад хэсэг нь хаягдаад ч байгаа юм шиг нэг ийм агуулга харагдаад байгаа юм. Тэгээд ер нь бид энэ Улсын Их Хурлаас өгч байгаа үүрэг чиглэл дээр, ялангуяа Улсын Их Хурлын тогтоол дээр Засгийн газрын энэ үндсэн чиг үүрэг рүү, хуулиар хүлээсэн чиг үүрэг рүү айхтар нарийн орохоос илүү, хяналтын механизмаа хэрэгжүүлэх нь бидэнд 1 дүгээрт ач холбогдолтой юм болов уу гэсэн бодол байна. Энэ дээр хариулт өгөөч?

Мөн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулах гээд орхичхож байгаа юм. Санал боловсруулаад цаашаа яах вэ, зүгээр санал

боловсруулаад орхичих юм уу? Энэ нэг л тийм боловсруулалтын хувьд нэг л тийм дутуу харагдаад байгаа юм л даа.

2 дахь заалт дээр гэхэд гэрээний хэрэгжилтийг харилцан дүгнэх, алдагдсан боломжийг тооцоолж дүгнэлт гаргах гэнгүүтээ Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах гээд. Хэрвээ хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргавал энийг засах үүрэг нь Засгийн газрын үүрэг. Хэрвээ энэ дээр засагдахгүй бол Засгийн газарт яг тодорхой асуудлууд дээр нь чиглэл өгмөөр байгаа юм. Яг ямар асуудал дээр гэдэг юм. Нийтлэг ийм зүйл орохоор яг Засгийн үүрэг рүү ороод байх шиг.

3 дахь асуудал дээр үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар хяналтыг сайжруулна гээд байгаа юм. Яг энэ өгүүлбэрийн агуулгыг уншихаар тэгж харагдаад байгаа байхгүй юу. Хар даа, үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар үнэ цэнийг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах гэдэг үг чинь орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр нөөц нэмэгдсэнээрээ хяналт сайжрах юм уу? Ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах гэдэг нь ямар процесс дутуу яваад байгаа юм гээд нэг ийм бүрхэгдүү асуудлууд яваад байх юм.

Мөн Монголын талын үр өгөөжийг 53 хувиас доошгүй байх гээд тодорхой хувь заачихжээ. Энэ хувь ямар үндэслэлтэй гарч ирсэн хувь юм бол? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Нэлээн нухацтай харж асууж байна. Баярлалаа. 1 дүгээрт эхний заалт дээр шаардлагатай, хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн эсэхийг, нийцсэн байдлыг нягтална гэж байгаа. Тэгэхээр Хянан шалгах түр хорооноос бол хууль зөрчсөн гэдгийг тодорхойлдоггүй. Бид хуульд нийцсэн байна уу гэдгийг тодорхойлоод, хууль зөрчсөн гэдгийг улсын байцаагч, эсвэл шүүх тогтоох ёстой. Тэгэхээр бид хуульд нийцсэн эсэх талаар тайлан дүгнэлтээ гаргаад, холбогдох байгууллагуудад бүгдэд нь өгч байгаа. Тэгэхээр бидний энэ дээр хүсэж байгаа зүйл хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг Засгийн газар нягтлаад, арга хэмжээ ав л гэсэн агуулга явж байгаа.

Ашигт малтмал, газрын тосны газар бол яг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгодог, бүх эрх, бүрэн эрх нь тэнд байгаа. Тийм учраас бид энэ дээр шаардлагатай тохиолдол буюу тэр хуульд нийцсэн эсэхээс дүгнэлтээсээ үндэслээд, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл цуцлах хүртэл арга хэмжээ ав гэдэг агуулгыг оруулж ирсэн. Гэхдээ сая 2 ч гишүүн бас энэ агуулгыг хасах саналаа бол дэвшүүлж байна. Тэгэхээр Хянан шалгах түр хорооны маргаашийн хурал дээр бид энийгээ авч үзнэ.

2 дугаарт, тийм бидний шинжээчдийн гаргасан дүгнэлт дээр ер нь ОТ-н орд дээр геологи хайгуулын судалгааг үргэлжлүүлж хийж, үйлдвэрлэлийн нөөцөө өсгөх замаар урдын үнэ цэнийг нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлт гарсан байгаа. Тэгээд бас ТЭЗҮ-тэй холбоотой, дээрээс нь ОТ-н энэ үйл ажиллагаа дээр тавьж байгаа хяналт өөрөө хангалтгүй явж ирснээс үүдсэн олон асуудлууд бол шинжээчид гаргаж ирсэн. Тийм учраас 1 дүгээрт тус ордын үнэ цэнийгээ нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэхийн тулд хайгуул судалгааны ажлаа сайн үргэлжлүүлэн хийж, жишээлбэл С нөөцөө илүү А, В рүү оруулаач. Энүүгээрээ үйлдвэрлэлийн нөөц өсөхөд ОТ-н ордын үнэ цэн 1 дүгээрт өснө.

Тэгээд 2 дугаарт яг энэ ОТ-н ашиглалтын үйл ажиллагаанд бол Уул уурхайн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас бол мэргэжлийн хяналтаа тавих ёстой. Энэ хяналт өөрөө сул явж ирснээс болоод элдэв янзын хуульд нийцээгүй тогтоол, хуульд нийцээгүй даргын тушаалууд хүртэл гарч ирснээр бол сая бидний сонсголоор ил боллоо л доо. Тийм учраас ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналт бол эрс сайжрах хэрэгтэй байгаа юм. Бид зардал хянаж чадахгүй байна гээд л маш олон ярьсан. Тэгэхээр энэ буцаад эргээд л төр өөрөө энэ ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтаа хийж чадаж байгаа юу гэдэгтэй чадамжтай шууд холбож явж байгаа. Тийм учраас энийг бид ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруул гэдэг агуулгаар оруулж ирсэн.

Төгсгөлд нь Монголын талын үр өгөөж хувь хэмжээ 53 гэдэг хаанаас гарч ирсэн бэ гэвэл энэ анх хөрөнгө оруулалтын гэрээ хийгдэхдээ хөрөнгө оруулагч талаас, нэмэлт 1 минут авч болох уу даргаа, хугацаа дуусчихлаа.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн 1 минут.

О.Батнайрамдал: 2009 оны хөрөнгө оруулалтын гэрээ Хөрөнгө оруулагч тал Монголын талтай байгуулахдаа тухайн үедээ урьдчилсан ТЭЗҮ-тэй байсан. ТЭЗҮ дээрээ Монголын талын үр өгөөж 53 хувь байна гэж ТЭЗҮ-дээ тусгаж оруулж ирж байсан. Тэгэхээр нэг ёсондоо анхны амлалт ОТ төсөл хэрэгжсэнээрээ Монголын талд үр өгөөж нь 53 хувь байна гэсэн амлалтыг ТЭЗҮ-ээрээ баталгаажуулж ирснээс хойш энэ огт хэрэгжээгүй явж ирсэн. Тэгэхээр эндээс сая 3 өдрийн сонсголоос үе үеийн 16 жилийн туршид шийдвэр гаргасан бүх хүмүүс хамтдаа цуглаад, эндээс бүгдээрээ нэг зүйл дээр санал нэгдсэн зүйл бол анхны тэр 53 хувийн үр өгөөждөө бид одоо хүртэл хүрээгүй байна. Тэгэхээр анхны өгсөн амлалтдаа зайлшгүй очих ёстой юм байна. Энийгээ бид холбогдох гэрээ контрактад тусгаагүй нь бас алдаа болжээ гэдэг зүйлийг анхны хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хүмүүсээс эхлээд энэ дээр бүгдээрээ санал нэгдсэн. Тийм учраас Хянан шалгах түр хорооны гишүүд бид бүхэн ярилцаад, анхны тэр 53 үр өгөөждөө бид хүрэх ёстой, нөхцөлийг нь баталгаажуулъя. Тэгээд энийгээ албажуулж.../минут дуусав/

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж байгаа гэж байна Түр хороо. Тэгээд хуульд нийцсэн үү, үгүй юү гэдгийг дүгнэлт гаргачхаж байгаа юм бол энэ хуульд нийцсэн үү, үгүй юү гэдгийг нягтал гэж Засгийн газарт үүрэг өгөх нь Түр хорооныхоо ажлыг нягтлуулах гээд байгаа юм шиг ойлголт руу явчихлаа шүү ер нь. Тэгэхээр энийг та бүхэн маань маргааш хуралдах юм байна, үүн дээрээ нэлээн нарийн нягтлаад аваад үзчихээрэй. Эргээд хуульд нийцсэн эсэх дээр дүгнэлт гаргасан бид гэххээд түүнийгээ Засгийн газар нягтал гэдэг нэг л логикийн хувьд уялдаагүй болоод явчихлаа.

Засгийн газарт нэг тийм дүгнэлт гаргах, санал боловсруулах ийм үүрэг чиглэл өгөөд байгаа юм. Тэр хувь эзэмшлийн талаар саналаа боловсруул, тэгээд энэ нөгөө хэрэгжилтийн талаар алдагдсан боломжийг тооцоолж, дүгнэлт гарга гээд тэгээд цааш нь яг яах вэ? Тэгэхээр энэ нэг тийм дутуу юм шиг харагдаад байгаа юм л даа. Хэлэлцээр хийж байгаа үед нь, би 1 минут нэмээд авчих уу, тодруулах 1 минутаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа 1 минут.

Д.Үүрийнтуяа: Хэлэлцээр, Засгийн газар хэлэлцээрт орж байгаа энэ үед Хянан шалгах түр хорооны зүгээс оруулж Их Хурлаар Засгийн газарт үүрэг чиглэл өгөх гэж байгаа бол энэ хэлэлцээрт анхаарах асуудлууд руу нь илүү түлхүү үг, үсэг, зарчмын асуудлуудаа тусгаж оруулаасай гэж хүсэж байгаа юм, боломжтой асуудлууд дээр. Бүүр боломгүй асуудлууд дээр дараагийн шатны арга хэмжээнүүд рүү нь яриад явах нь зүйтэй байх гэж. Тэгэхээр Засгийн газрын дотоод процессын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд оролцохоос илүү Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа чиг үүргийн хүрээнд илрүүлсэн зөрчил дутагдалтай асуудлууддаа тодорхой үүргүүдээ өгөөд, ерөнхий биш, тодорхой асуудлууд дээр үүргийг нь өгөөд, сайжруулах зүйл, заалтаа яриад явбал үр дүнтэй болов уу гэсэн саналтай байна. Тэгээд энэ асуудлууд хэрхэн, яаж орж ирэхээс чуулган дээр дараа нь санал, дүгнэлтээ хэлье гэж бодож байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт.

С.Бямбацогт: Оюу толгойн түр хороо хяналтын сонсголоо хийсэн. Ер нь үр дүнтэй болсон. Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монголын ард түмний мэдэх эрх хангагдсан. Өнгөрсөн хугацаанд энэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсан цагаас хойш, анх гэрээ байгуулахдаа юу гэж ярьж байсан, хувь нийлүүлэгчийн гэрээ хийх үед ямар алдаа гарсан, цаашид 15 онд Дубайн гэрээний үед ямар асуудал үүссэн, мөн 18 онд, 20-иод онд, 21 онд тодорхой ямар асуудлууд шийдэгдсэн гээд бүх зүйл олон нийтийн өмнө ил тод мэдээлэлтэй болсон. Энүүгээрээ үндсэндээ Монголчууд, Монголын ард түмэн, Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газар нэгдмэл ойлголттой, нэгдсэн байр суурьтай, нэг зорилготой болоход үр дүнтэй болсон. Ганцхан чуулган дээр миний хувьд нөгөө тогтоолынхоо төслийг танилцуулаагүй оруулсан нь жоохон бухимдсан. Батнайрамдал гишүүнээс уучлалт хүсье.

Яагаад гэвэл угаасаа өнгөрсөн зунаас хойш л бид бүхэн хамтраад бид нэг тал шүү Засгийн газар, Их Хурал, ард түмэн нэг талдаа, нэг бодлоготой, нэг зорилготой үйл ажиллагаа явуулъя. Их Хурлаас гаргаж байгаа шийдвэр, тушаал бүх юмыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Улсын Их Хурал бол хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага. Засгийн газар бол хууль хэрэгжүүлэх Үндсэн хуулиар хүлээсэн үүрэгтэй институт. Тэгээд энэ хүрээндээ та бүхэн маань гаргаж байгаа тогтоол бидэнд хүч оруулах, дэм болох, энэ Монголын ард түмний хүсэж байгаа, Монголын төрийн хүсэж байгаа анх хөрөнгө оруулагч талын амлаж байсан, ярьж байсан тэр өгөөжид хүрэх энэ талд үр дүнтэй болох ёстой гэж ярьж байсан. Тогтоолын төслийг ерөнхийдөө, түрүүн авсан төслөөс нэлээн өөрчлөгдчихсөн юм байна тийм ээ, ерөнхийдөө агуулгын хувьд дэмжиж байна. Ганц, хоёр нэмэх, өөрчлөх санал байвал дахиад өгье.

Гэхдээ энд гишүүнийхээ хувьд байр сууриа илэрхийлж байгаа шүү. Та зөв ойлгоорой та бүхэн. Мэдээж албан ёсоор Улсын Их Хурлаас баталж өгөх тогтоолыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгээд дэм болчих болов уу гэж бодож байгаа. Энэ дээр шаардлагатай тохиолдолд гэдэг үг бол тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах гэдэг үг байх ёстой байх. Бидэнд нэг тийм ташуур хэрэгтэй. Хөрөнгө оруулагч талдаа Улсын Их Хурлаас төрийн хууль тогтоох дээд байгууллагаас ийм үүрэг чиглэл өгсөн, энд хүрэх ёстой, анхнаасаа та бүхэн, бид бүхэн ярьж байсан Монголын талын хүртэх өгөөж 53 хувьд хүрэх. Энэ хүрч байж үндсэндээ хэлэлцээрт өөрчлөлт орвол энд хүрч байж үндсэндээ асуудал одоо боллоо гэж тогтох ёстой. Тийм болохоор сүүлийн заалтыг 53 хувьд хүргэх гээд, хүргэсэн эсэхээ буцааж тайлагнах, хүргэхийн төлөө шаардлагатай бол Улсын Их

Хурлаас дахиад дэмжлэг авах гэсэн хүч нэмсэн заалтууд бидэнд оруулаад өгөөч. Энэ бидэнд хэрэгтэй. Яагаад гэвэл бид Улсын.../минут дуусав/

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Бямбацогт сайдад баярлалаа. Засгийн газраас хэлэлцээрт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хувьд идэвхтэй оролцоод явж байгаа. Өмнө нь ч гэсэн яг таны өрөөнд холбогдох сайдууд бүгдээрээ байгаад, ажлын хэсэг бүгдээрээ ирж уулзаж байсан. Тэгэхээр Хянан шалгах түр хороон дээр манай гишүүд ч гэсэн бүгд санал нэгдэж байгаа. Бид энийг маш олон удаа хэлсэн. Ганцхан Монгол Улсын эрх ашиг гэсэн ганцхан эрх ашиг л байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал ч бай, Засгийн газар ч бай бид бүгдээрээ Монгол Улсын эрх ашигт үйлчилж байгаа субъектүүд. Тэгэхээр бид Монгол Улсын эрх ашиг дээр баттай хамтдаа зогсоно.

Анх Хянан шалгах түр хороог бид байгуулж байхад бол хэлэлцээр эхлээгүй байсан. Тэр үед гэхдээ бид Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор Хянан шалгах түр хороо байгуулчихсан байсан. Засгийн газар дараа нь хэлэлцээрт ороод явахад бид ерөөсөө л Засгийн газар хэлэлцээрт амжилт гаргах эсэхээс бүх зүйл хамаарах учраас бид бүх талаараа энэ тогтоолоороо ч гэсэн дэмжиж байгаа гэж бид бүхэн бүгд байр суурь нэгтэй байгаа. Энэ тогтоол яг хэлэлцээрийн дундуур гарч таарлаа цаг хугацааны хувьд. Гэхдээ энэ нь Засгийн газарт хэлэлцээрт ороход илүү дөхөм болж, илүү тус болж явна гэдэгт итгэлтэй байгаа.

Тэгээд Засгийн газарт бид бүхний зүгээс ч гэсэн хэлэлцээртээ амжилттай явах тал дээр бүх талаар цаашдаа тусалж явах болно, дэмжиж явах болно, хэрэгжилтийг бас шаардаж явах болно. Тэгээд хамтдаа Монгол Улсын эрх ашгийн төлөө 16 жил жилийн дараа шийдэл гаргаад, ОТ төсөл дээр нэг шинэ эрин эхлээсэй гэж Хянан шалгах түр хорооны гишүүд бид бүгдээрээ санал нэгтэй байгаа. Монголын нийт иргэд ч гэсэн тийм зүйл хүсэж байгаа болов уу гэж бодож байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Түр хорооны даргаас нэг юм хүсье. Энэ усны, гүний ус ашиглаж байгаа ОТ төсөл. Гүний усыг, гадаргын усыг ялангуяа Хэрлэн тоонот усыг төслийг говь руу аваачих талаар техник, эдийн засгийн үндэслэлийг ОТ компани санхүүжилт хийж байгаа 3 сая доллар байна уу. Тэрэнд сайшаагаад, тэгээд энэ гадаргын усыг яаралтай хэрэглэхийг эрмэлзэх, энэ дээр яаралтай шийд гаргаж тэр толгой группээрээ гүний усыг хойч үед үлдээх талаар ажлын хэсэг юу Түр хорооны дарга та ганц өгүүлбэр ч гэсэн оруулж өгөөч.

Энэ бол говийн ард түмэнд хамгийн нөхөхгүй баялаг бол ус байхгүй юу. Усыг хэрэглэж баяжуулсан баяжмалаа гадагшаа экспортолж байгаа шүү дээ. Тэгээд ийм хүсэлтийг та бүхэн маань нэг маргааш Байнгын хороон дээрээ, юун дээрээ ажлын хэсгийн хурал дээрээ, Түр хорооны хурал дээрээ ярьж өгөөч гэдэг ийм хүсэлттэй байна. Тэгээд энэ чинь үг байхгүй гэж байгаа юм, асуулт байгаа гэж байгаа юм. Тэгэхээр та нэг хариулах уу? Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Сэддорж дарга ОТ төслийн хувьд чухал асуудлыг хөндөж байна л даа усны асуудал. Цаашдаа ОТ төсөл 30, 40, 50, 60 жил явна. Тэгэхээр усны асуудлаа бол урт хугацаандаа шийдэх нь зөв. Манай Хянан шалгах түр хорооны хувьд Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор байгуулагдсан. Тэгэхээр Улсын Их Хурлаас нэг ёсондоо бидэнд тогтоолоор чиглэл өгсөн гэсэн үг Хянан

шалгах түр хороонд. Манай нэршил бол Оюу толгой төсөл дээр Монгол Улсын эрх ашгийг хангуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх. Бас хүрээ хязгаартай. Хүрээ хязгаар бол Онтрэ-тэй холбоотой асуудлууд шийдвэрлэх, төрийн эзэмшлийн хувь хэмжээг ойлгомжтой болгох, 2 дугаарт зээлийн хүүг бууруулах болон зээлийн хүүтэй холбоотой санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх гэж орсон байгаа юм.

Тэгэхээр нөгөө талаасаа бид бүхэн ОТ дээр асуудал яривал маш олон асуудлууд байгаа. Тэгэхээр асуудал болгоныг бид авч үзье гэхээр яг Улсын Их Хурлаас өгсөн хүрээ хязгаар тогтоолоор өгөгдсөн учраас бид тогтоолоор олгосон үүргийнхээ хүрээнд энэ тогтоолын төслийг боловсруулах ёстой юм. Энэ тогтоолын төсөл бол яг бидний хүрээ хязгаарын хүрээнд боловсруулсан бараг 400 хуудас тайлан, дүгнэлт дээр үндэслэж гарч байгаа юм. Тэгэхээр бид хүрээ хязгаарынхаа хүрээнд хуулийн дагуу ажиллах ёстой байгаа. Гэхдээ би таны санал, дүгнэлтэд орж байгаа учраас Хянан шалгах түр хороон дээр, Хянан шалгах түр хорооны хурал дээр танилцуулагдах болно. Баярлалаа.

Р.Сэддорж: Ойлголоо. Энэ Оюу толгойн төсөл усгүй бол ерөөсөө явахгүй. Ус, усгүй бол ерөөсөө явахгүй. Тийм учраас хамгийн чухал нь ус байхгүй юу, усгүй бол ямар ч төмөр зам, 1 дүгээрт ус тэр төсөлд хэрэгтэй юм. Тэгээд энийг та бүхэн энэ эрэмбэлэх, энэ эрэмбэлэх ажил дээрээ бодолцохгүй бол 1 дүгээрт ус. Тэгээд л тэрний дараа тэр хил гааль, тээвэрлэх барих, баяжуулах, баяжуулна гэдэг чинь ерөөсөө л ус. Тэгээд энэ дээр та нэг ядаж нэг өгүүлбэр оруулах хэрэгтэй л гэж бодож байна л даа. Тэгээд энийг би 20 гаруй жил ярьсан хүний хувьд, 20 гаруй жил ярьж байна шүү дээ 2004 оноос хойш.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах гишүүд Түр хорооны хурал дээрээ хэлэлцэхээр саналаа хэлсэн тул тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хянан шалгах түр хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жаргалан уншиж танилцуулна.

18.16 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Ажлын албаныханд баярлалаа, гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА